

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 9 сарын 29-ний өдрийн 95 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ГАЗАР
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБА

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОТЬ 4-1
ЕРӨНХИЙ ХЭСЭГ

ГҮЙЦЭТГЭГЧ: ГАЗАР ДЭЛХИЙ ХХК
ГЕОБОТАНИК ХХК

ГАЗАР ДЭЛХИЙ ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



Г.Намсрай

ГЕОБОТАНИК ХХК-ийн
Захирал



Д.Цэвэгмэд

2022 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

А	АА	Аж ахуй
	ААН	Аж ахуйн нэгж
	ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
	АДХГЗ	Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа
	АИХ	Ардын их хурал
Б	ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний систем
	БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
	БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
	БНБД	Барилгын норм ба дүрэм
	БОАЖЯ	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
	БОНХЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам (Хуучин нэр)
	БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
Г	ГА	Газар ашиглалт
	ГАТБҮ	Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ
	ГЗБ	Газар зохион байгуулалт
	ГЗБЕТ	Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
	ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
	ГК	Газрын кадастр
	ГНСТ	Газрын нэгдмэл сангийн тайлан
	ГНС	Газрын нэгдмэл сан
	ГХГЗЗГ	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар (Хуучин нэр)
Д	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
	ДБ	Дэлхийн банк
	ДЦС	Дулааны цахилгаан станц
Е	ЕТ	Ерөнхий төлөвлөгөө
З	ЗЗНДН	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж
	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
	ЗГ	Засгийн газар
И	ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
М	МУ	Монгол Улс
	МАА	Мал аж ахуй
О	ОХУ	Оросын Холбооны Улс
С	САА	Сангийн аж ахуй
	СЯ	Сангийн яам
Т	ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
	ТХЭГ	Тусгай хэрэгцээний газар
	ТХГ	Тусгай хамгаалалттай газар
	ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
У	УГЗБХЗТИнститут	Улсын газар зохион байгуулалт хайгуул зураг төслийн институт
	УГЗБЕТ	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
	УИХ	Улсын Их Хурал
	УЦС	Усан цахилгаан станц
	УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
Ү	ҮНО	Үндэсний нийт орлого
	ҮСХ	Үндэсний статистикийн хороо
Х	ХАА	Хөдөө аж ахуй
	ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
	ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
Ц	ЦС	Цахилгаан станц
Ш	ШУА	Шинжлэх ухааны академи
Э	ЭХЭУБ	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
	ЭҮТ	Экосистемийн үйлчилгээний төлбөр

ГАРЧИГ

Оршил.....	5
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ НЭГ. НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ХЭСЭГ.....	6
1.1. Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний агуулга, арга зүй, зорилго, зарчим, стратегийн зорилт, шийдвэрлэх үндсэн асуудлууд.....	6
1.1.1. Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний агуулга.....	6
1.1.2. Нийслэлийн ГЗБЕТ боловсруулахад баримталсан зарим, стратегийн зорилт .	9
1.1.2.1. Хууль, эрх зүйн зарчмууд.....	9
1.1.2.2. Мэргэжил арга зүйн дараах суурь зарчмууд.....	11
1.1.2.3. Нийслэлийн ГЗБЕТ-ний стратегийн зорилт.	13
1.2. Нийслэлийн нутаг дэвсгэрийн гзбет боловсруулах үзэл баримтлал.....	13
1.2.1. Суурь үзэл баримтлалууд.....	14
1.2.2. Газар зохион байгуулалтын мэргэжил арга зүйн үзэл баримтлал.....	16
1.2.3. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэг зөрчил, түүнд хариуцлага тооцох, газрын маргааныг бууруулахад чиглэсэн хууль дээдлэх, газрын засаглалыг сайжруулах үзэл баримтлал:.....	19
1.2.4. Нийслэлийн ГЗБЕТ-ний хүрээнд газар нутгийн хамгаалал, байгаль орчин-экологийн аюул, эрсдэлгүй, тэнцвэртэй байдалд хүрэх үзэл баримтлал:.....	20
1.2.5. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм, эдийн засгийн бодлого, зорилтын үзэл баримтлал.....	21
1.3. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн газрын нэгдмэл сангийн удирдлага, бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох шийдвэрлэх асуудлын чиглэл.....	23
1.3.1. Нийслэлийн ГЗБЕТ-ний цогцолбор арга хэмжээний ерөнхий чиглэл.....	23
1.3.2. Улсын хөгжлийн бодлого хөтөлбөртэй уялдуулах НГЗБЕТ-нд тусгах үндсэн чиглэл.....	26
1.3.2.1. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм, эдийн засгийн бодлого, зорилт, арга хэмжээний чиглэл.....	26
1.3.2.2. Нийслэлийн ГЗБЕТ-ний хүрээнд газар нутгийн хамгаалал, байгаль орчин-экологийн аюул, эрсдэлгүй, тэнцвэртэй байдлыг хангах зорилт, арга хэмжээний чиглэл.	28
1.3.2.3. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм, эдийн засгийн бодлого, зорилт, арга хэмжээний чиглэл.....	29
1.3.2.4. Газар ашиглалтын бүтцийн өөрчлөлт хийж хэт төвлөрлийг бууруулах, замын түгжрэлийг багасгах газар ашиглалтын зориулалт, салбаруудын болон аж ахуйн төрөлжилтийг оновчтой тогтоож байршуулах зорилт, арга хэмжээний чиглэл.....	30
1.4. Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах байгаль хамгаалал, нийгэм, эдийн засгийн хэрэгцээт байдлын төсөөлөл.....	33
1.5. Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөл, нөөцөд суурилсан Нийслэлийн газар нутгийн ялгарал ГЗБЕТ-ийн шийдлийн суурь үндэслэл.....	47
1.6. Нийслэлийн нутаг дэвсгэр, газрын нэгдмэл сангийн ашиглалт, хамгаалалт, нийгэм, ахуй соёл, газрын засаглалын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн СВОТ шинжилгээ.....	87
1.7. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж газрын ухаалаг засаглалын бодлого, төлөвлөлт.....	89
1.7.1. Газрын засаглалыг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шийдэл.	89
1.7.2. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм-экологийн бодлого төлөвлөлт.....	94
1.7.3. Нийслэлийн ГЗБЕТ-ний газар ашиглалтын экологи-эдийн засгийн бодлого төлөвлөлтийн шийдэл.....	96
1.8. Нийслэлийн ГЗБЕТ-ыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулсан бодлого, шийдэл.....	97
1.8.1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийслэлийн ГЗБЕТ-г уялдуулах үндэслэл, агуулга, хандлага, бодлого төлөвлөлт шийдэл.....	97
1.8.1.1. Нийслэлийн ГЗБЕТ-г бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн үндэслэл.....	97

1.8.1.2. Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн онол-арга зүйн үндэслэлийг тодорхойлсон байдал.....	98
1.8.1.3. Нийслэлийн ГЗБЕТ-г бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулсан бодлого, шийдэл.....	99
1.8.2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх стратеги, нутаг дэвсгэрийн болон үйлдвэрлэл технологийн кластерийн ГЗБЕТ, схем.....	101
1.8.3. Нутаг дэвсгэр, газар ашиглалтад суурилсан нутаг дэвсгэрийн болон үйлдвэрлэл-технологийн кластер үүсгэх шийдлийн үндсэн чиглэл.....	101
1.8.4. Нийслэлтэй эрчимтэй таталцал нөлөөллийн бүсэд үйлдвэрлэл-технологийн кластер үүсгэх шийдэл.....	103
1.8.5. Нийслэл УБ хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, хилийн цэсийн өөрчлөлтийн төлөвлөлтийн шийдэл.....	113
1.9. Газрын нэгдмэл сангийн ангилал төлөвлөлт.....	125

Зургийн жагсаалт

Зураг 1. Газрын тухай хуулийн 25.1.5-д заасны дагуу улсын ГЗБЕТ-г дараа шатны төлөвлөлтөөр хэрэгжүүлэх суурь зарчмын схем.....	12
Зураг 2. Тогтвортой хөгжлийн схем зураг.....	19
Зураг 3. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойргийн зураг.....	47
Зураг 4. Нийслэлийн нутаг дэвсгэрийн ландшафт, газар нутаг, урочишийн фон зураг.....	50
Зураг 5. Дүүргүүдийн Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойрог дахь нутаг дэвсгэрийн ялгарлууд.....	52
Зураг 6. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал.....	100
Зураг 7. Нийслэлийн таталцал нөлөөллийн бүсийн үнэлгээний зураглал.....	104
Зураг 8. Нийслэл болон Нийслэлтэй эрчимтэй таталцал нөлөөллийн бүсэд буй аймаг сумтай ХАА-н үйлдвэрлэлийн кластер үүсгэх тогтвортой ногоон хөгжлийн загвар схем.....	112
Зураг 9. Дүүргийн хүн амын байршил, хуваарилалтын байдал.....	113
Зураг 10. Дүүргүүдийн нутаг дэвсгэрийн орон зайн үнэлгээ /дүүргүүдийн хилээр/.....	116
Зураг 11. Дүүргүүдийн нутаг дэвсгэрийн орон зайн үнэлгээ /хороогоор/.....	122
Зураг 12. Нийслэлийн ГНС-н үндсэн ангилал.....	125
Зураг 13. Нийслэлийн газрын нэгдмэл сангийн ангилалын өөрчлөлт.....	125
Зураг 14. ГНС-ын үндсэн ангиллын зураг /2036 онд/.....	126

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Мэргэжил, арга зүйн дараах үзэл баримтлал.....	17
Хүснэгт 2. Газар ашиглалтын нийгэм, эдийн засгийн хөгжил, геоэкологийн доройтлыг бууруулж, газрыг хамгаалах, нөхөн сэргээж хүний амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх хүний амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэгцээ.....	33
Хүснэгт 3. Ангиллын түвшин ба зарчим.....	48
Хүснэгт 4. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойрог дахь нутаг дэвсгэрийн ялгарлууд.....	50
Хүснэгт 5. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойрог дахь газар нутгийн ялгарлууд, тэдгээрийн онцлог, Газар ашиглалтад тавигдах ерөнхий нөхцөл, шаардлага, хязгаарлалт.....	54
Хүснэгт 6. Нийслэлийн нутаг дэвсгэр, газрын нэгдмэл сангийн төрийн удирдлага, төлөвлөлт, хот байгуулалт, төлөвлөлтийн өнөөгийн байдалд хийсэн SWOT шинжилгээ.....	87
Хүснэгт 7. Улаанбаатар хотын геоэкологи, хүрээлэн буй орчны өнөөгийн нөхцөл байдалд хийсэн SWOT шинжилгээ.....	88
Хүснэгт 8. Газрын засаглалыг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шийдэл.....	91
Хүснэгт 9. Нийслэлийн ГЗБЕТ-ний суурьшлын бүсийн газрын нийгэм-экологийн бодлогын шийдэл.....	94
Хүснэгт 10. Нийслэлийн ГЗБЕТ-ний газар ашиглалтын экологи-эдийн засгийн бодлогын шийдэл.....	96
Хүснэгт 11. Нийслэлийн ГЗБЕТ-г бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэх бодлого, шийдэл.....	102
Хүснэгт 12. Нийслэлийн таталцал нөлөөллийн бүс дэх аймаг сумууд.....	103
Хүснэгт 13. Таталцал нөлөөллийн 1-р бүс дэх аймаг, сумдын үзүүлэлтүүд.....	105
Хүснэгт 14. Таталцал нөлөөллийн 2-р бүс дэх аймаг, сумдын үзүүлэлтүүд.....	106

Хүснэгт 15.	Таталцал нөлөөллийн 3-р бүс дэх аймаг, сумдын үзүүлэлтүүд	108
Хүснэгт 16.	Таталцал нөлөөллийн бүсүүдийн үнэлгээний нэгтгэл, хэрэгжүүлэх үйл ажиллагаа 109	
Хүснэгт 17.	Нийслэл болон Нийслэлтэй эрчимтэй таталцал нөлөөллийн бүсэд буй аймаг сумтай үйлдвэрлэлийн кластер үүсгэх загвар схем	112
Хүснэгт 18.	Нутаг дэвсгэрийн орон зайн хүчин зүйлийн үнэлгээ /дүүргүүдийн хилээр/	115
Хүснэгт 19.	Дүүргүүдийн нутаг дэвсгэрийн орон зайн үнэлгээ /Хороогоор/	117
Хүснэгт 20.	Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал /2036 онд/	126

ОРШИЛ

Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үндсэн зорилго нь Нийслэлийн хэмжээнд болон дүүргүүдийн нутаг дэвсгэрийн хил хязгаарын доторх байгаль газарзүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхыг үнэлсний үндсэн дээр тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрыг оновчтой, үр ашигтай эзэмших, ашиглах, хамгаалах, үр өгөөжийг нь сайжруулах бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх арга хэмжээний менежментийг эрх зүй, шинжлэх ухааны үндэслэлтэй, төлөвлөлтөөр дэмжиж, газар эзэмшигч, ашиглагчдын эрх зүйн баталгааг хангаж, газрын кадастрыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Газар дэлхий ХХК, Геоботаник ХХК-ийн түншлэлийн хооронд 2020 оны 8 дугаар сарын 14-ны өдөр байгуулсан НХААГ/202001278/02/02 дугаар бүхий зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээ болон гэрээний хавсралт болох ажлын даалгавар, ажил гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

МУ-н газрын тухай хуулийн 25.2-т Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль, газар зүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхад зохицсон газрын менежментийн бодлогоор улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 16-20 жилийн хэтийн чиглэлийн баримжаатай зураг төслийн баримт бичиг байна гэж заасан ба 25.3-т Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь **энэ хуулийн 25.2-т заасан хүрээнд** боловсрогдсон 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна гэж заасан байдаг. Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаварт 2021-2036 онд хүртэлх хугацаанд 3-н үе шаттайгаар хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг байхаар тусгасан.

Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний суурь үзэл баримтлал, үндсэн чиглэл, МУ-н хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан бүс нутгийг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийн шийдлийг “ЕРӨНХИЙ ХЭСЭГ” буюу 1-р ботид тусгав.

**БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ НЭГ. НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ХЭСЭГ**

**1.1. НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА, АРГА ЗҮЙ, ЗОРИЛГО, ЗАРЧИМ, СТРАТЕГИЙН
ЗОРИЛТ, ШИЙДВЭРЛЭХ ҮНДСЭН АСУУДЛУУД**

**1.1.1. Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний
агуулга**

Газар бол нийгмийн үнэлж баршгүй, юугаар ч орлуулшгүй баялаг юм. Энэ бол байгалийн гол баялаг, хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны материаллаг нөхцөл, орон зай, үндэсний эдийн засгийн бүх салбарын байршил, хөгжлийн үндэс суурь, үл хөдлөх эд хөрөнгө, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол хэрэгсэл, хүчин зүйл, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол эх үүсвэр зэрэг үүрэг гүйцэтгэдэг юм. Тиймээс газар нутгийг зохистой ашиглах, хамгаалах ажлыг зохион байгуулах, зүй зохистой төлөвлөх нь ард иргэдийн оршин байх, сайн сайхан амьдрах, амьдралын чанарыг дээшлүүлэх, улс, бүс нутаг, орон нутгийн хөгжлийг хангах хамгийн чухал суурь нөхцөл юм. Энэ утгаараа газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь хот байгуулах, хөдөө, ой, усны аж ахуйн хөгжүүлэх, үйлдвэр аж ахуйн салбарыг оновчтой байршуулах, төрөлжүүлэн хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн суурь харилцааг зохицуулах үүрэгтэй байдаг.

Зах зээлийн нийгэмд газрын гүйцэтгэх үүрэг, ашигт чанараар нь ангилал, зориулалтыг тогтоож дараах чиглэлээр эргэлтэд оруулж ашигладаг.

- 1. Үл хөдлөх хөрөнгийн*
- 2. Байгалийн нөөцийн*
- 3. Хүний амьдрах, үйлдвэр, үйлчилгээ, аж ахуйн салбарын орон зай, байршлын*
- 4. Экосистемийн үйлчилгээний*
- 5. Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх өвийг хадгалан тээгчийн*

Нийслэлийн Газар зохион байгуулалтын зураг төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага, хөгжлийн бодлого төлөвлөлтийн одоогийн болон алс хэтийн зорилго, зорилт, стратегийн хүрээнд шийдвэрлэх тулгамдсан асуудлыг одоо хэрэгжиж газар зохион байгуулалтын болон нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, төсөл боловсруулах, үндэслэл, арга зүй, газар ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбоотой ажлын зураг төсөл, улс, нийслэл, бүс нутгийн онцлог, хөгжлийн чиг хандлага, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн зураг төслөөр тусгайлан зохицуулах асуудал зэргийг нэгдмэл системд авч үздэг ойлголт зарчмыг баримтлах шаардлагатай байна. Үүний зэрэгцээ онол, арга зүй, нэр томъёоны ойлголт, залгамж чанарыг хадгалахын зэрэгцээ, орчин үеийн шинэ ойлголт, эрх зүйн харилцааны ойлголт, хандлагыг нэмж оруулах, практик дээр өөрсдийгөө нотолсон уламжлалт болон орчин үеийн дизайн загварчлалын аргуудыг

нарийвчлан тайлбарлаж, хууль эрх зүйн үндэслэл сайтай боловсруулах хэрэгцээ шаардлага гарч байна.

Иймд газар зохион байгуулалтын төлөвлөлтийн системийн платформ нь мэргэжил, арга зүйн талаасаа инженер-эдийн засгийн болон байгаль орчны инженерчлэлийн агуулга дээр суурилна. Платформ нь орон зайн хувьд нутаг дэвсгэрийн, газрын өмч, үл хөдлөх эд хөрөнгийн эрх түүнд суурилсан бусад эрхийн төрлүүд, газрын гүйцэтгэх үүрэг, ашигт чанарт суурилсан экологи-эдийн засгийн агуулгыг багтаасан блок-моделийн дизайн загвартай байх юм.

Хот гэх суурь ойлголтод хотын аж ахуйн болон эдийн засгийн хөгжлийн иж бүрдэл, хүн амын амьдралын чанар, нийтлэг эрх ашгийг хангах газар ашиглалт, төлөвлөлтөд суурилсан архитектурын болон инженерийн дэд бүтцийн хангамжийг сүлжээ, төвлөрөл, капиталыг хуримтлал хамаарч байна.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийг чадварлаг төлөвлөж ашигласнаар л тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн үр ашгийн шалгуур үзүүлэлт, гадаад өнгө төрх, дизайн загвар, үзэмжийг хангах төдийгүй тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эдийн засгийн үзүүлэлт, үр ашгийг дээшлүүлж чадна.

Дээр дурдсанаар нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн баримт бичгийн бодлого, агуулга, хамрах асуудлыг Газрын тухай хуулийн 25.2.-т "Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль, газар зүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхад зохицсон газрын менежментийн бодлогоор улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 16-20 жилийн хэтийн чиглэлийн баримжаатай зураг төслийн баримт бичиг байна.", 25.3.-т "Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь энэ хуулийн 25.2-т заасан хүрээнд боловсрогдсон 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна." гэж тус тус тодорхойлж өгсний дагуу төлөвлөв.

Газрын харилцааны хууль эрх зүйн агуулга

Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль эдгээр хуульд нийцүүлэн гаргасан бусад хууль, эрх зүйн актын хүрээнд Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын өмчийн болон дараах бусад эрхийн төрлүүдийн агуулгаар төлөвлөнө. Үүнд:

Газрын нийтийн өмчийн эрхийг эзэмшигч нь төр, иргэний өмчийн эрхийг эзэмшигч нь Монгол улсын иргэн байна.

Төр нь нийтийн өмчийн эрх зүйн агуулгаар газар өмчлөгч байна.

Монгол улсын иргэн нь хувийн эрх зүйн агуулгаар газар өмчлөгч байна.

Газрын өмчийн эрхээс үүсэх дараах агуулга бүхий эрхийн төрлүүд байна.

1. Бусдын газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглах эрх буюу газрын узуфрукт эрх;

2. Бусад этгээдийн газар дээр барилга байгууламж барих эрх;
3. Дундын өмчийн эд хөрөнгийн эрхээс үүссэн газрын эрх (СӨХ газар болон түүнтэй адилтгах дундын өмчийн барилга, байгууламжийг өмчлөх эрхээс үүсэх газрын эрх, кондоминиум эрх);
4. Дайран өнгөрөх, нэвтэрч гарах сервитут эрх;
5. Зан заншлын эрхээр бэлчээрийн газрыг уламжлалт мал ахуйн зориулалтаар нийтээр дундаа болон хэсгээр дундаа өвлүүлэх эрхтэйгээр ашиглах эрх;
6. Ашгийн төлөө бус зорилгоор газар эзэмших, ашиглах
7. Захиргааны гэрээгээр ашиглах эрх, (түрээсийн гэрээ, төрийн тодорхой үүрэг гүйцэтгэх гэх мэт)

Нийслэлийн ГЗБЕТ-ийн ногоон хөгжлийн агуулга:

Нийслэлийн ГЗБЕТ-г ногоон хөгжлийн бодлогын дараах ойлголтод нийцүүлж төлөвлөв.

-“ногоон хот” гэж эрчим хүч, дулаан, ус хангамж, харилцаа холбоо, нийтийн тээврийн ухаалаг дэд бүтэц, хог хаягдлын оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан хот сууриныг;

-“ногоон хөгжил” гэж байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, нийгмийн оролцоог хангаж ядуурлыг бууруулах хөгжлийн загварыг

-“ногоон эдийн засаг” гэж байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг

-“ногоон өсөлт” гэж хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалах, нийгмийн оролцоог дэмжих, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн өсөлтийг;

-“ногоон үйлдвэрлэл” гэж эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг;

-“экосистемийн үйлчилгээний төлбөр” гэж экосистемийн үйлчилгээг хүртэгч болон уг үйлчилгээг тогтвортой хадгалахад хувь нэмрээ оруулагчийн хооронд бий болгох төлбөрийн зохицуулалтын механизмыг.

Амьдралын чанарыг сайжруулах ойлголтын агуулга:

1. Хоол хүнсний аюулгүй чанартай хэрэглээ, хангамж,
2. Нийтийн орон сууц, гэр, хувийн сууцны тав тухтай чанарлаг, тансаг байдал, инженерийн дэд бүтцийн хангамж үйлчилгээ
3. Төрийн тэгш, шударга, шуурхай үйлчилгээ

4. Чанартай эрүүл мэндийн үйлчилгээ, амрах, сувилах, эрүүлжих орчны хангамж, боломж
5. Чанартай боловсрол, сурч хөгжих таатай орчин
6. Шилжилт хөдөлгөөн, нутагшил, суурьшилтын таатай орчин
7. Байгаль орчны хамгаалал, хүрээлэн буй орчны аюулгүй байдал,
8. Газар бусад үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө олж авах, аж ахуй эрхлэх эрхийн баталгаа, найдвартай байдал
9. Хувь хүн, гэр бүлийн аз жаргал, үнэ цэнэ, нэр төр, сэтгэл ханамж
10. Хувь хүний эд хөрөнгө, хогшил, хотын соёл, хувцаслалтын үзэмж, гоо зүй, чанартай ухаалаг хэрэглээ
11. Амьдралын хэрэгцээг хангасан цалин хөлс, ажлын байрны хангамж, нөхцөл, бүтээмж

Нийслэлийн ГЗБЕТ-ний алсын хараа: Газрын чадавх нөөц, нэгдмэл санг үр ашигтай зүй зохистой ашиглан, тогтвортой болон ногоон хөгжлийн зарчмаар нийслэлийн хэмжээнд “Алсын хараа-2050”-ийн зорилго, зорилтыг газрын менежментийн бодлого, төлөвлөлтөөр дэмжин хүний амьдралын чанарыг сайжруулах, эрүүл аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Нийслэлийн ГЗБЕТ-ний зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдалд нийцүүлэн 2021-2036 оны хугацаанд хэрэгжүүлэх газрын бодлогыг хэрэгжүүлэх, нэгдмэл сангийн удирдах, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, газрыг зүй зохистой, үр ашигтай, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх цогцолбор арга хэмжээний зураг төслийн баримт бичгийг боловсруулахад оршино.

1.1.2. Нийслэлийн ГЗБЕТ боловсруулахад баримталсан зарим, стратегийн зорилт

1.1.2.1. Хууль, эрх зүйн зарчмууд

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим.

Нэгдүгээр зүйл.2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд заасан зарчим:

4 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчим

4.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дараах үндсэн зарчмыг баримтална:

- 4.1.1.улс, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх;
- 4.1.2.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- 4.1.3.хууль дээдлэх;

- 4.1.4. нэгдмэл, харилцан уялдуулан зохицуулагдсан байх;
- 4.1.5. шуурхай, тасралтгүй байх;
- 4.1.6. бодит мэдээлэлд үндэслэх;
- 4.1.7. төрийн байгууллага, иргэд харилцан хариуцлага хүлээх;
- 4.1.8. үндэсний эв нэгдлийг эрхэмлэх;
- 4.1.9. нээлттэй байх.

Газрын тухай хуульд заасан зарчим

4 дүгээр зүйл. Төрөөс газрын талаар баримтлах зарчим:

4.1. Төрөөс газрын талаар дараах зарчмыг баримтална:

- 4.1.1. Монгол Улсын газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх;
- 4.1.2. газар төрийн хяналт, хамгаалалтад байх;
- 4.1.3. газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;
- 4.1.4. газрыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу үндсэн зориулалтаар нь үр ашигтай, зохистой эзэмших, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;
- 4.1.5. хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх.
- 4.1.6. газар зохион байгуулалтын төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах.
- 4.1.7. газар дээрх үл хөдлөх хөрөнгө нь тухайн газрын бүрдэл хэсэг байх.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль

7 дугаар зүйл. Удирдлагын үйл ажиллагааны үндсэн зарчим

1. Нийслэлийн удирдлага нь зохион байгуулалт, үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндсэн зарчмыг баримтална.

2. Нийслэлийн удирдлагаас чиг үүргээ хэрэгжүүлэхдээ оршин суугчдынхаа хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэнэ.

3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, засаг дарга, үйл ажиллагаандаа иргэдийн санал бодол, нутаг дэвсгэртээ ажиллаж буй төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, сүм хийд, буяны болон сайн санааны байгууллага, олон түмний идэвх оролцоонд тулгуурлах зарчмыг баримтална.

Хот байгуулалтын тухай хууль

4 дүгээр зүйл. Хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчим

- 4.1. Хот байгуулалт, төлөвлөлтөд дараах үндсэн зарчим баримтална:
 - 4.1.1. Монгол Улсыг хөгжүүлэх үндэсний хөгжлийн стратегийг хангах;
 - 4.1.2. хүний аюулгүй байдал, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах;
 - 4.1.3. хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч этгээдийн эрх ашгийг тэгш хангах.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль

9 дүгээр зүйл. Хот, тосгоны удирдлагын үндсэн зарчим

Хот, тосгоны удирдлага нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх болон оршин суугчдын ашиг сонирхлыг төлөөлөх үндсэн зарчим баримтална.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль

5 дугаар зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэхэд баримтлах зарчим

5.1.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд Хот байгуулалтын тухай хуулийн 4.1-д заасан хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.нийтийн эрх ашгийг эрхэмлэх;

5.1.2.олон нийтийн оролцоог хангах.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчим.

5.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;

5.1.2.дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;

5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

5.1.4.тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;

5.1.5.тэнцвэртэй байх;

5.1.6.нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;

5.1.7.ил тод, нээлттэй байх;

5.1.8.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

5.1.9.зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;

5.1.10.шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;

5.1.11.төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;

5.1.12.төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах;

5.1.13.бүх талын оролцоог хангасан байх;

5.1.14.төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах;

5.1.15.оролцогчдын хариуцлагын зарчим.

1.1.2.2. Мэргэжил арга зүйн дараах суурь зарчмууд

1. Ерөнхийгөөс нарийвчлал руу, нарийвчлалаас ерөнхий рүү чиглэсэн үндсэн суурь зарчим


2.Бүсчлэлийн зарчим

3.Нутаг дэвсгэрийн зарчим

4.Системийн хандлагын зарчим

5.Газрын ангилал, зориулалт, зөвшөөрөгдсөн ашиглалтын төрлийн зарчим

Зураг 1. Газрын тухай хуулийн 25.1.5-д заасны дагуу улсын ГЗБЕТ-э дараа шатны төлөвлөлтөөр хэрэгжүүлэх суурь зарчмын схем.



Нийслэлийн ГЗБЕТ-тэй уялдуулах дараа шатны ГЗБТ-нд тусгах ажлын чиглэл
Газрын тухай хуулийн 25.3, 25.4-т заасны дагуу тухайн жилийн ГЗБТ-г
дараах ажлын чиглэлийг уялдуулж төлөвлөнө.

- Нийслэлийн ГЗБЕТ-нд тусгагдсан үндэсний болон Нийслэлийн хэмжээний бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжих газрын байршилыг үндэслэн төлөвлөгөөний төслийг хэрэгжүүлэх газрын хил заагийг тогтоон улсын тусгай хэрэгцээнд авах ГЗБ-ын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Нийслэлийн ГЗБЕТ-ний масштабын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний зургийг дараа шатны ГЗБТ-нд шууд хуулбарлахгүй бөгөөд тухайн шатны ГЗБТ-нд тавигдах зургийн масштабын стандартад нийцүүлэн хээрийн судалгаа хийж газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний зургийг шинээр хийж төлөвлөлтөө хийж гүйцэтгэнэ.

- Газрын тухай хуулийн 25.1.5-д заасны дагуу дараа шатны ГЗБ-ын нарийвчилсан төлөвлөгөө хийгдэж ерөнхий хил заагийг нь тодотгон тогтоогдоогүй тохиолдолд улсын ГЗБЕТ-ний схемд тусгасны дагуу ангилал, зориулалтын газрын ерөнхий хил заагийг дараа шатны ГЗБТ-нд шууд тусгана.

- Нийслэлийн ГЗБЕТ-нд схемээр ангилал, зориулалт өөрчлөх газрын ерөнхий хил заагийг Газрын тухай хуулийн 25.1.5-д заасны дагуу дараа шатны ГЗБ-ын нарийвчилсан төлөвлөгөө хийгдэж ерөнхий хил заагийг нь тодотгон тогтоогдсон тохиолдолд уг тодотгосон хил заагийг дараа шатны ГЗБТ-нд шууд тусгана.

1.1.2.3. Нийслэлийн ГЗБЕТ-ний стратегийн зорилт.

1. Байгаль орчинд ээлтэй бус, нэгдсэн бодлого төлөвлөлтгүй хөгжлийн өнөөгийн байдлаас байгаль орчиндоо зохицсон, уламжлалт ахуй, соёлын үнэт зүйлсэд суурилсан нэгдмэл зорилго, уялдаатай, иргэдийн оролцоотой, хүний хөгжил, амьдралын чанарыг дээшлүүлэх хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтолцоонд шилжинэ.

2. Сумын газар, хүн хүч, хөрөнгө санхүү болон байгалийн нөөц, чадавхад суурилсан газрын харилцаа, газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг ногоон хөгжлийн агуулга, зарчимд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх хөгжил, чадавхыг бүрдүүлнэ.

3. Төрийн өмчийн газар, байгалийн нөөцийг эд хөрөнгө баялгийн эрхээр удирдах, эзэмшиж, ашиглах, бизнесийн асуудлыг гэрээний эрх зүйн харилцаанд бүрэн шилжүүлнэ.

4. Газар, байгалийн бусад нөөцийг ашигласны төлбөр, татварыг ногоон эдийн засгийг дэмжих арга хэрэгсэл болгох санхүүжилт, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг газрын менежментийн бодлогоор дэмжих.

5. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг нутаг дэвсгэрийн маркетингийг хөгжүүлж, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

6. Бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.

7. БО-г хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, газар, бэлчээр нутгийн доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг удаан хугацаанд тогтвортой хангана.

1.2. НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ГЗБЕТ БОЛОВСРУУЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1. Газрын тухай багц хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн агуулга, чиглэлийг гаргах.

2. Газрын нэгдмэл сангийн ангиллыг өөрчлөн шинэчлэх, удирдлага, төлөвлөлтийн тогтолцоо, газар зохион байгуулалтын системийг боловсронгуй болгох журам, заавар, арга зүй, аргачлал, стандартын чиглэлийг гаргах.

3. Газар, байгалийн нөөцийг эд хөрөнгө, активын хэлбэрт шилжүүлэн төр өмчийн эзэн, өмчлөгчийн хувьд хөрөнгө оруулалтын эх үүсвэрт тооцох, хувь хэмжээг тогтоох үндэслэл болгох механизм, арга хэрэгсэл болгож хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиглэлийг тогтоох.

4. Газар ашигласны төлбөрийн эдийн засгийн арга, хандлагыг өөрчилж газрын рентийн зарчим, системд шилжүүлэх чиглэлийг гаргах.

5. Газрын харилцаа, газар зохион байгуулалт, газрын нэгдмэл сангийн үндсэн 6 ангиллын ерөнхий бүсчлэл буюу хил заагийн ерөнхий схемийг боловсруулах.

6. Газар ашигласны төлбөрийг газрын гүйцэтгэх үүрэг (эд хөрөнгө, нөөц, экосистемийн үйлчилгээ, орон зай гэх мэт), экологи-эдийн засгийн үнэлгээнд суурилан газрын рентийн төлбөрийн зарчим, системд шилжүүлэхтэй уялдуулан газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэд ангилал, газар ашиглалтын төрөл, ангилал зүйг /таксон/ шинэчлэх чиглэлийг гаргах.

7. Газрын харилцаа, газрын эрхийн гэрчилгээ, гэрээний нөхцөл, болзлыг шинэчлэх агуулга, чиглэлийг гаргах.

8. Газрыг нэг ангиллаас нөгөө ангилалд шилжүүлэх, газарт учруулсан хохирол, нөхөн олговор, нөхөн төлбөрийг газрын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны нөлөөлөл, учруулсан эдийн болон эдийн бус хохирол, үр шим, өгөөж, цаг хугацааны(геологийн нас, эрхийн хугацаа гэх мэт) хүчин зүйлд үндэслэн экологи-эдийн засгийн үнэлгээгээр тооцох хандлагыг тусгах.

1.2.1. Суурь үзэл баримтлалууд

Суурь үзэл баримтлал 1: Нийслэлийн ГЗБЕТ-г газрын дор дурдсан гүйцэтгэх үүрэг, ашигт чанарт нийцүүлэн боловсруулна

1. Газар нь хүний амьдрах, оршин байх анхдагч эрхийг хангах эд баялаг, орон зайн орчны үүрэг гүйцэтгэнэ.

2. Газар нь үл хөдлөх хөрөнгө бөгөөд түүнтэй бэхлэгдсэн эд зүйлс нь газрын бүрэлдэхүүн хэсэг байх ба нэгж талбар нь барьцаа, ипотек, концесс зэрэг хэлцлийн зүйл болох ашигт чанартай

3. Газар нь үйлдвэрлэлийн хүчин зүйл бөгөөд ХАА, ойн аж ахуйн салбарт үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болох ашигт чанартай

4. Үйлдвэрлэх хүчний байршлын бааз суурь, орон зайн үүрэг гүйцэтгэнэ

5. Ландшафтын хэв шинж, тогтоц, ой, ус зэрэг газрын байгалийн бүрдэл хэсэг нь экосистемийн үйлчилгээ үзүүлж, аж ахуйн нөөцийн үүргийг гүйцэтгэнэ.

6. Капитал, актив, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэнэ

7. Байгаль, нийгмийн түүх, соёлын үнэ цэнэ, эд өлгийн зүйлсийг агуулж хадгалагчийн үүрэг гүйцэтгэнэ.

Хүлээгдэж буй үр дүн:

Нийслэлд газрын гүйцэтгэх үүрэг, ашигт чанар, газрын өмчийн эрх, уг эрхээс уламжлагдсан бусад эрхийн төрүүдэд суурилсан газрын нэгдмэл сангийн бодлого, удирдлага, төлөвлөлт хуваарилалтын нэгдсэн тогтолцоо боловсронгуй болж, тогтвортой, ухаалаг газрын харилцаа төлөвшиж хөгжсөн байна.

Суурь үзэл баримтлал 2. Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Хот байгуулалтын багц хуулиуд, Байгаль орчны багц хуулиуд, Үндэсний аюулгүй байдал, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Алсын хараа-2050, тогтвортой болон ногоон хөгжлийн бодлого зэрэг төрийн бодлогын баримт бичгүүдийн бодлого зарчим, зорилт, хүрэх үр дүнд нийцүүлэн боловсруулна.

Хүлээгдэж буй үр дүн:

Үндсэн хууль, Иргэний хууль, байгаль орчны, газрын, хот байгуулалт, төлөвлөлтийн хууль тогтоомжид нийцсэн, Алсын хараа-2050, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой болон ногоон хөгжлийн бодлого, нутагшил, суурьшилтын ерөнхий схем зэрэг төрийн бодлогын баримт бичгүүдийн бодлого, зарчим, зорилтыг шингээсэн газрыг үр ашигтай, зүй зохистой ашиглах, хамгаалах 15 жилийн хугацаанд хэрэгжих газрын менежментийн тулгуур баримт бичигтэй болсон байна.

Суурь үзэл баримтлал 3. Уг төлөвлөгөөгөөр эхний ээлжид УБ хотын экологийн аюултай, эрсдэлтэй байдлыг бууруулах, улмаар үр дагаврыг арилгах цогц арга хэмжээг төлөвлөж, цар хүрээний хувьд нийслэлийн ГЗБЕТ-г УБ хотыг метрополитан хотын түвшинд боловсруулах бөгөөд байгаль-цаг уур, физик газар зүйн хүчин зүйл, экологийн даац, уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, антропоген доройтол, бохирдлын нөлөөллөөс өөрөө цэвэрших чадавх, онцлогоор нь нутаг дэвсгэрийг ялган бүсчлэх, үүнд нийцүүлэн УБ хотын хүн амын хэт төвлөрлийг бууруулах, хөдөөгийн дүүрэг, дагуул хот, тосгон болон эдийн засгийн бусад бүсүүдтэй үйлдвэрлэлийн кластер үүсгэн хамтарч ажиллах замаар дагуул хот, хөдөө орон нутагт хүн амын шилжин суурьших нөхцөлийг бүрдүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн

1. УБ хотын экологийн аюултай, эрсдэлтэй байдал арилгах, төсөл, арга хэмжээнүүд хэрэгжиж газар, хөрс, ус, агаарын бохирдол, доройтлын сөрөг үр дагавар буурч, нөхөн сэргэж газар-хөрс-усны цогц менежмент хэрэгжиж, гамшгийн нөхцөл байдал арилсан байна.

2. Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-нд үндэслэн хэт төвлөрлийг сааруулах, экосистемийн доройтлыг нөхөн сэргээх зорилгоор газар ашиглалтын бүтцийг өөрчлөн байгуулах хүрээнд УБ хотоос гаргах байгууллага, аж ахуйн нэгжийн хуваарь төлөвлөгөө хэрэгжиж УБ хотын агаар, хөрс, усны бохирдлын эх үүсвэр бүрэн арилсан байна.

3. УБ хотоос айл өрх, иргэдийг хөдөө орон нутагт шилжин суурьшуулах Засгийн газрын газрын шинэтгэлийн хөтөлбөр хэрэгжиж гэр хорооллын агаар, хөрс, усны бохирдлын эх үүсвэр бүрэн арилсан байна.

Суурь үзэл баримтлал 4. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд өөрийн орны газар зүйн байршлын онцлогийг харгалзан нийслэлийн газрын нэгдмэл санг өмчлөх, ашиглах, байгалийн баялгийн ашиглах эрхийг зайлшгүй нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд төр, Монгол улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжийн эрх, мэдэлд байлгаж хөрөнгө оруулагчтай хийх хэлцэлд газрын эрхээ хөрөнгө сангийн эх үүсвэр болгох, Франчайзийн гэрээгээр эдийн бус хөрөнгийг ашиглах, өндөр технологи нэвтрүүлэх, нутагшуулах замаар хараат байдал, хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний аюулгүй байдалд нийцүүлэн боловсруулна. Цаашид УБ хотын эдийн засаг, үйлдвэрлэлийн гол салбар нь нано, цахим технологи бүхий үйлдвэрлэл, дагуул хотод аж үйлдвэр, хөнгөн үйлдвэр, тосгонд ХАА-н үйлдвэрлэлийг төрөлжин хөгжүүлэх газрын менежментийн бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөнө. Үйлдвэрлэл, технологийн хөгжил нь газар, бусад нөөцийг үр ашигтай ашиглаж, үндэсний үйлдвэрлэлийг кластер үүсгэн импортыг орлож, экспортыг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүлээгдэж буй үр дүн:

1. Газар, байгалийн нөөцийн эрх мэдлийг үндэсний үйлдвэрлэгчдэд олгосноор газрын эрхийн актив хөрөнгийн үүргээр эдийн засгийн эргэлтэд орж, гадаадын хөрөнгө оруулагчид франчайзийн гэрээгээр үйлдвэрлэлд ноу-хау нэвтрүүлж, биет бус хөрөнгө оруулалт хийж технологи нутагшуулж эцсийн бүтээгдэхүүн бүхий үндэсний брэндүүд бий болж импортын урсгал бага ч, экспортын хэмжээ нэмэгдэж, бизнест төрийн оролцоо багасаж, нийслэлийн эдийн засаг “солонгорсон” байна.

2. Эдийн засгийн бусад бүс нутаг, дагуул хот, тосгоны хөгжлийг дэмжих кластерын зарчмаар хөгжиж, УБ хотын хэт төвлөрөл саарч, экологийн даацад нийцсэн зохистой төвлөрөл, үйлдвэрлэл, технологийн бүтэц бүрдэж, УБ хотод хиймэл оюун ухаан, инновац, өндөр технологи, цахим технологийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжиж, дагуул хотуудад хүнд, хөнгөн үйлдвэрүүд шинээр байгуулагдаж, хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолборууд бий болж нийслэлийн хүнсний хангамжийг хот орчмын тосгон, эдийн засгийн бусад бүсүүдээс нийлүүлж, үндэсний үйлдвэрийн эко хүнсээр бүрэн хангагдсан байна.

1.2.2. Газар зохион байгуулалтын мэргэжил арга зүйн үзэл баримтлал

Газрын тухай хуулийн 24.1 дэх “Газар зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн.” гэж заасныг мэргэжил, арга зүйн дараах үзэл баримтлалаар нарийвчилж төлөвлөв.


Хүснэгт 1. Мэргэжил, арга зүйн дараах үзэл баримтлал

№	Хуульд заасан агуулга	Төлөвлөх цогцолбор арга хэмжээний үзэл баримтлалын агуулга, чиглэл
1	Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	<p>Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, газрын үл хөдлөх хөрөнгө олж авах, аж ахуй эрхлэх зэрэг Үндсэн хуулийн шаардлагыг хангахаар төлөвлөнө.</p> <p>Нийслэл, дүүрэг, хот, тосгоны түвшинд газрын засаглалын индекс, түүний агуулга, чиглэл, шалгуур үзүүлэлт тогтоож ангилал зориулалт бүрээр газар ашиглагч салбар, газрын эрх бүхий этгээдийн өнөөгийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж цаашид төлөвлөгөөнд тусгах бодлого, чиглэл, арга хэмжээний хэрэгцээт байдлыг тогтоож төлөвлөнө.</p> <p>ГЗБЕТ-нд газрын ангилал зүйг нийслэлийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагын системтэй уялдуулна.</p> <p>Оролцогч талууд, иргэдийн оролцоог хангаж төлөвлөнө.</p> <p>Захиалагч талын удирдамж, чиглэл, саналд үндэслэж төлөвлөнө.</p> <p>Газрын маргааны шалтгаан, үр дагаврыг тогтоож, зөрчил маргааны менежментийн чадавхыг сайжруулах арга хэмжээний чиглэлийг боловсруулна.</p> <p>Газрын гэрээний эрх зүйн чадамж, үр дүнг сайжруулах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулна.</p>
2	Газрын кадастр эрхлэх	<p>Өмнөх ГЗБЕТ-ний хэрэгжилтийг кадастрын мэдээллийн сангийн зураг, нийслэлийн газрын нэгдмэл сангийн тооллого, тайлантай давхцуулж дүгнэх, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилттэй харьцуулж дүгнэлт гаргах, цаашид олон зорилгот кадастрыг нэвтрүүлэх бодлого, чиглэл, арга хэмжээг нийслэлийн ГЗБЕТ-нд тусгах,</p> <p>төрийн нийтийн өмчийн газрын кадастрыг эрхлэх агуулга чиглэлийг боловсруулах, нийтийн ашиглалтын газрын менежментийг сайжруулах,</p> <p>Нийслэлийн газрын нэгдмэл сангийн ангилал, хуваарилалтын өнөөгийн байдалд үнэлгээ хийх, цаашид төлөвлөгөөнд тусгах хэрэгцээт байдлыг тодорхойлох</p> <p>ГЗБТ-г хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь газрын кадастр байхаар төлөвлөнө.</p> <p>Газрын экологи-эдийн засгийн үнэлгээнд суурилж газар ашиглалтын зориулалт, төрлийг өөрчлөх, газрыг эргүүлэн авах, газарт учруулсан экологийн болон нөхөн төлбөрийн харилцааг зохицуулах механизмыг нэвтрүүлэх зөвлөмжийг боловсруулах</p>
3	Газрыг үр ашигтай, зохистой ашиглах	<p>Газрыг тогтвортой, ногоон хөгжлийн агуулга зарчмуудыг баримтлан байгаль хамгаалал, нийгмийн болон эдийн засгийн үр ашиг, өгөөжийн төсөөллийг төлөвлөнө.</p> <p>байгалийн хүчин зүйлүүдийн өөр хоорондын болон хүн, байгалийн харилцан үйлчлэлийг зөв тодорхойлон газрын даац, бүтээх чадавх, үр ашигт нийцсэн газар ашиглалтыг төлөвлөнө</p> <p>Газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдалд нийцүүлэн газар ашиглалтын салбар хоорондын зохистой харьцаа, бүтцийг хангаж төлөвлөнө.</p>
4	Газар хамгаалах	<p>Газрыг хууль бусаар өөрийн мэдэлд авч ашиглахаас хамгаалах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулна.</p> <p>Хуульд заасан газрыг хамгаалах нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө.</p> <p>Газрын хянан баталгааны дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө.</p> <p>Газрын төлөв байдал, чанар, байгаль орчин, хүний эрүүл, аюулгүй орчинд сөрөг нөлөө үзүүлэх үйлдвэр үйлчилгээг УБ хотоос гаргах арга хэмжээг төлөвлөнө.</p> <p>Тусгай хамгаалалтад авах газар, бүх төрлийн зориулалттай хамгаалалтын бүс тогтоох газрын байршил, хил заагийг тогтоон төлөвлөнө.</p>

		<p>Экологийн тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн газрыг хамгаалах зохион байгуулалт, эдийн засаг, эрх зүйн иж бүрэн инженерингийн цогц арга хэмжээг төлөвлөнө.</p> <p>Ой, усны сан бүхий газрыг экосистемийн тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээ, чадавх, үр нөлөөг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөнө.</p> <p>Туул голын эргийн хамгаалалтын бэхлэгээний байршлын схем, хамгаалалтын бүсийн хил заагийг шинэчлэн тогтоох, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна.</p>
5	Газар нөхөн сэргээх	<p>Газрын эрх бүхий этгээдийн газар нөхөн сэргээх газрын байршил хэмжээ, учруулсан хохирол, нөхөн сэргээх зардлын тойм хэмжээг тогтоож төлөвлөнө.</p> <p>Газрыг нөхөн сэргээхэд газрын эрх бүхий этгээдийн гэрээний үүрэг хариуцлагыг сайжруулах загвар зөвлөмжийг боловсруулах, гэрээг шинэчлэх, дүгнэх зөвлөмжийг боловсруулах</p>
6	Газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх	<p>Нийслэлийн бүх ангиллын газрын ашиглалтыг экологи-эдийн засгийн үнэлгээ, хөрөнгө оруулалт, барилгажилтын тооцоонд оруулж капиталжуулах, бүртгэх чиглэлийг боловсруулах</p> <p>Газрын хөгжүүлэлт хийх, магистрал зам, инженерийн байгууламж, шугам сүлжээний хангамжаар хангах газрын байршлын схем боловсруулах</p> <p>Ой, усны сан бүхий газрын экосистемийн үйлчилгээ, үнэ цэнэ, хил заагийг тооцож газрын үнэлгээ, төлбөр тогтоох хүчин зүйл болгож тооцох арга хэмжээг төлөвлөнө.</p> <p>Газрын экологи-эдийн засгийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын төсөөллийг үндэслэн газрын төлбөрийн бүсчлэлийн схемийг шинэчлэн боловсруулах</p> <p>Газрын төлбөрийн бусад бүс нутаг, хот суурины газрын төлбөрөөс 2-3 дахин их байхаар төлөвлөнө.</p> <p>Барилгажсан болон барилгажаагүй газрын үнэ, ашиг ижил тэнцүү байх эдийн засгийн механизм, арга хэрэгслийг нэвтрүүлж гэр хорооллын газрыг дахин төлөвлөлтөд хамруулж барилгажуулах сонирхол төрүүлэх, утаа гаргагч эх үүсвэрийн тоог бодитой бууруулах арга хэмжээг төлөвлөх</p> <p>газрыг ашигласнаар бий болох нэмүү өртөг, үр ашиг, газрын өнөөгийн үнэ цэнэ, үнэлгээ, төлбөрийн төсөөллийг тогтоож төлөвлөнө.</p>
7	Газар зүйн таатай орчин бүрдүүлэх	<p>газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдалд үндэслэн нутаг дэвсгэрийн хуваарь, хил заагийг шинэчлэх өөрчлөх үндэслэл, хувилбарын саналыг боловсруулах</p> <p>нутагшил суурьшил, дэд бүтэц, үйлдвэр, аж ахуйн салбаруудыг экологи, эдийн засаг, орон зайн хувьд оновчтой зохион байгуулж байршуулж төлөвлөнө.</p>
8	Газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх	<p>газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастрын үйл ажиллагаагаар газрын үндсэн ангилал шилжүүлэх,</p> <p>газар ашиглалтын зориулалтын бүс, ашиглалтын зориулалт, төрөл, ашиглалтын шаардлагыг тогтоох</p> <p>газрын сервитут тогтоох, орц, гарц гаргах газар ашиглалтыг эмхэлж цэгцлэх, горим, дэглэм тогтоох байршлын схем боловсруулах</p> <p>хөршийн эрхийг хангах, газрыг эргүүлэн авах, солих, чөлөөлөх, нөхөн олговор олгох зэрэг газар ашиглах, хамгаалах орон зайн таатай орчин бүрдүүлэх үйл ажиллагааг төлөвлөнө.</p>

Газрын тухай хуулийн 25 зүйлд заасныг үндэслэн нийслэлийн ГЗБЕТ-ний газар ашиглалт, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг цогцолбор байдлаар шийдвэрлэх тогтвортой хөгжлийн шийдлийн бодлого, зарчим, бүтэц, агуулгыг баримтална.

Зураг 2. Тогтвортой хөгжлийн схем зураг



1.2.3. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэг зөрчил, түүнд хариуцлага тооцох, газрын маргааныг бууруулахад чиглэсэн хууль дээдлэх, газрын засаглалыг сайжруулах үзэл баримтлал:

1. Нийслэлийн ГЗБЕТ боловсруулахад Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай багц хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах

2. Нийслэлийн ГЗБЕТ, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөний логик уялдаа, эрэмбэ дарааллын системийн хандлагыг боловсронгуй болгох

3. Газрын өмчийн болон бусад эрхийг төрлөөр газрын харилцааг зохицуулах, өмчлөлийн эрх нь бусад эрхээ “захирах” эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх

4. Газрын кадастрын зургийг хийхдээ хөршөөр хүлээн зөвшөөрүүлж акт үйлддэг тогтолцоонд шилжих журам зааврын агуулгыг боловсруулж газрын маргааныг эрс багасгана.

5. Газрын засаглалын индексийг нэвтрүүлж байгаль орчин, нийгэм, эдийн засгийн харилцааны шинж чанар, үр дүнгээр газрын засаглалын үнэлгээний тогтолцоонд шилжих

6. Газрын харилцаа, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын нэгдмэл санг цахим удирдлага, хяналтын тогтолцоог бүрэн нэвтрүүлж хөндлөнгийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэх

7. Гүйцэтгэх болон шүүх засаглалын хүрээнд ГЗБ-ын төлөвлөгөөний хэрэгжилтийн болон газрын эрхийн хууль бус хэрэг, зөрчил, хохирлыг газрын эд хөрөнгийн агуулгаар хариуцлага хүлээлгэж хохирол тооцох системд шилжүүлэх зөвлөмжийг боловсруулах

8. Нийслэлийн ГЗБЕТ боловсруулахад зорилтот бүлгүүдийн оролцоог хангах, санал авах

1.2.4. Нийслэлийн ГЗБЕТ-ний хүрээнд газар нутгийн хамгаалал, байгаль орчин-экологийн аюул, эрсдэлгүй, тэнцвэртэй байдалд хүрэх үзэл баримтлал:

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах Үндсэн хуулийн шаардлагыг хангахын тулд дараах үзэл санааг дэвшүүлж байна.

1. УБ хотын 6 дүүргийн нутаг дэвсгэрт газрын чадавх, даацыг тогтоож түүнд нийцсэн боломжит хүн амын тоо, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, төрөлжилтийг тогтоож, УБ хотоос шилжин суурьших хүн ам, байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг тогтоох, шийдвэрлэх арга зам, механизм, шийдлийг гаргах,

2. УБ хотын эвдэрсэн, элэгдсэн, бохирдсон, доройтсон газрыг экосистемийн хэмжээнд нөхөн сэргээж газар, агаар, хөрс, усны бохирдол, доройтлыг эрс бууруулах, арилгах

3. УБ хотын 6 дүүрэгт одоогийн суурьшсан газрын заагаар хот, тосгон бусад суурины ангиллын газрын хил заагийг шинэчлэн тогтооно.ой, усны сан бүхий газар, тусгай хамгаалалттай газраас шинээр хот, тосгон бусад суурины ангиллын газарт шилжүүлж ирээдийн суурьшлын бүсийг тэлэх, газрын эрх олгохыг зогсоох, өнөөгийн гэр хорооллын суурьшлын бүсэд ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн газрыг шинэчлэн зохион байгуулах ГЗБЕТ-ний схемийн боловсруулж хот, суурины газрын дахин төлөвлөлтийн нөхцөлийг бүрдүүлэх.

4. Нийслэлийн нийт нутаг дэвсгэрийн ой, усны сан бүхий газрын хил заагийг шинэчлэн тогтоож эдгээр ангиллын газрыг газар ойн болон усны аж ахуйн салбар, аялал жуулчлалаас бусад зориулалтаар газар ашиглах, барилга байгууламжийн зориулалтаар ашиглахыг хязгаарлахаар төлөвлөх

5. Усны нөөцийн хомсдол, агаар, хөрс, ус, орчны бохирдол, доройтолд нөлөөлж буй аж ахуйн жагсаалтын гаргаж хотоос нүүлгэж шилжүүлэх арга замыг тодорхойлох, УБ хотод шинээр ХАА-н түүхий эд боловсруулах, хорттой бодис үйлдвэрлэх, хадгалах, цуглуулах зориулалтаар газрын эрх олгох, газар дамжуулан түрээслэхийг хориглох үйл ажиллагааны чиглэлийн жагсаалтыг гаргах, батлуулах, мөрдүүлэх

6. Нийслэлийн экосистемийн үйлчилгээнд хамрагдах газар нутгийн хил заагийг тогтоох

7. Богд уулын ДЦГ, Хан хэнтийн ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ-ын хоорондын коридор газар нутгийн схемийг боловсруулах, нийслэлийн нутаг дэвсгэрт хамаарах тусгай хамгаалалттай газарт зэрлэг амьтдын амьдрах орчны тархац нутагт учирч буй ачаалал, дарамтыг бууруулахад чиглэсэн газар ашиглалт, хамгаалалтын бүсийг тогтоох, хамгаалалтын менежментийн чиглэл, зөвлөмжийг гаргах

8. Нэгж талбарын эрх бүхий этгээдийн газар ашиглалт, хамгаалалтын хүрээнд ногоон байгууламж байгуулах, нөхөн төлбөр төлөх эдийн засгийн арга хэрэгсэл, механизмыг боловсруулах, газрын эрхийн гэрээнд тусгах арга хэмжээний баримт бичгийн үзэл баримтлал, агуулга чиглэлийг боловсруулах

9. Газрын эрх бүхий этгээд өөрийн хөрөнгөөр экосистем, газар, газрын хэвлийг доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг гаргах, газар ашиглалтын гэрээнд тусгах, дүгнэх, хариуцлага тооцох баримт бичгийн үзэл баримтлалын агуулга, чиглэлийг боловсруулах

10. Тариалангийн газрыг элэгдлээс хамгаалах ойн зурвас байгуулах, хөрс хамгаалах, хөрсний ялзмагийг нэмэгдүүлэх баримт бичгийн үзэл баримтлал, агуулга, чиглэлийг боловсруулах

11. Тусгай хамгаалалтад авах газар, байгалийн түүх соёлын объектын газрын хэмжээ, хил заагийг тогтоох

Дээр дурдсан үзэл баримтлалыг газрын үндсэн ангилал, зориулалт, салбаруудын газар ашиглалт, хамгаалалтын газар зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээ болгон төлөвлөнө.

1.2.5. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм, эдийн засгийн бодлого, зорилтын үзэл баримтлал

1. Нийслэлийн ГЗБЕТ-г газрыг үр ашигтай зүй зохистой ашиглах зорилгоор нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээнд нийцүүлэн зориулалтаар эрх үүсгэн бүсчлэн төлөвлөх, хот төлөвлөлт, архитектурын төлөвлөлт хийх

2. Нийслэлийн газрын нэгдмэл сангийн удирдлагын систем, эрхийг төрлийг боловсронгуй болгох зорилгоор газар ашиглалтын зориулалт, хэрэгцээний төрөлд үндэслэн ангилал зүйн тогтолцоог бүрдүүлэх баримт бичгийн төслийг боловсруулах

3. Газрын нэгдмэл санг зөвхөн орон зайн үүрэг ач холбогдлоор төдийгүй бусад олон үүрэг, ашигт чанараар нь ашиглалт, менежментийн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, бүх газар эдийн засгийн харилцаа, тооцооны хэрэгсэл байх

агуулга, чиглэлийг боловсруулах, газрын үнэлгээ, үнэ, төлбөр, нөхөн төлбөр тогтоох арга хэлбэр

4. Газар өмчлөлийг ангиллын зарчим баримтлах, суурьшил үүссэн газрын хил зааг тогтоож дараах гэр бүлийн хэрэгцээний газрыг иргэнд үнэгүй өмчлүүлэхээр төлөвлөнө. Үүнд:

- *Зуслангийн доторх нэгж талбарыг өмчлүүлэх*
- *Нийтийн орон сууцны доорх газрыг давхарлалтын зарчим, олон улсын хандлага, аргачлалаар өмчлүүлэх,*
- *Нийслэлийн хөдөөгийн ХАА аж ахуйн үйлдвэрлэл болон өрхийн аж ахуй эрхэлж буй гэр бүлийн хэрэгцээний газрыг өмчлүүлэх*

5. Газар ашиглалтын бүтцийн өөрчлөлт хийж хэт төвлөрлийг бууруулах, газар ашиглалтын оновчтой байршил, төрөлжилтийг дараах арга замаар шийдвэрлэхээр төлөвлөнө. Үүнд:

- *Наран туул, Хүчит шонхор, Далай ээж зэрэг томоохон зах худалдааны төвүүдээс үүдэлтэй хэт төвлөрөл, замын түгжрэл үүсгэдэг асуудлыг шийдэх хүрээнд өөр байршилд салбар байгуулах, газар зүйн алслагдсан байршил бүхий хэрэглэгчдэд ижил үнэ, үйлчилгээний нэр төрөл бүхий зах худалдааны төвийг ойртуулах газрын байршил хэмжээ, нөхөн олговрыг төлөвлөх*
- *Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нийгмийн дэд бүтцийн хэрэгцээ, газрын байршил, хэмжээ, нөхөн олговрыг төлөвлөх*
- *Нийслэлийн авто замын хөндлөн нэвт гарц бүхий зам, агаарын зам барих, өргөтгөх, нийтийн тээврийн замналыг өөрчлөх, шинээр замнал тогтоох, автобусны буудлыг нягтруулах, зорчигчдод ойртуулах, тохижуулах газрын байршил хэмжээ, нөхөн олговрыг төлөвлөх, замын түгжрэлийн бууруулах бусад арга замыг тодорхойлж төлөвлөж түгжрэлийг бууруулах*
- *УБ хотын баруун захаас зүүн зах, Шинэ нисэх буудлыг холбосон суудлын цахилгаан галт тэрэгний замын хэрэгцээт газар, замнал, газрын байршил хэмжээ, нөхөн олговрыг төлөвлөж замын түгжрэлийг бууруулах*
- *УБ хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх байгууллага, аж ахуйн нэгжүүдийг улсын ГЗБЕТ-тэй уялдуулан нарийвчлан тодорхойлох, холбогдох яам, газартай уулзалт, хэлэлцүүлэг хийх, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох*

6. УБ хотоос алслагдсан дүүрэг болон бусад аймаг, сумдад шилжин суурьших өрхийн судалгаа авах, Засгийн газрын дэмжлэг тусалцаатайгаар шилжин суурьших өрхөд бизнес эрхлэхэд нь мал, амьтан, үр бордоо, хөрөнгө зээлийн тусламж үзүүлэх, газар эзэмшүүлэх, суурьшуулах, орон сууцжуулах цогц арга

хэмжээ хэрэгжүүлэх талаар Засгийн газрын тогтоолын төслийн агуулга, зарчмыг боловсруулах

7. Байршлын хувьд эдийн засгийн онц ач холбогдолгүй агуулахын аж ахуй, нөөцийн газруудыг нийслэлийн хөдөөгийн дүүрэг, өөр аймаг суманд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг боловсруулж газраа чөлөөлж авах

8. Газар ашиглалтын бүтцийн өөрчлөлтийн үед чөлөөлөгдсөн төрийг өмчийн газар, нэгж талбарын нөөцийн сан үүсгэж нийтийн эрх ашигт нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хэрэгцээнд нийцүүлж өөр газраа солих зэргээр газрын менежментийг хэрэгжүүлэх

9. УБ хотын таталцлын бүсийн аж ахуйн төрөлжилт, хамтын ажиллагаа, кластер үүсгэх түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлэлт, өртгийн сүлжээ байгуулах арга хэмжээг, төлөвлөх

10. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн ХАА-н газрын ГЗБ-ын схем, сэлгээ, мелиораци, хөрс сайжруулалт арга хэмжээ боловсруулах, хиймэл хөрс бэлтгэх, нарийн ногооны хүлэмж, гидропоны аж ахуй, эрчимжсэн мал, амьтны аж ахуй, уламжлалт өрхийн МАА, тэжээлийн аж ахуй, жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногооны аж ахуйн төрөлжилт, агуулах зоорь, Хөдөө аж ахуй эрхлэгчдийн эдлэн газрын байршил, хэмжээний төлөвлөлт

11. Барилын материал, түүхий эдийн олборлолтын үйлдвэрийн газрын байршил хэмжээ, эзэмшил, ашиглалт, үйлдвэрлэлийн бодлого тодорхойлох

1.3. ГАЗАР АШИГЛАЛТЫН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНД НИЙЦҮҮЛЭН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГА, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛЫН ЧИГЛЭЛ

1.3.1. Нийслэлийн ГЗБЕТ-ний цогцолбор арга хэмжээний ерөнхий чиглэл

1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын ангилал, зориулалт бүрээр газрын экологийн доройтлыг ландшафт, экосистемийн хэмжээнд хамгаалах төрөл бүрийн хамгаалалтын бүсийн хил зааг, экологийн коридор байгуулах бүсийн хил зааг, суурьшил, барилгажилтаас чөлөөлөх, хориглох, хязгаарлах бүсийн хил зааг, доройтсон газрыг нөхөн сэргээх, ачааллыг бууруулах газрын хил зааг, экологийн нөхөн төлбөрийг тогтоох бүсийн хил зааг экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг газрын үнэлгээ, үнэд тооцох бүсийн хил заагийг тус тус тогтоох арга хэмжээг төлөвлөх

2. Газрын ангилал, зориулалт бүрээр газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт хийх газар болон бусад нөөцийн ашиглалт, хамгаалалтын үр ашгийг нэмэгдүүлэх газрын байршил хэмжээ, ашиглалтын зориулалтыг тогтоох, ландшафтыг сайжруулах, газар хөгжүүлэлт, хамгаалалт,

нөхөн сэргээлт хийх, хиймэл ландшафт бүхий нутаг дэвсгэрийн маркетингийг хөгжүүлж газар нутгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөх

3. газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл, газрын татвар, төлбөрийн системийг нийгэм, эдийн засаг, экологийн харилцааг зохицуулах суурь хөшүүрэг арга хэрэгсэл болгох, газрын гүйцэтгэх үүрэг, ашигт чанарыг илэрхийлсэн олон зорилго, зориулалт бүхий кадастрын системийг нэвтрүүлэх, газрын үл хөдлөх хөрөнгийн татвар, түрээсийн үнийн нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг төлөвлөх

4. газрын зах зээлийг хөрөнгийн зах зээлийн суурь зарчимд нийцүүлэх, газрын үл хөдлөх хөрөнгө газрын кадастрыг зөвшөөрөгдсөн ашиглалтын төрлийн хэм хэмжээ, үнэн зөв, найдвартай хэмжил бүхий газрын эрхийн кадастр, газрын гүйцэтгэх үүрэг, ашигт чанараар нь үнэлсэн үнэлгээ, үнэ, татвар, төлбөр, нөхөн төлбөрийн системд суурилсан санхүү татварын кадастр газрын харилцааны ухаалаг цахим системийг бүрдүүлэх, газрын маргааныг бууруулах арга хэмжээ

5. Оновчтой байршил бүхий нийгмийн дэд бүтэц, төр, олон нийтийн үйлчилгээг замын түгжрэлийг багасгах, дэд бүтэц, нийтийн тээврийн зохистой, оновчтой сүлжээг байгуулах орон зай, газрын байршил, замнал, инженерийн болон нийгмийг дэд бүтцийн хэрэгцээнд газрыг эргүүлэн авах буюу солих, нөхөн олговор тогтоох газрын байршил хэмжээний чиглэл

6. Нийтийн орон сууцны хорооллын төлөвлөлтөд ногоон байгууламж, СӨХ-ийн буюу кондоминиумын газрын хүрэлцээ, хэмжээний норматив тогтоох, эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлэх арга хэмжээний чиглэл

7. Нийслэлийн дүүргүүдийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, хилийн цэсийг оновчтой тогтоох, эдгээрийн хувилбаруудын схемийг боловсруулах (Саналын түвшинд)

8. Нийслэлийн өнөөгийн хөгжлийн бодлого, чиглэлийг тогтвортой болон ногоон хөгжлийн суурь агуулга, зарчимд нийцүүлэх, иргэдийн оролцоо, санаачилгад тулгуурлан хөгжих, хандлага арга барилыг нэвтрүүлэх арга хэмжээний чиглэл

9. ГЗБЕТ-ний хүрээнд хэрэгжүүлэх газар, байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, нийгэм, эдийн засгийн төсөл, арга хэмжээний нэр төрөл, цар хүрээг тодорхойлох

10. Хэт төвлөрлийг сааруулах хүрээнд улсын ГЗБЕТ-нд нийцүүлэн УБ хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, айл өрхөд дэмжлэг үзүүлэх, зохицуулах газрын менежментийн бодлогоор арга хэмжээ

11. Газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, ногоон хөгжлийг дэмжих, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дотоод нөөц бололцоо, гадаад хүчин зүйлийг ашиглах арга хэмжээ

12. Газрын өмчийн болон бусад эрхийн төрөл, ангилал, зориулалтын эрхийн бүс, зөвшөөрөгдсөн ашиглалтын төрлийн ангилал зүйг тогтоож батлуулах, үүнд нийцүүлэн хот төлөвлөлт, барилгажилтын зураг төсөл, архитектурын шийдлийг

газрын ангилал зүйг мөрдөж байх тогтолцоог энэ төлөвлөгөөгөөр тогтоох, газрыг шинэчлэн зохион байгуулах, иргэн өмчийн газраар хувь нийлүүлэхэд газрын эрхийн баталгааны үзэл санааг боловсруулах

13. Орон сууцны хорооллын төлөвлөлтөд ногоон байгууламж, авто зогсоол, гаражийн СӨХ-ийн буюу кондоминиумын газрын хүрэлцээг хангах арга хэмжээ хэрэгжих хорооллын байршлын схем

14. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, амьдралын чанарыг дээшлүүлэх хүрээнд гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авахад нөхөн олговрын, өмчийн газрыг худалдаж авч дэд бүтцийн сүлжээний болон сервитут тогтоох газрын байршлын ерөнхий схем, гэр хорооллын иргэд өөрсдийн газраар хувь нийлүүлж СӨХ-ийн буюу кондоминиумын газар байгуулах арга хэмжээний чиглэл

15. Иргэд аж ахуй эрхлэх, газрын болон бусад үл хөдлөх хөрөнгө олж авах эрхээ хамгаалуулах, байгаль орчныг хамгаалах Үндсэн хуулийн журамт үүргээ хэрэгжүүлэх арга хэмжээ

16. Дүүрэг бүрд рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн сувиллын төвүүд болон цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын наран шарлагын талбай байгуулах газрын байршил, хэмжээний асуудал

17. Түүх соёлын үл хөдлөх эд хөрөнгийн зүйлс байршиж буй газар нутагт хөгжүүлэлт хийж брэнджүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, нутаг дэвсгэрийн үнэ цэнэ, маркетингийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, хөгжүүлэх арга хэмжээ

18. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлын нөөцийг зүй зохистой ашиглах, байгаль хамгаалал, ногоон хөгжилд суурилсан нийгэм, эдийн засгийн хөгжлийн шийдлүүдийг цогц байдлаар боловсруулах асуудал

19. Нийслэлийн нутаг дэвсгэрт инженерийн байгууламж, ариутгах татуургаар хангагдсан газрын хэмжээг нэмэгдүүлэх, оршуулгын газар, хог хаягдлын менежментийг эдийн засгийн арга механизм, арга хэрэгсэлд суурилж шийдвэрлэх төсөл, арга хэмжээ

20. Нийслэлийн нутаг дэвсгэрийн бохирдсон доройтсон газрыг эрүүлжүүлэхэд газрын эрхийн гэрээнд эдийн засгийн арга механизм, арга хэрэгсэлд суурилж шийдвэрлэж байх арга хэмжээний чиглэлийг тусгана.

21. Нийслэлийн хэмжээнд газрын өмчийн болон бусад эрхийн төрөл, салбар хоорондын газрын бодлого төлөвлөлт, газар зохион байгуулалт, кадастр, бүртгэл, мэдээллийн тогтолцоо, үйлчилгээний системийг бүрдүүлэх арга хэмжээ

22. Нийслэлийн ГЗБЕТ-г газарт буулгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл, арга хэмжээ, тухайн жилийн газар зохион байгуулалтын санхүүжилтийн асуудал

1.3.2. Улсын хөгжлийн бодлого хөтөлбөртэй уялдуулах НГЗБЕТ-нд тусгах үндсэн чиглэл

1.3.2.1. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм, эдийн засгийн бодлого, зорилт, арга хэмжээний чиглэл

Алсын хараа-2050. Хотын сайн засаглал

Зорилт 9.4.Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно.

НГЗБЕТ-нд тусгах арга хэмжээний үндсэн чиглэл

1. Нийслэлийн ГЗБЕТ-г хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх зарчмыг мөрдөж боловсруулахын зэрэгцээ, нийслэл, дүүргийн тухай жилийн ГЗБ-ын төлөвлөгөөг ГЗБЕТ-ний байгаль хамгаалал, нийгэм, эдийн засгийн агуулга, зорилго, зорилт, газрын ангилал, зориулалтын бүс, байршил хэмжээтэй нийцүүлэн төлөвлөж, үндсэн чиглэл хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалттай уялдуулан төлөвлөж хэрэгжүүлж байх тогтолцоог боловсронгуй болгох.

2. Нийслэлийн ГЗБЕТ, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөний логик уялдаа, эрэмбэ дарааллын системийн хандлагыг боловсронгуй болгох

3. Газрын өмчийн болон бусад эрхийг төрлөөр газрын харилцааг зохицуулах, өмчлөлийн эрх нь бусад эрхээ “захирах” эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож газрын харилцааны таатай орчин бүрдүүлнэ.

4. Иргэний хуульд заасныг үндэслэн ГЗБЕТ болон тухайн жилийн төлөвлөгөөнд газрын бүрдэл хэсэг, салшгүй эрхийг иж бүрэн хангаж байх газрын орон зайн шийдэлтэй байхаар төлөвлөнө.

5. Газрын кадастрын зургийг хийхдээ хөршөөр хүлээн зөвшөөрүүлж акт үйлддэг тогтолцоонд шилжих журам зааврын агуулгыг боловсруулж газрын маргааныг эрс багасгана.

6. Одоогийн зуслангийн барилгажсан газрыг хот, тосгон бусад ангиллын газарт шилжүүлж өмчлүүлэх, хязгаарлагдмал хугацаагаар бохирын шугам, хог хаягдал зайлуулах үйлчилгээгээр үйлчилж гэр хороолол болохоос урьдчилан сэргийлэхээр төлөвлөнө.

7. Газрын засаглалын индексийг нэвтрүүлж байгаль орчин, нийгэм, эдийн засгийн харилцааны шинж чанар, үр дүнгээр газрын засаглалын үнэлгээгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх тогтолцоонд шилжихээр төлөвлөнө.

8. Газрын харилцаа, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газрын нэгдмэл сангийн цахим удирдлага, хяналтын тогтолцоог бүрэн нэвтрүүлж хөндлөнгийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.

9. Гүйцэтгэх болон шүүх засаглалын хүрээнд ГЗБ-ын төлөвлөгөөний хэрэгжилтийн болон газрын эрхийн хууль бус хэрэг, зөрчил, хохирлыг газрын эд

хөрөнгийн агуулгаар хариуцлага хүлээлгэж хохирол тооцох системд шилжүүлэх зөвлөмжийг боловсруулна.

10. Нийслэлийн ГЗБЕТ боловсруулахад олон нийт, нийгмийн зорилтот бүлгүүдийн оролцоог хангах, санал авч олон нийтийн эрх ашиг, саналд нийцүүлэн боловсруулна.

11. Монгол улсын иргэн өмчийн газраа бусдад узуфрукт эрхээр эзэмшүүлэх, түрээсээр ашиглуулах эрх зүйн харилцаа, улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг боловсронгуй болгож газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, газрын маргааныг бууруулах зөвлөмжийг боловсруулах

12. Нийслэлийн газрын нэгдмэл сангийн удирдлагын систем, эрхийг төрлийг боловсронгуй болгох зорилгоор газар ашиглалтын зориулалт, хэрэгцээний төрөлд үндэслэн ангилал зүйн тогтолцоог бүрдүүлэх баримт бичгийн төслийг боловсруулах

13. Газрын нэгдмэл санг зөвхөн орон зайн үүрэг ач холбогдлоор төдийгүй бусад олон үүрэг, ашигт чанараар нь ашиглалт, менежментийн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, бүх газар эдийн засгийн харилцаа, тооцооны хэрэгсэл байх агуулга, чиглэлийг боловсруулах, газрын үнэлгээ, үнэ, төлбөр, нөхөн төлбөр тогтоох арга хэлбэрийг тогтоох

14. Газар өмчлүүлэхэд ангиллын зарчим баримтлах, суурьшил үүссэн газрын хил зааг тогтоож дараах гэр бүлийн хэрэгцээний газрыг иргэнд үнэгүй өмчлүүлэхээр төлөвлөнө. Үүнд:

- Зуслангийн доторх нэгж талбарыг өмчлүүлэх
- Нийтийн орон сууцны доорх газрыг давхарлалтын зарчим, олон улсын хандлага, аргачлалаар өмчлүүлэх,
- Нийслэлийн хөдөөгийн ХАА аж ахуйн үйлдвэрлэл болон өрхийн аж ахуй эрхэлж буй гэр бүлийн хэрэгцээний газрын өмчлүүлэх

15. Одоо гэр бүлийн хэрэгцээнд ашиглаж байгаа энэ төлөвлөгөө, хотын хөгжлийн төлөвлөгөөгөөр нийтийн орон сууцны хороолол барих, хувийн орон сууцны хороолол хэвээр хадгалагдах гэр бүлийн хэрэгцээний нэгж талбарын газрыг өмчлүүлэх

16. Хотын засаглал, газрын нийгэм, эдийн засгийн суурь харилцаа нь хотын дүрмийн суурь үндэслэл болгох, газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах иргэдийн оролцоо нь хотын соёлын нэг гол үзүүлэлт байх агуулга чиглэлийг боловсруулна.

17. Нийслэлийн иргэдийг газар ашиглах, газартай харьцах соёлд суралцах, ногоон эдлэн газар, хороолол байгуулах эдийн засгийн хөшүүргээр дэмжих газрын бодлогыг боловсруулах

1.3.2.2. Нийслэлийн ГЗБЕТ-ний хүрээнд газар нутгийн хамгаалал, байгаль орчин-экологийн аюул, эрсдэлгүй, тэнцвэртэй байдлыг хангах зорилт, арга хэмжээний чиглэл

Алсын хараа-2050. Орчин төвтэй шийдэл

Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.

Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.

НГЗБЕТ-нд тусгах арга хэмжээний үндсэн чиглэл

1. УБ хотын 6 дүүргийн нутаг дэвсгэрт газрын чадавх, даацыг тогтоож түүнд нийцсэн боломжит хүн амын тоо, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, төрөлжилтийг тогтоож, УБ хотоос шилжин суурьших хүн ам, байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг тогтоох, шийдвэрлэх арга зам, механизм, шийдлийг гаргах,

2. УБ хотын эвдэрсэн, элэгдсэн, бохирдсон, доройтсон газрыг экосистемийн хэмжээнд нөхөн сэргээж газар, агаар, хөрс, усны бохирдол, доройтлыг эрс бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөнө.

3. УБ хотын 6 дүүрэгт одоогийн суурьшсан газрын заагаар хот, тосгон бусад суурины ангиллын газрын хил заагийг шинэчлэн тогтооно.ой, усны сан бүхий газар, тусгай хамгаалалттай газраас шинээр хот, тосгон бусад суурины ангиллын газарт шилжүүлж иргэдийн суурьшлын бүсийг тэлэх, газрын эрх олгохыг зогсоох, өнөөгийн гэр хорооллын суурьшлын бүсэд ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн газрыг шинэчлэн зохион байгуулах ГЗБЕТ-ний схемийн боловсруулж хот, суурины газрын дахин төлөвлөлтийн нөхцөлийг бүрдүүлэх.

4. Нийслэлийн нийт нутаг дэвсгэрийн ой, усны сан бүхий газрын хил заагийг шинэчлэн тогтоож эдгээр ангиллын газрыг газар ойн болон усны аж ахуйн салбар, аялал жуулчлалаас бусад зориулалтаар газар ашиглах, барилга байгууламжийн зориулалтаар ашиглахыг хязгаарлахаар төлөвлөх

5. Усны нөөцийн хомсдол, агаар, хөрс, ус, орчны бохирдол, доройтолд нөлөөлж буй аж ахуйн жагсаалтын гаргаж хотоос нүүлгэж шилжүүлэх арга замыг тодорхойлох, УБ хотод шинээр ХАА-н түүхий эд боловсруулах, хортой бодис үйлдвэрлэх, хадгалах, цуглуулах зориулалтаар газрын эрх олгох, газар дамжуулан түрээслэхийг хориглох үйл ажиллагааны чиглэлийн жагсаалтыг гаргах, батлуулах, мөрдүүлэх арга хэмжээг төлөвлөнө.

6. УБ хотоос байгаль орчинд сөрөг нөлөөтэй ХАА-н бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийх, бусад үйлчилгээ, хоёрдогч түүхий эд цуглуулах нөөцийг агуулах, боловсруулах үйлдвэр, нефть шатахууны нөөцийн агуулах

зэргийн газар ашиглалтыг өөрчлөн байгуулах жагсаалтыг гаргах, хүнд үйлдвэр байгуулахыг хориглож төлөвлөнө.

7. Усны нөөцийг хуримтлуулах хөв цөөрөм далан байгуулах тохиромжтой газрын байршлыг тогтоох, хуримтлагдсан усыг ногоон байгууламжийн усалгаа, ХАА, ойн аж ахуй зэрэгт олон зориулалтаар зохистой ашиглах схем боловсруулах.

8. Ус ихээр хэрэглэдэг ундаа, архи пивоны үйлдвэрийн салбаруудыг усны нөөц, ихтэй дэд бүтэц хөгжсөн эдийн засгийн бусад бүсэд шилжүүлэх асуудлыг үе шаттайгаар газрын эрхийн гэрээ, төлбөрийн механизмаар зохицуулж УБ хотын усны нөөцийн хомсдолын эрсдэлээс хамгаална.

9. Нийслэлийн экосистемийн үйлчилгээнд хамрагдах газар нутгийн хил заагийг тогтоож, газрын төлбөрийн бүсийг шинэчлэн тогтоож төлөвлөх

10. Богд уулын ДЦГ, Хан Хэнтийн ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ-ын хоорондын зэрлэг амьтны шилжих хөдөлгөөний коридор газар нутгийн схемийг боловсруулах, нийслэлийн нутаг дэвсгэрт хамаарах тусгай хамгаалалттай газарт зэрлэг амьтдын амьдрах орчны тархац нутагт учирч буй ачаалал, дарамтыг бууруулахад чиглэсэн газар ашиглалт, хамгаалалтын бүсийг тогтоох, хамгаалалтын менежментийн чиглэл, зөвлөмжийг гаргах

11. Хог хаягдлын цэгт хөгжүүлэлт хийх, хот доторх оршуулгын газрыг дахин зохион байгуулах

12. УБ хотын дүүрэг, дүүрэг дундын болон дагуул хот бүрд ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлж төлөвлөнө.

1.3.2.3. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм, эдийн засгийн бодлого, зорилт, арга хэмжээний чиглэл

Алсын хараа-2050. Хүн төвтэй хот

Зорилт 9.1. Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно.

НГЗБЕТ-нд тусгах арга хэмжээний үндсэн чиглэл

Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжил, төрөлжилтийг хиймэл оюун ухаан, цахим технологид суурилсан цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж, эдгээрийн эд анги, сэлбэг хэрэгсэл, өндөр технологийн инновацын үйлдвэрлэл, үйлдвэрлэх үйлдвэр, бүх төрлийн хөнгөн үйлдвэр, банк, санхүү, хөрөнгийн биржийн үйлчилгээ, аялал жуулчлал, алт мөнгөн болон бусад үнэт эдлэл, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр төрөлжихөд газрын бодлогыг чиглүүлж төлөвлөнө.

Аэросити хотод чөлөөт бүс байгуулж экспортын чиглэлтэй хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр тусгай хэрэгцээнд авах газрыг төлөвлөнө.

Цахим, технологид суурилсан үйлдвэрлэл-технологийн паркийг ШУТИС –д тулгуурлан байгуулах газрын байршил, хэмжээний схемийг боловсруулна.

нийслэлийн ГЗБЕТ-г газрыг үр ашигтай зүй зохистой ашиглах зорилгоор нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвт нийцүүлэн газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээнд нийцүүлэн зориулалтаар эрх үүсгэн бүсчлэн төлөвлөх, хот төлөвлөлт, архитектурын төлөвлөлт хийх

Шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир спортын нэгдсэн болон төрөлжсөн цогцолбор төвүүдийг байршуулах газрыг төлөвлөнө.

Гэр бүлийн хэрэгцээний газар өмчлөгч, эзэмшигч иргэд өөрсдийн газраар болон өөрсдийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр хувь нийлүүлж зураг төслийн дагуу орон сууц барихыг дэмжих

Хотын суурьшлын бүсийн газар ашиглалтын төлөвлөлт, газрын бүртгэл, кадастрыг хорооллын тогтолцоонд шилжүүлж ая тухтай тавлаг орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Инженерийн дэд бүтцийн хүчин чадал, хамрагдах газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх хэмжээ, газрыг солих буюу эргүүлэн авах газрын байршил, хэмжээ, нөхөн олговрыг тойм хэмжээг тогтооно.

Ашиглалт багатай болон нийтийн эзэмшлийн газрыг үр ашигтай ашиглах, удирдах, хөгжүүлэх, эдийн засгийн чөлөөт эргэлтэд оруулах тогтолцоог бүрдүүлж олон нийтэд ил тод, нээлттэй болгоно.

Зам, шугам сүлжээний газрын байршлын схем, замын түгжрэлийг бууруулах худалдаа, үйлчилгээний олон төв, захын газрын байршил, хэмжээ, газар чөлөөлөх арга хэмжээний чиглэлүүдийг боловсруулах

Богд хан төмөр замын байршлын схемийг УБХНН-тэй хамтарч тогтоон тусгай хэрэгцээнд авах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

Дагуул хот, тосгоныг холбосон хурдны авто замын замнал, байршил, хэмжээ, нөхөн олговор, газар чөлөөлөх арга хэмжээг боловсруулах

Хот, суурины газрыг дахин төлөвлөлтөд оруулах, газраар хувь нийлүүлэхэд газрын эрхийн харьяалал, өмчийн болон бусад эрхийн төрөл, ашиглалтын зориулалтаар газрын бүртгэл хийх, хөрөнгө оруулалтад тооцох арга зүйн агуулга чиглэлийг боловсруулах

1.3.2.4. Газар ашиглалтын бүтцийн өөрчлөлт хийж хэт төвлөрлийг бууруулах, замын түгжрэлийг багасгах газар ашиглалтын зориулалт, салбаруудын болон аж ахуйн төрөлжилтийг оновчтой тогтоож байршуулах зорилт, арга хэмжээний чиглэл

Алсын хараа-2050. Дагуул хот

Зорилт 9.5. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.

НГЗБЕТ-нд тусгах арга хэмжээний үндсэн чиглэл

1. Худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж хот доторх төвлөрлийг багасгах хүрээнд Наран туул, Хүчит шонхор, Барс, Да хүрээ зэрэг хэт төвлөрөл, замын түгжрэл үүсгэдэг зах худалдааны төвүүдийн салбаруудыг өөр байршилд байгуулах, газар зүйн алслагдсан байршил бүхий хэрэглэгчдэд ижил үнэ, үйлчилгээний нэр төрөл бүхий зах, худалдааны төвийг ойртуулах газрын байршил хэмжээ, нөхөн олговрыг төлөвлөх

2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нийгмийн дэд бүтцийн хэрэгцээ, газрын байршил, хэмжээ, нөхөн олговрыг төлөвлөх

3. Нийслэлийн авто замын хөндлөн нэвт гарц бүхий зам, агаарын зам барих, өргөтгөх, нийтийн тээврийн замналыг өөрчлөх, шинээр замнал тогтоох, автобусны буудлыг нягтруулах, зорчигчдод ойртуулах, тохижуулах газрын байршил хэмжээ, нөхөн олговрыг төлөвлөх, замын түгжрэлийн бууруулах бусад арга хэмжээтэй цогц байдлаар уялдуулан төлөвлөж замын түгжрэлийг бууруулах

4. УБ хотын Эмээлтээс Налайх, Шинэ нисэх буудал, Аэросити хотыг холбосон суудлын цахилгаан галт тэрэгний замын хэрэгцээт газар, замнал, зогсоолын газрын байршил хэмжээ, газрыг эргүүлэн авах газрын нөхөн олговрыг төлөвлөж замын түгжрэлийг бууруулах

5. Амгалан орчимд төмөр замын вокзал, гааль, логистикийн төв, агуулахын аж ахуйг шинээр байгуулах газрын байршил хэмжээ, газрыг эргүүлэн авах газрын нөхөн олговрыг төлөвлөж замын түгжрэлийг бууруулах

6. УБ хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх байгууллага, аж ахуйн нэгжүүдийг улсын ГЗБЕТ-тэй уялдуулан нарийвчлан тодорхойлох, холбогдох яам, газартай уулзалт, хэлэлцүүлэг хийх, нүүлгэн шилжүүлэх хугацааг тохиролцох

7. УБ хотоос алслагдсан дүүрэг болон бусад аймаг, сумдад шилжин суурьших өрхийн судалгаа авах, Засгийн газрын дэмжлэг туслалцаатайгаар шилжин суурьших өрхөд бизнес эрхлэхэд нь мал, амьтан, үр бордоо, хөрөнгө зээлийн тусламж үзүүлэх, газар эзэмшүүлэх, суурьшуулах, орон сууцжуулах цогц арга хэмжээ хэрэгжүүлэх талаар Засгийн газрын тогтоолын төслийн агуулга, зарчмыг боловсруулах

8. Байршлын хувьд УБ хотод онц ач холбогдолгүй уул уурхай, ХАА-н агуулахын аж ахуй, нөөцийн газруудыг нийслэлийн хөдөөгийн дүүрэг, өөр аймаг суманд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг боловсруулж газраа чөлөөлж, уг газрын инженерийн болон нийгмийн дэд бүтэц барьж байгуулах хэрэгцээнд авах

9. Газар ашиглалтын бүтцийн өөрчлөлтийн үед чөлөөлөгдсөн газрыг газар, нэгж талбараар газрын нөөцийн сан үүсгэж нийтийн эрх ашигт нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хэрэгцээнд нийцүүлж өөр газраа солих зэргээр газрын менежментийг хэрэгжүүлэх

10. УБ хотын таталцлын бүсийн аж ахуйн төрөлжилт, хамтын ажиллагаа, кластер үүсгэх түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлэлт, өртгийн сүлжээ байгуулах арга хэмжээг, төлөвлөх

11. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн ХАА-н газрын ГЗБ-ын схем, сэлгээ, мелиораци, хөрс сайжруулалт арга хэмжээ боловсруулах, хиймэл хөрс бэлтгэх, нарийн ногооны хүлэмж, гидропоны аж ахуй, эрчимжсэн мал, амьтны аж ахуй, уламжлалт өрхийн МАА, тэжээлийн аж ахуй, жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногооны аж ахуйн төрөлжилт, агуулах зоорь, Хөдөө аж ахуй эрхлэгчдийн эдлэн газрын байршил, хэмжээний төлөвлөлт

12. Барилын материал, түүхий эдийн олборлолтын үйлдвэрийн газрын байршил хэмжээ, эзэмшил, ашиглалт, үйлдвэрлэлийн бодлого тодорхойлох

13. Нэгж талбарын газрын эрх бүхий этгээдийн газар ашиглалт, хамгаалалтын хүрээнд ногоон байгууламж байгуулах, нөхөн төлбөр төлөх эдийн засгийн арга хэрэгсэл, механизмыг боловсруулах, газрын эрхийн гэрээнд тусгах арга хэмжээний баримт бичгийн үзэл баримтлал, агуулга чиглэлийг боловсруулах

14. Газрын эрх бүхий этгээд өөрийн хөрөнгөөр экосистем, газар, газрын хэвлийг доройтлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг гаргах, газар ашиглалтын гэрээнд тусгах, дүгнэх, хариуцлага тооцох баримт бичгийн үзэл баримтлалын агуулга, чиглэлийг боловсруулах

15. Аялал-рекреацийн өнөөгийн байдал, газрын экологийн төлөв байдлыг тогтоох, дүгнэлт хийж зүй зохистой хөгжүүлэх, аяллын замналыг тогтоох, аялал жуулчлалын бүтээгдэхүүний зэрэглэл тогтоох, хөгжүүлэлт хийх шидлүүдийг боловсруулах аялал жуулчлалын газрын үнэлгээ, төлбөрийн бүсийг тогтоох

16. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хараат байдлаас ангижрах зорилгоор тариалангийн газрыг зөвхөн Монгол улсын иргэн, үндэсний аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, дундын эзэмшлийн үл хуваагдах үл хөдлөх нэгж талбар бүхий жимс, ногооны хоршоог газрын бодлогоор дэмжихээр төлөвлөнө.

17. Шувууны аж ахуй, агропарк нэмж байгуулах газрын байршил, хэмжээг тогтоох

18. Тариалангийн газрыг элэгдлээс хамгаалах ойн зурвас байгуулах, хөрс хамгаалах, хөрсний ялзмагийг нэмэгдүүлэх баримт бичгийн үзэл баримтлал, агуулга, чиглэлийг боловсруулах.

19. Тусгай хамгаалалтад авах газар, байгалийн түүх соёлын объектын газрын хэмжээ, хил заагийг тогтоох

Дээр дурдсан зорилт, арга хэмжээний чиглэлийг газрын үндсэн ангилал, зориулалт, салбаруудын газар ашиглалт, хамгаалалтын газар зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээ болгон төлөвлөнө.

1.4. НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ

Төрийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилт, үйл ажиллагаатай нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах хэрэгцээ шаардлага

Нийслэлийн газар ашиглалтын хэрэгцээт байдлыг тэргүүлэх ач холбогдлоор нь дараах байдлаар эрэмбэлж төлөвлөв

1. Газар ашиглалтын нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох

2. Геоэкологийн доройтлыг бууруулж, газрыг хамгаалах, нөхөн сэргээж хүний амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх хүний амьдралын чанарыг дээшлүүлэх.хэрэгцээг тодорхойлох

3. Газрын засаглалыг сайжруулах, газар зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх газрын хэрэгцээг

4. Газрын чадавх, нөөцийг нэмэгдүүлж тодорхойлох, Газрын сангийн эд хөрөнгийн болон бусад ашигт чанар, гүйцэтгэх үүрэгт нийцсэн удирдлага, хяналтын тогтолцоог

Газрыг үр ашигтай, зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газар хөгжүүлэлт, хөрөнгө оруулалтын хэрэгцээг тодорхойлох

Хүснэгт 2. Газар ашиглалтын нийгэм, эдийн засгийн хөгжил, геоэкологийн доройтлыг бууруулж, газрыг хамгаалах, нөхөн сэргээж хүний амьдрах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх хүний амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэгцээ

№	Бодлогын баримт бичгүүд	Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгах болон уялдуулах заалтууд
1	“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”- 5 заалт	3.1.2.1.Нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарчимтай уялдуулан Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно. 3.4.3.1.Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн. 3.4.3.2. Нийслэлийн хүн амын төвлөрлийг тархаан байршуулах зорилгоор дагуул хотуудыг төлөвлөж, нийслэл орчмын бүс нутгийг өндөр хурдны авто зам, эрчим хүч, инженерийн барилга байгууламжаар найдвартай хангаж холбоно. 3.4.3.3. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэдийн аюулгүй ажиллаж амьдрах нөхцөлийг бий болгох зорилтод нийцүүлэн

		<p>шинэчилж, хот байгуулалтад төлөвлөлтийг хатуу мөрдөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.</p> <p>3.4.3.4. Томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, ариун цэврийн байгууламжийн бүтээмжийг нэмэгдүүлж, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.</p> <p>3.4.3.7. Амьдрах орчныг эрүүлжүүлэхэд иргэдийн үүрэг, хариуцлага, оролцоог нэмэгдүүлнэ.</p> <p>3.1.4.1. Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ. Дэлхийн Монгол судлалын төвийг Улаанбаатарт байгуулж монголч эрдэмтдийг судалгааны ажлуудад татан оролцуулах, бусад оронд салбар байгуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>4.2.6. Нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга нар орон нутагтаа Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хүлээнэ.</p>
	<p>“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого</p>	<p><u>Хүнд ээлтэй амьдрах орчин</u></p> <p>I үе шат (2021-2030): Эрүүл баталгаат орчин бий болгох үе.</p> <p>Зорилт 2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.</p> <p>1. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгоно.</p> <p>2. Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчинтой болно.</p> <p>II үе шат (2031-2040): Амьдралын таатай орчин бүрдүүлэх үе.</p> <p>1. Тохилог амьдралын таатай орчин бүрдүүлж, орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтийг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн хог хаягдлын зохистой менежментийг хэвшүүлнэ.</p> <p>2. Ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хот, суурин газрын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлнэ.</p> <p>3. Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагыг боловсронгуй болгож, баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй болон эрүүл хүнсний хэрэглээтэй болно.</p>
		<p><u>ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА</u></p> <p>Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>II үе шат (2031-2040): Эрсдэлээс сэргийлсэн нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах үе.</p> <p>5. Ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулсан байна.</p> <p><u>Орлогод нийцсэн орон байр</u></p> <p>Зорилт 3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх үе.</p> <p>1. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоотой болсон байна.</p> <p>2. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоо бэхэжсэн байна.</p> <p>II үе шат (2031-2040): Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны чанар, стандартыг сайжруулах үе.</p>

	<p>1.Гэр хорооллын нөхцөлийг сайжруулж, хүн амын худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулна.</p> <p><u>Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт</u></p> <p>Зорилт 3.4. Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж, эрсдэлээс хамгаална.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлэх үе.</p> <p>1.Зорилтот санхүүжилт, хөнгөлөлт, хүртээмжтэй үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн байна.</p> <p>II үе шат (2031-2040): Дундаж давхаргыг бэхжүүлэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх үе.</p> <p>1.Эрэлтэд нийцүүлсэн зорилтот санхүүжилт, хөнгөлөлтийг тасралтгүй хөгжүүлж, дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд зориулсан төсвийн хуваарилалт, зарцуулалт нэмэгдсэн байна.</p> <p><u>Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг</u></p> <p>Зорилт 3.5.Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үе.</p> <p>1.Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.</p> <p>II үе шат (2031-2040): Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх биеийн тамир, спортын чанар, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх үе.</p> <p>1.Идэвхтэй амьдралын дадал хэвшлийг дэмжих тогтолцоо бүрдэж, хот, суурин газрын орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд биеийн тамир, спортоор хичээллэх, амьдралын зөв дадал хэвшилтэй болгох олон улсын стандарт, шаардлагад нийцсэн, тохилог, таатай орчныг бий болгоно.</p> <p><u>Газрын харилцаа</u></p> <p>Зорилт 3.6.Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үе</p> <p>1.Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдсэн байна.</p> <p>2.Газрын бирж, олон зориулалттай кадастрын нэгдсэн системийг нэвтрүүлж, газрын нэгдмэл сан, түүний ашиглалтад тавих төрийн хяналтын тогтолцоо боловсронгуй болсон байна.</p> <p>3.Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоо бүрдэнэ.</p> <p>4.Монгол Улсын геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангана.</p> <p>II үе шат (2031-2040): Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүхий ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог нэвтрүүлэх үе.</p> <p>1.Газрын хяналт, удирдлагын нэгдсэн тогтолцоог бий болгож бэхжүүлнэ.</p> <p>2.Үндэсний орон зайн мэдээллийн нэгдсэн платформыг бий болгон хөгжүүлж, хэрэглэж хэвшсэн байна.</p> <p>Зорилт 5.2.Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p>
--	---

		<p>I үе шат (2021-2030): Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог төлөвшүүлэх үе.</p> <p>2.Хөгжлийн бодлогод нийцсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оновчтой хуваарилалт бий болж, орон нутгийн бие даасан байдал хангагдана.</p> <p>5.Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүй, бодлогын орчин бүрдэнэ.</p> <p>II үе шат (2031-2040): Иргэдийн эрх ашгийг дээдэлсэн, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжсэн цомхон бөгөөд үр ашигтай, үр нөлөөтэй бүтэц, зохион байгуулалтыг төрийн байгууллагуудын бүх түвшинд нэвтрүүлэх үе.</p> <p>2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бие даан хөгжих нөхцөл бүрдэнэ.</p> <p>5.Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчин бүрдэнэ.</p>
		<p>ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ</p> <p>Зорилго 6.Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.</p> <p>Эх байгаль анхдагч экосистем</p> <p>Зорилт 6.1.Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлэмжийг нэмэгдүүлж эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх үе.</p> <p>1.Байгалийн баялгийн нөөц, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлгээг шинэчилнэ.</p> <p>2.Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаална.</p> <p>II үе шат (2031-2040): Экосистемийн үйлчилгээг тэтгэж үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе.</p> <p>1.Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, нөөц, даацыг шинэчлэн тогтоож, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</p> <p>2.Онцлог, үнэ цэн бүхий экосистемүүдийг тусгай хамгаалалтад авч, анхдагч байгалийн унаган төрх, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.</p> <p>Байгалийн баялгийн үр өгөөж</p> <p>Зорилт 6.2.Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгох үе.</p> <p>1.Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлнэ.</p> <p>2.Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.</p> <p>3.Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангана.</p> <p>4.Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийнэ.</p> <p>II үе шат (2031-2040): Техник, технологийн ололт, инновацыг байгаль хамгаалалд ашиглаж, нөөцийн хомсдол, орчны доройтлоос сэргийлэх үе.</p> <p>1.Технологийн хөгжлийг биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, тарималжуулах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэхэд ашиглан нөөцийн хомсдолоос сэргийлнэ.</p>

		<p>2.Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ.</p> <p>3.Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, мэдээллийн нэгдсэн цахим санг өргөжүүлж, технологийн хөгжлийг нэвтрүүлэн, мэдээллийн ухаалаг цогц тогтолцоог бүрдүүлнэ.</p> <p><u>Үнэт баялаг үс</u> Зорилт 6.3.Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>
		<p><u>ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ</u> Зорилго 4.Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.</p> <p><u>Чинээлэг монгол</u> Зорилт 4.1.Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн <u>Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн</u> Зорилт 4.5.Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030): Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх үе. 1.Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлсэн байна 2.Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна. II үе шат (2031-2040): Бүс нутгийн болон олон улсын чанар, стандартын тогтолцоог нэвтрүүлэх, цахим худалдааг хөгжүүлэх замаар бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээнд холбогдож ажиллах үе. 1.Бүс нутгийн эдийн засгийг дэмжих экспортын төрөлжилт бий болсон байна.</p>
		<p><u>ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ</u> Зорилго 9.Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.</p> <p><u>Хүн төвтэй хот</u> Зорилт 9.1.Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй хот болно. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030): Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үе. 1.Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалт хийж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана. 2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана. II үе шат (2031-2040): Иргэн төвтэй нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш байдлыг хангасан, үр ашигтай тогтолцоог бэхжүүлэх үе. 2.Шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрмийн дагуу биеийн тамир, спортын барилга байгууламжууд баригдсан байна. 3.Олон улсын стандартад нийцсэн соёлын ордон, зарим бүсэд мэргэжлийн урлагийн байгууллагатай болно. <u>Орчин төвтэй шийдэл</u> Зорилт 9.2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.</p>

		<p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох үе.</p> <ol style="list-style-type: none"> 1.Экосистемийн үнэ цэн экологийн даацыг тогтоож, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ. 2.Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бохирдол үүсгэгчийг багасгаж, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулсан байна. 3.Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж, гадаргын усыг хуримтлуулан, дахин ашиглаж, усны үнэ цэнийг нэмэгдүүлнэ. 4.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болсон байна. 5.Хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлж, хот доторх оршуулгын газрыг дахин зохион байгуулна. 6.Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах, гамшгийг эрт илрүүлэх, тэсвэрлэн гарах чадавхыг бэхжүүлнэ. 7.Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно. 8.Агаар, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг олон улсын түвшинд хүргэнэ. 9.Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ. <p>II үе шат (2031-2040): Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон, ухаалаг технологийн үе.</p> <ol style="list-style-type: none"> 1.Хот, суурин газрын экосистем, биологийн олон янз байдлыг хамгаалж, голуудын урсцыг сайжруулан, усны нөөцийг хуримтлуулах хөв цөөрөм, усан сан байгуулж, эх үүсвэрийн гүний тэжээгдлийг экологийн түвшинд хүргэнэ. 2.Ус дахин ашиглах хэмнэлттэй хэрэглэх тогтолцоог бүрдүүлсэн байна. 3.Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, автоматаар татан авах (хог хаягдлыг татан авах шугам) технологийг нэвтрүүлсэн байна. 4.Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор нийтийн тээвэрт эко, цахилгаан тээврийг нэвтрүүлсэн байна. 5.Гэр хорооллын болон ногоон бүсийн айл өрхүүдийн эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлж, өрхийн үйлдвэрлэсэн цахилгааныг төвийн сүлжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ 6.Ой хамгаалал, нөхөн сэргээлтийн тогтвортой менежментийг хэрэгжүүлж, ойн экосистемийг бий болгосон байна. <p><u>Төлөвлөлт төвтэй хөгжил</u></p> <p>Зорилт 9.3.Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэлийн үе.</p> <ol style="list-style-type: none"> 1.Улаанбаатар хотын төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, газар зохион байгуулалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зайн шаардлагатай төлөвлөлтийг тооцон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 2.Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамж нэмэгдсэн байна. 3.Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлсэн байна. 4.Хотын орон зайн түвшинд аюулгүй байдлыг хангасан автоматжуулалтыг бий болгоно. 5.Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. 6.Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлсэн байна. 7.Ачаа тээврийн Богд хан төмөр замыг барьж байгуулна.
--	--	--

	<p>8.Улаанбаатар хотын авто замын бүсчлэлийг тогтоож тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулна.</p> <p>II үе шат (2031-2040): Дэд бүтцийн бүрэн хангамжтай, ухаалаг систем бүхий хотын хөгжлийг эрчимжүүлэх үе.</p> <p>1.Улаанбаатар хот доторх төвлөрлийг задлах зорилгоор соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, тэдгээрийг холбосон хөгжлийн коридорыг бий болгоно.</p> <p>2.Цахим суурьтай санхүүгийн технологи, цахим банк, цахим мөнгө, хиймэл оюун ухаан, блокчэйн технологи, автоматжуулалт, үүлэн технологи, хатуу болон зөөлөн дэд бүтцийг хүчирхэгжүүлнэ.</p> <p>3.Нийт эрчим хүчний баланст эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийн хувийн жинг нэмэгдүүлж, бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангана.</p> <p>4.Богд хан уулыг тойрсон зорчигч тээврийн сүлжээг барьж байгуулна.</p> <p>5.Дагуул хот, тосгоныг холбосон хурдны замтай болно.</p> <p>6.Хотын гудамж замын иж бүрэн сүлжээг бий болгоно.</p> <p><u>Хотын сайн засаглал</u></p> <p>Зорилт 9.4.Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот болно.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Хууль, эрх зүйн шинэчлэл хийж хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдүүлэх үе.</p> <p>1.Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгосон байна.</p> <p>3.Мэдээллийг цахимжуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэх тогтолцоог бий болгоно.</p> <p>4.Хотын татварыг төрөлжүүлэн онцгой татвар бий болгоно.</p> <p>5.Хотын бие даан хөгжих хууль, эрх зүйн орчныг шинэчлэн, хотын багц дүрэмтэй болж, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан салбаруудын мастер төлөвлөгөөтэй болно.</p> <p>6.Төрийн байгууллагуудын менежментийг сайжруулан хүний нөөцийг чадавхжуулсан байна.</p> <p>II үе шат (2031-2040): Хотын тогтвортой засаглалыг бэхжүүлэх, олон улсын найрсаг харилцааны эрх зүйн орчин бүрдүүлэх үе.</p> <p>1.Иргэд төрийн байгууллагад биеэр очилгүй цахимаар төрийн үйлчилгээг авах боломжийг бүрэн бүрдүүлж, иргэнээ дээдэлсэн төрийн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.</p> <p>2.Хотын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр ашгаар эрэмбэлэн, санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын сан байгуулж, нэгдсэн менежментийн тогтолцоог бүрдүүлсэн байна.</p> <p>3.Орон нутгийн өмчит газруудыг олон нийтийн компани болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, менежментийг сайжруулна.</p> <p>4.Ашиглаагүй үл хөдлөх хөрөнгийг үр ашигтай эзэмших, удирдах, хөгжүүлэх, эдийн засгийн чөлөөт эргэлтэд оруулах тогтолцоог бүрдүүлж олон нийтэд ил тод, нээлттэй болгоно.</p> <p><u>Дагуул хот</u></p> <p>Зорилт 9.5.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ.</p> <p>Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн</p> <p>I үе шат (2021-2030): Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлэх үе.</p> <p>1.Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>
--	--

		<p>2.Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.</p> <p>3.Хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төв нээгдэнэ.</p> <p>4.Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлнэ.</p> <p>5.Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.</p> <p>II үе шат (2031-2040): Нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх үе.</p> <p>1.Улаанбаатар бүсийн хэмжээнд өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулна.</p> <p>2.Үндэстэн дамнасан корпорацууд болон олон улсын байгууллагуудын салбарууд нээгдсэн байна.</p> <p>3.Шинэ техник технологи, инновац шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг дагуул хаяа хот, тосгонд нэмэгдүүлсэн байна.</p> <p>4.Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотуудад хотхон байгуулан шилжүүлнэ.</p> <p>5.Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр дагуул хотуудад шилжүүлнэ.</p>
2	"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал" – 6 заалт	<p>4.1. Бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих бодлогын гол чиглэл нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын нутгийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшнийг эрэмбэ дараатай дээшлүүлэх явдал юм.</p> <p>4.2. Бодлогын гол чиглэлийг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлнэ.</p> <p>4.3.5. Улаанбаатарын бүсэд: нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд тус тус орно.</p> <p>4.5. Бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг харгалзан Улаанбаатарын бүсэд: оюуны багтаамж ихтэй бүх төрлийн үйлдвэр, үйлчилгээ, олон улсын банк санхүүгийн сүлжээг тус тус тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.</p> <p>4.7.5.г. Улаанбаатарын болон бусад бүсийн хэмжээнд Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрлийг задлах зохистой чиглэл, хотын оршин суугчдын амьдрах орчны чанар, аюулгүй байдлыг хангах, хотын газрыг үр ашигтай ашиглах, инженерийн шугам сүлжээ, замын байгууламжийг шинэчлэх шаардлагыг бодолцон нийслэл хотын хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулах;</p> <p>4.7.5.д. эрх зүй, эдийн засаг, нийгэм сэтгэл зүйн зохих нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр Монгол Улсын нийслэлийг Улаанбаатар хотоос тус улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт шилжүүлэн байршуулах асуудлыг иж бүрнээр судалж 2020 он хүртэлх хугацаанд шийдвэрлэх;</p> <p>3.13. Нийслэл хот нь засаг захиргааны болон соёл, шинжлэх ухаан, мэдээлэл, гадаад харилцааны байгууллагууд зонхилон байрласан харьцангуй цөөн хүн амтай, экологийн эрүүл орчинтой, архитектурын зохиомж сайтай, нийгмийн харилцааны гол төв болохуйц зохистой байршилтай болж байгаа зэрэг орчин үеийн дэлхий нийтийн өөрчлөлтийн түгээмэл хандлагыг харгалзан Монгол Улсын нийслэлийн байршил, чиг үүргийг оновчтой тогтоох асуудлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хэрэгжих орчинтой холбон зохистой шийдвэрлэнэ.</p>
4	"Ногоон хөгжлийн бодлого" –6 заалт	<p>3.2.9.ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлж, хүн амын 90-ээс доошгүй хувийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангаж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг 60-аас доошгүй хувьд хүргэх;</p> <p>3.6.1.уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх</p>

		<p>чадвартай “ногоон”, “ухаалаг” хот, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>3.6.2.хот, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах;</p> <p>3.6.3. Улаанбаатар хот болон бусад хот сууриныг дахин төлөвлөж эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 15 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх;</p> <p>Хүрэх үр дүн: Улаанбаатар хот, бусад суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь 2020 онд 15%, 2030 онд 30%-д хүргэнэ.</p> <p>3.6.5.байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, найдвартай, эрсдэлгүй нийтийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд тав тухтай зорчих орчныг бүрдүүлэх;</p> <p>3.6.6.явган зорчигчийн зорчих хэсэг, ногоон байгууламж, дугуйн зам, зогсоолын төлөвлөлт, зохион байгуулалтыг боловсронгуй болгож явган явах, дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх.</p>
	Төрөөс ойн талаар баримтлах бодлого	<p>3.2.5.бэлчээр, тариалангийн талбай, авто зам, төмөр замын сүлжээг хамгаалах зориулалт бүхий ойн зурвас, хот, суурин газар ногоон байгууламж байгуулах ажлын зардлыг захиалагч болон ашиглагчийн зураг төсөв, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;</p> <p>3.2.7.экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор байгалийн гамшиг болон хууль бус мод бэлтгэл, уул уурхайн олборлолт, хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас устсан ойг нэн тэргүүнд нөхөн сэргээх;</p> <p>3.4.4.ойн хүлэмжийн хий шингээх, хүчилтөрөгч ялгаруулах, хөрс, ус болон биологийн олон янз байдлыг хамгаалах зэрэг экологийн ач холбогдлыг үнэлсэн экосистемийн үйлчилгээний төлбөрийг бий болгон мөрдөх.</p>
	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого	<p>2.4.1.1. эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусган уялдуулж, нэгдсэн зохицуулалттайгаар хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлснээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах;</p> <p>2.4.1.2. хот, суурин, уул уурхайн бүс нутгийн агаар, ус, хөрсний бохирдлын шалтгаан, үр дагаврыг тандах, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг бууруулах, арилгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>2.4.2.1. эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах;</p>
	Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар Баримтлах бодлого	<p>4.1.6.төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагад үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрт оролцох, туршилт-үйлдвэрлэл эрхлэх боломжийг бий болгох;</p> <p>4.1.7.бүс болон орон нутгийн онцлогийг харгалзан эрдэм шинжилгээний төв, хүрээлэн байгуулахыг дэмжих;</p> <p>4.2.6.судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p> <p>4.2.7.шинжлэх ухаан, технологийг инновац, бүсчилсэн хөгжил, аж үйлдвэрийн бодлоготой нягт уялдуулан хөгжүүлэх.</p> <p>4.5.1.судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны парк байгуулах;</p> <p>4.5.2.шинжлэх ухаан, технологийн кластер, хотхон байгуулж, татвар, санхүү, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлөөр дэмжих;</p> <p>4.5.3.эрдэм шинжилгээний байгууллагыг зориулалтын барилга байгууламжаар хангаж, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах;</p> <p>4.5.5.салбар дундын судалгааны нэгдсэн, төрөлжсөн лаборатори, үндэсний хэмжээний төв, хүрээлэн байгуулах, чадавхжуулах замаар судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих;</p>
	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн	<p>4.1.2.аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон "Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал"-ыг экосистем, хүн амын</p>

	талаар баримтлах бодлого	нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах; 4.2.2.1.экосистем, геополитик, хүн амын нутагшил, суурьшил, дэд бүтэц, ашигт малтмал, үндсэн түүхий эдийн нөөцөд үндэслэн аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлох; 4.2.5.4.төр, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн дэвшилтэт технологи, инновацыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх тогтолцоог дэмжих.
	Төрөөс инновацын талаар баримтлах бодлого	2.2.1. судалгаа, боловсруулалтын ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн инновацын үйл ажиллагааг хөгжүүлэх; 2.2.4. орчин үеийн аж үйлдвэр, өндөр технологийн салбарт байгальд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай технологийг хөгжүүлэх 4.4.1. төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан инновацын үйлдвэрлэл технологийн дэд бүтэц (технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, бизнес-инкубатор, гарааны компани, шинжлэх ухааны болон өндөр технологийн парк, тоон технологийн зангилаа төв, хамтын оффисууд гэх мэт)-ийг байгуулах, түүнд хөрөнгө оруулалт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	3.2.2. “хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах” чиглэлийн хүрээнд орон нутагт хүн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг урамшуулах замаар хөдөөгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувийг нэмэгдүүлж, хүн амын байршлын зохистой харьцааг хот, хөдөөд тэнцвэртэй болгоно; 4.1.10. хүний эрүүл мэнд, амьдралын чанарын түвшинд сөргөөр нөлөөлж байгаа агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх; 4.2.2. хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлж, хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хот, суурин газар, орон нутгийн тогтвортой хөгжлийг газар зохион байгуулалт, хот байгуулалт, дэд бүтэц, аж үйлдвэр зэрэг бусад салбарын бодлоготой уялдуулах; 4.2.3. хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт, олон улсын стандартад нийцсэн хот, суурин газрыг хөгжүүлж, иргэдийн эрүүл аюулгүй, тохилог амьдрах нөхцөлийг бүрдүүлэх; 4.2.7. нийслэл, хот, суурин газраас орон нутаг руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг урамшуулах; 4.3.6. гэр бүлийг орон сууц, газар болон амьжиргааны олон талт эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх;
	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого	3.1.6.сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт эрчим хүчний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах. 3.2.1.4.хот, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах, дулаан хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх;
	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	1.4.1.уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх; 2.1.9.эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлснээс бусад бэлчээрийг төрийн эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалттайгаар ашиглуулах, эрчимжсэн мал аж ахуйда тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулах; 2.1.10.бэлчээр болон байгалийн бусад нөөцийн зохистой ашиглалт, бэлчээрийн газар зохион байгуулалт, төлөвлөлт, удирдлагын тогтолцоог сайжруулах, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх; 2.1.11.бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл, сүргийн бүтцийг тохируулах эдийн засгийн хөшүүрэг бий болгох, бэлчээрийг оновчтой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

		<p>3.1.8.төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн тариалалтад ус, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй дуслын болон хөрсөн доороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;</p> <p>3.1.13.өвөл, зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлэн хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, хот, суурины хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор тогтвортой хангах.</p>
5	“Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны хөтөлбөр” – 13 заалт	<p>4.1.1.2. Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймгийн төвүүдийн 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон шинээр төлөвлөх, тэдгээрийг хэрэгжүүлэх;</p> <p>4.1.2.4.Улаанбаатар хот, аймаг, орон нутгийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжид технологийн шинэчлэл хийх, шинээр барьж ашиглалтад оруулах;</p> <p>4.1.2.5.Улаанбаатар хотын авто замыг шинэчлэн сайжруулах, Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй, аймгийн төвийг ойролцоох хилийн боомттой холбосон улсын болон олон улсын чанартай авто замын сүлжээг бий болгох;</p> <p>4.1.5.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр: 4.1.5.2.гэр хорооллын айл өрхийн зуух-яндан-түлшний бүтэц, шаталтын технологийг өөрчлөн сайжруулах, нам даралтын уурын зууханд технологийн шинэчлэл хийх, гэр, орон сууцны дулаалгыг сайжруулах замаар түүхий нүүрсний хэрэглээг багасгаж, утаа, тортгийн ялгаралтыг 50 хүртэл хувиар бууруулах;</p> <p>4.1.5.4.хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн хэрэгслийг байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрт шилжүүлж, авто тээврийн хэрэгслээс ялгарах утааг бууруулах цогц арга хэмжээ авах;</p> <p>4.1.8.1.орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулах, хотын төвлөрөл, эмх замбараагүй тэлэлтийг бууруулах зорилгоор Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, сумдыг цогцоор хөгжүүлэх;</p> <p>4.1.8.3.бүсийн тулгуур төвүүдэд оюутны хотхон шинээр байгуулан Улаанбаатар хотод төвлөрсөн их, дээд сургуулиудын тоог цөөрүүлэх замаар нийслэл рүү шилжин суралцах оюутнуудын тоог бууруулах;</p> <p>4.4.1.4.Улаанбаатар хотын гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;</p> <p>4.4.2.12. Улаанбаатар хотын авто замын 1, 2, 3 дугаар тойрог замыг шинээр бий болгох, тойрог замыг холбосон туслах зам, хотын алслагдсан дүүрэг, шинээр баригдсан орон сууцны цогцолбор хорооллуудыг холбосон авто зам барих, шинэчлэн сайжруулах, Хөшгийн хөндийн нисэх буудалтай холбосон шинээр нийт 212 км авто зам, шинэчилсэн 350 км авто зам, 2 түвшний гүүрэн 7 гарц барих.</p> <p>4.3.6. Улаанбаатар хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоо байгаа гэр хорооллын 557,8 га газрыг чөлөөлөх;</p> <p>4.4.5.1.хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах хорооллуудын нийт талбайн 20 хувиас доошгүй хэсгийг ногоон байгууламжтай болгох;</p> <p>4.4.5.2.гэр хорооллын 2300 га, нийтийн эзэмшлийн 1200 га талбайг зүлэгжүүлж, ойжуулан нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг хот төлөвлөлтийн стандартад хүргэх;</p>
6	“Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” – 6 заалт	<p>4.1.2. нийслэлд шилжин ирэх хөдөлгөөнийг хязгаарлаж, нийслэлийн гэр хорооллын тэлэлтийг зогсоож, яндангийн тоог нэмэгдүүлэхгүй байх;</p> <p>4.1.11. арьс шир, ноос, ноолуур боловсруулах үйлдвэр, авто техникийн болон барилгын материалын захыг нийслэлээс үе шаттай нүүлгэн шилжүүлж, инновацад тулгуурласан ногоон технологи бүхий үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх;</p> <p>4.1.12. хот, суурин газрын орчимд элс, хайрганы олборлолт, үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хязгаарлаж, газрыг нөхөн сэргээх;</p> <p>4.1.13. гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хот, суурин газрын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх;</p> <p>4.2.8. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан</p>

		<p>цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор шинэчлэх; Хүрэх үр дүн. 5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгальд ээлтэй инженерийн дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, агаар, орчныг бохирдуулагч эх үүсвэрийг багасган дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг хязгаарлаж, агаар, орчны бохирдлыг 80 хувиар бууруулна</p>
	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	<p>4.4.3. зорилго 5: экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах; 4.11.1. зорилт 10: газар зохион байгуулалтын улсын болон орон нутгийн төлөвлөгөөнд экосистемийн төлөөлөлд суурилсан тусгай хамгаалалттай газар нутгийг тусган сүлжээг өргөтгөж бэхжүүлэх; 4.11.2. зорилт 11: талуудын оролцоонд тулгуурласан тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, чадавхыг сайжруулах; 4.18.1. зорилт 24: биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа эдийн засгийн хөшүүргийг бууруулах арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх; 4.18.2. зорилт 25: биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглахыг дэмжих эдийн засгийн механизмыг боловсруулж хэрэгжүүлэх 4.19.2. зорилт 27: экосистемийн үйлчилгээний төлбөр (цаашид “ЭҮТ” гэх)-ийг нэвтрүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх. 4.20.2. зорилт 29: биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн орлогын эх үүсвэр (тухайлбал: экологийн үйлчилгээний төлбөр, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал)-ийг тодорхойлж нэвтрүүлэх.</p>
	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	<p>3.2.7.төвлөрсөн, томоохон хот, суурины ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх; 3.2.16. Хойд мөсөн далайн ай сав болон мөстлийн усны нөөц хуримтлуулах сангуудыг байгуулж эхлэх; 3.2.17.бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах ажлыг өргөжүүлэх; 3.2.20.газрын доройтол, цөлжилтийг сааруулах арга хэмжээг өргөжүүлэх; 3.2.25.хот, сууринд үерийн хамгаалалтын далан, суваг, инженерийн барилга байгууламжийг өргөжүүлэх, усыг дахин ашиглах технологийн шийдлийг боловсруулан хэрэгжүүлэх. 3.3.14.хотын замын хөдөлгөөний зохицуулалтыг сайжруулах, нягтралыг багасгах арга хэмжээ авах; 3.3.19.газар ашиглалтыг сайжруулж, атаршсан газрыг сэргээн ашиглах явдлыг өргөжүүлэх, шинээр газар хагалахыг хязгаарлах арга хэмжээ авах, уул уурхайн газрын нөхөн сэргээлтийг сайжруулах; 3.3.20.ойжуулах, ойг нөхөн сэргээх болон ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, хүлэмжийн хийн шингээлтийг сайжруулах;</p>
	Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	<p>2.2.1. аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх; 2.2.2. аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх; 2.2.5. аялал жуулчлалын салбарын гадаад хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх; 2.2.6. дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх. 2.3.1. үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөр буюу үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн хөгжлийн бодлоготой нийцсэн байх; 2.3.2. аялал жуулчлалын үйл ажиллагааг Монгол орны байгалийн унаган төрхийг хадгалах, орчны бохирдлыг багасгах, экологийн тэнцвэрт байдал, хүний эрүүл, аюулгүй орчинд аялах нөхцөлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулах;</p>

		<p>4.1.5. жуулчдын зорин очих дуртай газруудын төлөвлөлт, менежментийг сайжруулах, дэд бүтцийн асуудлыг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэх.</p> <p>4.2.1. аялал жуулчлалыг Монгол орны байгаль, түүх, соёлын үнэт өв, нүүдэлчин ахуй, уламжлалт зан заншлыг тусгасан өөр өөрийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгаатайгаар бүсчлэн хөгжүүлэх;</p> <p>4.2.2. аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжиж, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг тухайн бүс нутгийн онцлогт тулгуурлан бий болгох;</p> <p>4.2.3. соёлын өв, түүх, соёлын дурсгалт газарт суурилсан соёлын аялал жуулчлалын шинэ үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;</p>
	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	<p>4.3.6. хот, суурины хүн амын хүнсний хэрэгцээнд эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэн нийлүүлэх сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний хангамж, хүртээмж, хүнсний аюулгүй байдлын баталгааг сайжруулах үйл ажиллагаанд бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;</p> <p>4.3.7. эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, гурилын үйлдвэрүүдийг түшиглэн бүс нутгийн хэмжээнд тэжээл үйлдвэрлэл, тэжээл хүргэлтийн үйлчилгээний л</p> <p>4.4.1. бүс нутгийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн паркийн системд эрчимжсэн мал аж ахуйн кластерыг хөгжүүлэх; логистикийг хөгжүүлэх;</p>
	Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр	<p>3.1.1.өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулахад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурины хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах;</p> <p>3.1.4.хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургацын чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таримлын ургалтын үеийн био, органик, эрдэс бордоог хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>3.2.3.өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</p> <p>3.2.4.хүнсний ногооны үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу гэр бүл, залуучуудад гарааны болон санхүүгийн дэмжлэг олгож, ажлын байртай болгох, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;</p> <p>3.2.5.хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд халгүй, хямд төсөр усалгааны арга болох дуслын усалгаа, хөрсөн дотроос нэвчүүлэх усалгаа зэрэг дэвшилттэй технологи нэвтрүүлэх;</p> <p>3.2.7.услалтын системийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;</p> <p>3.2.10.таримлын төрөлд зохицсон зориулалтын зоорь, агуулах байгуулах иргэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, импортыг бууруулах;</p> <p>3.2.12.нийслэлийн дүүргүүд болон аймгийн төв, хүн ам олонтой томоохон сум, хот, суурин газарт тариалан эрхлэгчдийн санаачилга, оролцоонд тулгуурлан хүнсний ногоог хадгалах, борлуулах ажлыг шууд худалдааны борлуулалтын сүлжээ, төрөлжсөн зах бий болгох асуудлыг шийдвэрлэх;</p> <p>3.3.4.хүнсний ногооны үрийн тариалан эрхлэгчдэд сэлгээний талбай нэмж олгох ажлыг зохион байгуулах;</p> <p>4.3.Аймаг, нийслэлд “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэх салбар зөвлөлийг тухайн шатны Засаг дарга ахлан аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нар салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллана.</p>
	Жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөр	<p>5.1.1.жимс, жимсгэнэ тариалах, хураах, хадгалах, боловсруулах үйлдвэр байгуулах, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;</p> <p>5.1.5.жимс, жимсгэнийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, услалтын систем шинээр байгуулах, орчин үеийн дуслын усалгааны тоног</p>


		<p>төхөөрөмж суурилуулах, тариалалт, хөрс боловсруулалт, хураалтыг механикжуулах, суулгац худалдан авах иргэд, аж ахуйн нэгжид санхүүгийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p> <p>5.1.8.жимс, жимсгэнийн өртгийн сүлжээг хөгжүүлэх, түүний байршил, хамрах хүрээ, үе шат, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан бүс нутгийн нөөц, байгаль цаг уурын онцлог, дэд бүтэц, логистик, жижиг, дунд үйлдвэрийн хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлэх;</p> <p>5.1.9.жимс, жимсгэнийн кластерийн гол оролцогч болон хамтрагч, тариалагч хооронд үүрэг, хариуцлагыг нарийвчлан хуваарилах, логистик, тээвэр, банк, санхүүгийн байгууллага, даатгал, боловсрол, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоог хангах;</p> <p>5.1.13.жимс, жимсгэнийн тариалалтын талбайг тордон хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өрх хашаанд жимсний мод бут, тэр дундаа чацаргана тариалах иргэдийг дэмжих;</p> <p>5.2.2.алим, чавга, интоор, чацаргана, үхрийн нүд, нэрс, гүзээлзгэнэ, бөөрөлзгөнө, хад зэрэг жимс, жимсгэнийн сортын суулгацын ил талбайн болон хүлэмжийн эх цэцэрлэг, үржүүлгийн загвар аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн бэлтгэсэн суулгацыг худалдан авч, жимс, жимсгэнэ тариалах иргэн, аж ахуйн нэгжид тодорхой хувийн хөнгөлөлттэй үнээр болон урт хугацаатай зээлээр олгох;</p> <p>5.3.1.орчин үеийн технологид суурилсан хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлж, дулаан нөхцөл шаарддаг усан үзэм, тоор, лийр, нимбэг, гүзээлзгэнэ, анар, улаан чавга зэрэг жимс, жимсгэнийг нутагшуулах, тариалалтыг нэмэгдүүлэх;</p> <p>5.3.3.жимс, жимсгэнийн тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сортын суулгац үржүүлэг, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг цогцоор нь боловсруулах;</p> <p>5.3.7.жимс, жимсгэнийн талбайд хамгаалах ойн зурвасыг байгуулж, тариалах агро технологийг боловсруулах, тэдгээрийг хэвшүүлэх;</p> <p>5.3.7.жимс, жимсгэнийн талбайд хамгаалах ойн зурвасыг байгуулж, тариалах агро технологийг боловсруулах, тэдгээрийг хэвшүүлэх;</p> <p>5.4.“Салбарын маркетингийн стратегийг боловсруулж, дотоод болон гадаадын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинэ зах зээлд нэвтрэх ажлыг эхлүүлэх” зорилтын хүрээнд:</p> <p>5.4.6.эх орны хөрсөнд тарьж ургуулсан экологийн цэвэр жимс, жимсгэнэ, чацарганын үнэ цэнийг дээшлүүлж, үйлдвэрлэгчид болон борлуулагч, хэрэглэгчдийг холбох биржийн арилжаа, үнэ хаялцуулах худалдаа зэрэг шинэлэг дэвшилтэт маркетинг нэвтрүүлэх, төрөлжсөн худалдааны төв байгуулж ажиллуулах.</p>
--	--	---

1.5. БАЙГАЛЬ-НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОР НӨХЦӨЛ, НӨӨЦӨД СУУРИЛСАН НИЙСЛЭЛИЙН ГАЗАР НУТГИЙН ЯЛГАРАЛ ГЗБЕТ-ИЙН ШИЙДЛИЙН СУУРЬ ҮНДЭСЛЭЛ

2003 онд батлагдсан улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний суурь нөхцөлийг боловсруулах хүрээнд /Ланрес ХХК/ Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг ландшафт-экологийн хандлагын үүднээс бүсийн нийтлэг зүй тогтолд тулгуурлах зарчмыг баримтлан бүс нутгуудыг ялгаж түүнийг байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлөөр нь мужуудад, хотгор гүдгэрийн ялгаа, түүнтэй уялдан илрэх газар ашиглалтын онцлогийг харгалзан Хангай, Говийн, Тал хээрийн гэсэн 3 бүс нутагт хуваасан ба 2-р түвшинд 12 муж, 3-р түвшинд 31 тойрогт тус тус хувааж төлөвлөсөн байдаг ба 2019 онд шинэчлэн баталсан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хэвээр нь ашигласан байдаг.

Ландшафт нь геологийн тогтоц, газрын гадаргын төрх байдал, уур амьсгал, гадаргын ба гүний ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг зэрэг олон элементийн нийлбэр нэгдлийн хувьд дор бүрнээ өвөрмөц шинж байдалтай тодорхой орон зайд нийтлэг илрэх, өөрийн өвөрмөц тогтоцтой газар зүйн бүрхэвчийн хэсгийг хэлэх бөгөөд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө тухайн хэсэг ялгарлын онцлогт суурилан нийгэм-эдийн засгийн хувьд өндөр өгөөжтэйгээр байгаль-нутаг дэвсгэрийг зохистой ашиглах, хамгаалах цогц төлөвлөлтийг хийхэд чиглэнэ.

Зураг 3. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойргийн зураг



Хүснэгт 3. Ангиллын түвшин ба зарчим

1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин
Бүс нутаг	Муж	Тойрог
Газар нутгийг дулаан, чийгийн хангамж, хөрс ургамалжилтын ижил төстэй шинжээр хоорондоо ялгаатай нутгуудад ялгах	1-р түвшний ангиллыг байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлөөр мужуудад ялгах	2-р түвшний ангиллыг ландшафт-экологийн нөхцөл, хотгор гүдгэрийн онцлогийг харгалзан тойргуудад ялгах
3 бүс нутаг	12 муж	31 тойрог

Нийслэлийн нутаг дэвсгэр нь Хангайн бүсийн Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн Х-6, Х-7 тойрог, Хэнтийн нурууны тайга зонхилсон мужийн Х-8, Х-9 тойргууд болон Тал хээрийн бүсийн Дундад халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн мужийн Т-1 тойрогт /зөвхөн Багахангай дүүрэгт/ оршиж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэр нь Монгол орны эдийн засгийн төв бүс нь гаднаас түрж орж ирсэн байгалийн олон мужуудын шилжилтийн зааг дээр орших эмзэг, өвөрмөц экосистемтэй бөгөөд манай орны экологийн тэнцвэрт байдлыг тогтвортой байлгахад онцгой үүрэгтэй нутаг юм. Энд нэг талаас Азийн хэв шинжийн байгалийн цогцолборууд харилцан түрж нэвтрэлцсэнээс гадна өмнөд Сибирийн байгалийн нэг хэсэг байдгаараа онцлогтой.

Улаанбаатарын эдийн засгийн бүс нь гаднаас түрж орж ирсэн байгалийн олон мужуудын шилжилтийн зааг дээр орших эмзэг, өвөрмөц экосистемтэй бөгөөд экологийн тэнцвэрт байдлыг тогтвортой байлгахад онцгой үүрэгтэй нутаг юм. Энд нэг талаас тал хээрийн байгалийн цогцолборууд харилцан түрж нэвтрэлцсэнээс гадна өмнөд Сибирийн байгалийн мужийн нэг хэсэг Сибирийн их тайгын шууд үргэлжлэл болсон тайгын өвөрмөц төлөөллийг бүрэн хадгалсан Хэнтийн тайга байдгаараа онцлогтой.

Хотгор гүдгэрийн тархалтын хувьд газрын гадарга нь зүүнээс баруун тийш намсаж нутгийн зүүн хойд хэсгээр орших Хэнтийн нурууны эртний мөстлийн ул мөр бүхий бөмбөгөрдүү оройтой уул болон сул, сулавтар хэрчигдсэн налуу хажуутай дундаж өндөр улс, нам уулс, Туул голын цэвдэгт хөндий, элэгдлийн болоод өргөгдлийн суурьт тэгш тал зэрэг хотгор гүдгэрийн олон хэлбэрүүд хосолсон тогтоцтой байгалийн өвөрмөц нөхцөл бүхий нутаг юм.


Нийслэлийн нутаг дэвсгэр дэх газрын газрын чадавх, нөөц байгалийн баялгийг урт хугацаанд зохистой ашиглах, газрыг ландшафтын хэмжээнд нь хамгаалах, сэргээн сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ландшафт-экологийн 8 бүс байхаар төлөвлөв.

1. Нөлөөнд сулавтар өртөж байгаа хамгаалалт тогтоосон, цаашид барилгажилтыг хориглох бүс газар. /ТХГН-ийн ашиглалтад сул өртсөн газар, хэвийн хэмжээнд байгаа гол усны хамгаалалтын бүс газар, хэвийн хэмжээнд буй ойн сангийн газар, ашиглалтад өртөөгүй ногоон бүс, ойн зах гэх мэт газар/

2. Тариаланд болон таримал хадлан, бэлчээрт тохиромжтой, цаашид эрчимжсэн, суурин ХАА-г хөгжүүлэх бүс газар./ 20 см-ээс дээш зузаан хөрсөн давхарга бүхий 1 -ээс дээш хувийн ялзмагийн агууламжтай газар/
3. Нөлөөнд сул, дунд зэрэг өртөж байгаа байгалийн бэлчээр, хадланд тохиромжтой, цаашид уламжлалт бэлчээрийн МАА эрхлэх ашиглалтын бүс газар./хэвийн хэмжээнд ашиглагдаж буй байгалийн хадлан, бэлчээрийн газар/
4. Нөлөөнд дунд зэрэг болон дундаас дээш өртсөн, цаашид нөхөн сэргээж зохистой ашиглах боломжтой бүс газар./
5. Нөлөөнд дунд зэргээс хүчтэй өртөж байгаа ачаалал ихтэй, цаашид ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ачааллыг бууруулах, экологийн төлбөрт хамаарах бүс газар
6. Нөлөөнд хүчтэй өртсөн, цаашид ашиглалтыг хязгаарлаж, экологийн төлбөр, нөхөн төлбөрт хамруулж экосистемийн хэмжээнд нөхөн сэргээх шаардлагатай бүс,
7. Уул уурхайд хэвийн хэмжээнд ашиглагдаж буй болон уул уурхайн ашиглалтад өртсөн, цаашид нөхөн сэргээх, газарт учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, экологийн өндөр шатны төлбөр тогтоох бүс газар,
8. Нөлөөлөлд хүчтэй өртсөн элсжиж байгаа, цаашид консервацид авах, экологийн өндөр шатны төлбөр тогтоох бүс газар

Нийслэлийн ГЗБЕТ-нд ХАА, ой, усны бүхий газрын ландшафтад суурилсан төлөвлөлтийг нийслэл, хот, дүүргийн хэмжээнд ландшафтын ангилал зүйн нэгжүүдээр газар нутаг, урочицын түвшинд төлөвлөгөө боловсруулав.

Зураг 4. Нийслэлийн нутаг дэвсгэрийн ландшафт, газар нутаг, урочишийн фон зураг




Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг хийхэд эдгээр муж тойргуудыг урочишийн /ялгаатай нутаг дэвсгэр/ төрлүүдээр ангилан хувааж төлөвлөлтийг гүйцэтгэсэн ба дараах ялгарлуудад хуваасан. Үүнд:



Хүснэгт 4. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойрог дахь нутаг дэвсгэрийн ялгарлууд

Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойрог	Нутаг дэвсгэрийн ялгарал
Хангайн бүсийн Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн Х-6 тойрог Нийт 21 ялгарал	Багахангай дүүргийн хойт хэсэг Х-6-БХ-001 ээс Х-6-БХ-008 хүртэлх 8 ялгарал
	Налайх дүүргийн урд Багабаян уул орчмын нутаг Х-6-НА-001 ээс Х-6-НА-005 хүртэлх 5 ялгарал
	Нийслэлийн баруун-урд хэсэг /Нисэх, Шувуун фабрик, Эмгэнт уул, Эмээлт уул орчмын нутаг Х-6-УБ-001 ээс Х-6-УБ-001 хүртэлх 8 ялгарал
Хангайн бүсийн Орхон-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн Х-7 тойрог Нийт 7 ялгарал	Нийслэлийн нутаг дэвсгэрийн Баруун хойт хэсэг Хүйн хөндийгөөс хойших нутаг Х-7-УБ-001 ээс Х-7-УБ-007 хүртэлх 7 ялгарал
Хангайн бүсийн Хэнтийн нурууны тайга зонхилсон мужийн Х-8 тойрог	Багануур дүүргийн хойт хэсэг Бор өндрийн нуруу, Баруун залаа уул орчмын нутаг Х-8-БН-001 ээс Х-8-БН-003 хүртэлх 3 ялгарал

Нийт 4-н ялгарал	Налайх дүүргийн хойт зах хэсэг Тэрэлж, Туул голын хөндийн орчмын нутаг Х-8-НА-001 /1 ялгарал/
Хангайн бүсийн Хэнтийн нурууны тайга зонхилсон мужийн Х-9 тойрог Нийт 116 ялгарал	Багануур дүүргийн нутаг дэвсгэр Байдрагийн гол түүнээс урагш хэсэг, Хүнхэр улаан уул, Нарийн ухаа, Нарийн тал, Нугын тал, Төмөр өлгий уул зэрэг ихэнх нутаг дэвсгэр Х-9-БН-001 ээс Х-9-БН-014 хүртэлх 13 ялгарал
	Нийслэлийн нутаг дэвсгэрийн төвийн 6-н дүүргийн нийт нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг хамрах ба Туул голын хөндийгөөс хойших нутаг дэвсгэр Х-9-УБ-001 ээс Х-9-УБ-074 хүртэлх 74 ялгарал
	Нийслэлийн нутаг дэвсгэрийн төвийн 6-н дүүргийн нутаг дэвсгэрийн Туул голын хөндий, түүнээс урагших нутаг дэвсгэр Х-9-УБ-075 аас Х-9-УБ-108 хүртэлх 34 ялгарал
Тал хээрийн бүсийн Дундад халхын болон Дорнод Монголын талархаг хээрийн мужийн Т-1 тойрог Нийт 2 ялгарал	Дундад халхын болон дорнод монголын талархаг хээрийн мужын Т-1 тойрог, Багахангай дүүргийн урд хэсэг Т-1-БХ-001, Т-1-БХ-002 нийт 2 ялгарал
Нийт 2 бүсийн 3-н муж, 5-н тойрог 154 нутаг дэвсгэрийн ялгарал	

Зураг 5. Дүүргүүдийн Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойрог дахь нутаг дэвсгэрийн ялгарлууд





Хүснэгт 5. Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн муж, тойрог дахь газар нутгийн ялгарлууд, тэдгээрийн онцлог, Газар ашиглалтад тавигдах ерөнхий нөхцөл, шаардлага, хязгаарлалт

Байгаль дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн тойргийн байршил	нутаг муж, нэр,	Нутаг дэвсгэрийн ялгарлын дугаар	Эзлэх талбай	Газар нутгийн ялгарлын нэршил, онцлог	Газар ашиглалтад тавигдах ерөнхий нөхцөл, шаардлага, хязгаарлалт
Дундад халхын болон дорнод монголын талархаг хээрийн мужийн Т-1 тойрог, Багахангай дүүргийн урд хэсэг		T-1-БХ-001	1398.08	Өндөр толгойн урд тэгш талархаг хэсэг, Гадаргын усны сүлжээгүй, элсэнцэр Цайвар хүрэн хөрстэй, Хазаар, хялганат ургамлан нөмрөгтэй, Багахангай дүүргийн үйлдвэрийн бүс байршдаг. Өндөржилт 1440-1460м	1.Зонхилох салхины доод тал нь задгай учир агломераци, суурьшлын зориулалтаар газар ашиглалтыг нэмэгдүүлэх боломжтой, таатай орчинтой 2.Ус их хэмжээгээр шаарддаг үйлдвэрлэл, үйлчилгээ байршуулахад дэмжих боломж муутай, эрсдэл өндөртэй. Усны үндсэн хэрэглээгүй буюу бага хэрэглээтэй үйлдвэр үйлчилгээ явуулахад тохиромжтой. 3.Экологийн эмзэг газар нутаг. Хөрсийг элэгдлээс хамгаалах, ногоон байгууламжийг газар ашиглалтын шалгуур болгох шаардлагатай. 4. Агаар хөрс, усны бохирдол багатай.
		T-1-БХ-002	1543.98	Төмөр замаас зүүн тийш тэгш талархаг газар бөгөөд газар нутгийн дунд хэсгээр Баруун уртын гол урсах ба байнгын урсацгүй, Багахангай дүүргийн төмөр замын өртөөний суурьшил, худалдаа үйлдвэрлэлийн бүс байршдаг. элсэнцэр хүрэн хөрстэй, Хазаар, хялганат ургамлан нөмрөгтэй, Өртөөний суурьшлын орчимд болон түүний урд хэсэгт дүүргийн бохир ус хуримтлах нуур байх ба түүний орчимд гадаргын усны хуримтлал үүсдэг. Өндөржилт 1440-1480м	1.Зонхилох салхины доод тал нь задгай учир агломераци, суурьшлын зориулалтаар газар ашиглалтыг нэмэгдүүлэх боломжтой, таатай орчинтой 2.Ус их хэмжээгээр шаарддаг үйлдвэрлэл, үйлчилгээ байршуулахад дэмжих боломж муутай, эрсдэл өндөртэй. 3.Экологийн эмзэг газар нутаг. Хөрсийг элэгдлээс хамгаалах, ногоон байгууламжийг газар ашиглалтын шалгуур болгох шаардлагатай. 4. Агаар хөрс, усны бохирдол багатай. 5.Баруун уртын гол дагуу болон бохирын усны нуур орчим цэцэрлэгт хүрээлэн ой зурвас байгуулахад экологийн нөхцөл боломжийн
Орхо-Сэлэнгийн савын ойт хээрийн мужийн Х-6 тойрог, Багахангай дүүргийн хойт хэсэг		X-6-БХ-001	1551.77	Багахангай дүүргийн баруун хэсгийн багавтар нурууны баруун хэсэг дэх түр урсацтай гол бүхий хөндий, Элсэнцэр хүрэн хөрс, Хялгана-хазаарт ургамлын бүлгэмдэлтэй, өндөржилт 1480-1520м бөгөөд зүүн талын нуруунаас жижиг сайр судгууд орж ирдэг	1.Зонхилох салхины доод тал нь задгай хэдий ч агломераци, суурьшлын зориулалт хэрэгцээнд газар ашиглалтыг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал, 2.Ус их хэмжээгээр шаарддаг үйлдвэрлэл, үйлчилгээ байршуулахад дэмжих боломж муутай, эрсдэл өндөртэй. 3.Экологийн эмзэг газар нутаг. Хөрсний элэгдэл үүсэж гуу үүсэх өндөр эрсдэлтэй. Хөрсийг элэгдлээс хамгаалах, ногоон

			байгууламжийг газар ашиглалтын шалгуур болгох шаардлагатай. 4. Агаар хөрс, усны бохирдол багатай. 5.Бэлчээрийн мал аж ахуйн зориулалтаар ашиглах, газрын хамгаалах, нөхөн сэргээх
X-6-БХ-002	2885.51	Багахангай дүүргийн баруун хэсгийн багавтар нурууны баруун тал дахь жижиг толгод бүхий урдаасаа хойш өндөрссөн, үргэлжилсэн нуруу, Уулын хүрэн хөрстэй, үетэн харганат, хялгана-Агьт ургамлан нөмрөгтэй, өндөржилт 1520-1600м хүртэл байх бөгөөд хамгийн өндөр цэг нутгийн хилийн хойд зах 1614.2м өндөр бүхий толгой, өмнөд хэсгийн өндөрлөг цэг 1513.1 м бүхий Өндөр толгой нэртэй толгой байна.	1. Одоогоор ашиглалт багатай цаашид хот орчмын тусгай зохицуулалттай бэлчээрийн МАА эрхлэх зориулалтаар ашиглагдах боломжтой. 2. Суурьшлын зориулалт хэрэгцээнд газар ашиглалтыг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал 3. Хүн, машин техникийн нөлөөгөөр зам харгуй үүсэх, талхагдал өртөх өндөр эрсдэлтэй 4. Гал түймрийн эрсдэлээс сэргийлэх, газар хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
X-6-БХ-003	1323.37	Бор тал нэртэй газар бөгөөд төмөр замын баруун хэсэг ХАА-н үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдаж байгаа. Тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн Хазаар өвс- хялганат ургамлын бүлгэмдэлтэй, өндөршил 1480-1510м	1. Одоогоор ашиглалт багатай цаашид хот орчмын тусгай зохицуулалттай бэлчээрийн МАА эрхлэх зориулалтаар ашиглагдаж байна, цаашид эрчимжсэн суурин ХАА хөгжүүлэх боломжтой. 2. Суурьшлын зориулалт хэрэгцээнд газар ашиглалтыг нэмэгдүүлэх боломжтой 3. Хүн, машин техникийн нөлөөгөөр зам харгуй үүсэх, талхагдал өртөх өндөр эрсдэлтэй 4. Гал түймрийн эрсдэлээс сэргийлэх, газар хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эрчимжсэн суурин ХАА хөгжүүлэх тохиолдолд эмзэг хөрстэй тул агро техникийн арга хэмжээг сүүлийн үеийн дэвшилтэд технологиор боловсруулалт хийж доройтолд өртөхөөс сэргийлэх
X-6-БХ-004	1267.45	Бол талын дундуур гарч буй төмөр замын зүүн хэсэг бөгөөд цахим өмчлөл явуулж иргэдэд олгосон боловч суурьшил үүсээгүй, нэгж талбарыг тэмдэгжүүлсэн дугуйнууд газарт зоосон байдалтай байна. Хазаар өвс- хялганат ургамлан бүлгэмдэлтэй. Элсэнцэр хүрэн хөрс тархсан. өндөршил 1490-1530м	1. Цахим газар олголт хийгдэж иргэдэд өмчлүүлсэн боловч одоогоор суурьшил үүсээгүй ашиглалт багатай. 2. Дэд бүтэц хөгжүүлж суурьшлын зориулалт хэрэгцээнд газар ашиглалтыг нэмэгдүүлэх боломжтой 3. Хүн, машин техникийн нөлөөгөөр зам харгуй үүсэх, талхагдал өртөж байгаа 4. Гал түймрийн эрсдэлээс сэргийлэх, газар хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
X-6-БХ-005	1806.17	Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газар ихэнх хэсгийг эзлэн орших ба хашаалсан, доройтолд	1. Зүүн хэсэг улсын тусгай хэрэгцээний газарт хамаарах ба баруун хэсэгт Багахангай дүүрэг байршдаг. Газар ашиглалт эрчимтэй явагдаж байна.

			<p>өртсөн талбай ихтэй. Хазаар өвс-хялганат ургамлан бүлгэмдэлтэй. Элсэнцэр хүрэн хөрс тархсан. өндөршил 1460-1480м</p>	<p>2. Тусгай хэрэгцээний газрын хамгаалалтын бүсийн дэглэмтэй харшлахгүй хэсэгт суурьшлын зориулалт хэрэгцээнд газар ашиглалтыг нэмэгдүүлэх боломжтой</p> <p>3. Хүн, машин техникийн нөлөөгөөр зам харгуй үүсэх, талхагдал өртөж байгаа</p> <p>4. Ашиглалт багатай газруудад гал түймрийн эрсдэлээс сэргийлэх, газар хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p>
	X-6-БХ-006	536.80	<p>Төмөр замын өртөөний орчмын суурьшил бүхий газар нутаг бөгөөд талхагдалд өртөж байгаа. Хазаар өвс- хялганат ургамлан бүлгэмдэлтэй. Элсэнцэр хүрэн хөрс тархсан. өндөршил 1460-1480м</p>	<p>1. Хүн амын суурьшил ихтэй, газар ашиглалт идэвхтэй явагддаг. суурьшлыг тэлэх нөөц хомс</p> <p>2. Талхагдал доройтолд өртөж байгаа, хот суурины газрын хөгжүүлэлтийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай</p> <p>3. намагжилт болон үерийн эрсдэл хамгаалах, газар хөгжүүлэлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p>
Газрын сангийн нэгдмэл байдал алдагдсанаас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан “Монгол Улсын газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоно.” гэсэн заалтыг хэрэгжүүлж чадахгүй байна.	Газрын сангийн нэгдсэн бодлого, удирдлага алдагдаж үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл нэмэгдэх магадлалтай.
Сүүлийн жилүүдэд гарсан хууль тогтоомжуудад газрын харилцаа, ГЗБ-н эрх мэдлийг салбарын яам агентлагууд тус тусдаа хэрэгжүүлэхээр тусгаснаас салбар хооронд үл ойлголцол үүсэх, ажлын давхардал, хийдэл, хүнд суртал үүсэх, хөрөнгө оруулалт саатах зэрэг сөрөг асуудал үүсэж байна.	Төр, засаг нийгмийн/нийтийн зориулалттай өмч, эд хөрөнгө, баялгаа нэгтгэн удирдах чадвараа алдаж хэсэг бүлгийн эрхшээлд орох эрсдэлтэй.
Газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах асуудлыг шийдвэрлэхэд хангалттай биш нөлөө үзүүлж байна.	Нийслэлд газрын нийгэм, эдийн засгийн суурь харилцаа, ажилгүйдэл ядуурлыг суурь зохицуулалт хэрэгжихгүй, тогтвортой хөгжлийн зарчим алдагдах эрсдэлтэй.

Хүснэгт 7. Улаанбаатар хотын геоэкологи, хүрээлэн буй орчны өнөөгийн нөхцөл байдалд хийсэн SWOT шинжилгээ

Давуу тал	Боломж
Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж байгаа	Дагуул хот суурин байгуулж төвлөрлийг бууруулах боломжтой.
Агаарын бохирдлын хэмжилт, судалгаа хариуцсан бие даасан байгууллагатай	Агаарын бохирдлын байдалд байнгын хяналт тавих нөхцөл бүрдсэн
Газрын мониторингийн сүлжээ байгуулж төлөв байдлын өөрчлөлтийг хянаж байгаа	Газрын доройтлыг хянах, арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах нөхцөл бүрдэж байгаа.
Хотыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжиж байгаль орчныг бохирдуулагч гэр хорооллын өрхүүд орон сууцанд орж байгаа	Цаашид уг төслийг өргөжүүлэх боломж бүрдэж байгаа
Инженерийн дэд бүтцийн дэд төвүүдийг гэр хороололд байгуулж эхлээд байгаа	Гэр хорооллын өрхүүд инженерийн шугам сүлжээнд холбогдох нөхцөл боломж бүрдэж байгаа
Сул тал	Аюул, эрсдэл
Агаарын бохирдол, хөрсний нянгийн бохирдол хүлцэх хэмжээнээс хэд дахин хэтэрч гамшгийн хэмжээнд хүрсэн.	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах Үндсэн хуулийн эрх зөрчигдөж байгаа.

Газар, агаар, хөрс, усны бохирдол, биологийн олон янз байдлын хомсдол нь экосистемийн доройтол болж хувирсан.	Геосистемийн хэмжээнд авч үзэж шийдвэрлэхгүй бол хэсэгчилсэн арга хэмжээ нь үр дүн муутай болж хөрөнгө хүч, цаг хугацаа үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй.
Хүн амын хэт төвлөрөл, газар, байгалийн баялгийн ашиглалтаас үүссэн экологийн доройтлын нөхцөл байдал нь УБ хотын нутаг дэвсгэрийн байгалийн аясаар өөрөө цэвэрших боломж, чадавхаас хэд дахин давсан байна.	Хүн амын хэт төвлөрөл, газар, байгалийн баялгийн ашиглалтаас үүссэн нөхцөл байдал нь үндэсний аюулгүй байдал алдагдах, эдийн засаг, экологийн гүн хямралд нэрвэгдэх аюул, эрсдэл ойрхон байна..
Улаанбаатар хот нь 4 уулын дунд агаарын урсгал түгжигдэх газар зүйн байршилтай тул агаарын бохирдол хадгалагдан тогтох нөхцөлийг бүрдүүлж байна.	Байгаль нутаг дэвсгэр, хүрээлэн буй орчны даац чадавхад нийцсэн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг тогтоох, хязгаарлах арга хэмжээ авахгүй бол эрүүл мэнд, хөрөнгө мөнгөний асар их хохирол учрах эрсдэлтэй байна.
Улаанбаатар хотод орох хур тунадас нь Зүүн өмнөд ази, Буриадын хотуудад ордог хур тунадаснаас хэд дахин бага	Газар ашиглалт, хот байгуулалт, төлөвлөлтөд агаар хөрс усны бохирдлын хур тунадсаар цэвэрших процессыг тооцохгүй бол экологийн доройтол хэвээр үргэлжлэх эрсдэлтэй.

1.7. НИЙСЛЭЛИЙН ГЗБЕТ-НИЙ ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ГАЗРЫН УХААЛАГ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

1.7.1. Газрын засаглалыг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шийдэл.

1. Нийслэлийн ГЗБЕТ-г боловсруулах, хэрэгжүүлэхэд газрын засаглалын өнөөгийн байдлыг үнэлэх, ирээдүйн төсөөллийг тодорхойлох нь уг төлөвлөгөөний ач холбогдол, хувь заяаг шийдэх тулгуур арга хэмжээ бөгөөд Газар зохион байгуулалт гэсэн ойлголтод Газрын тухай хуулийн 24.1-д " зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх..." гэж газар зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээний нэг болгон тодорхойлсон байдаг. Газрын харилцаанд оролцогч этгээдүүдийн эрхлэх ажил, эрх үүргийг боловсронгуй болгох үүднээс газрын эрх бүхий этгээдийн нийгмийн өмнө хүлээн үүрэг, хариуцлагыг ил тод тодорхой болгох арга хэмжээг төлөвлөв

2. Ардчилсан засаглалын нэг гол тулгуур нь иргэдийн оролцоог нийгэм, эдийн засгийн харилцаанд оролцуулах эрхийг хангаж байдаг. Монгол улсын иргэдийн оролцоотой газрын засаглалыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөв.

3. Газрын засаглалыг хэрэгжүүлэх хүний болон техникийн нөөц, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг төлөвлөв.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1. Үндсэн хууль, Иргэний хууль, Газрын тухай хууль зэрэг газрын бусад хууль тогтоомжид нийцүүлэн газрын өмчийн болон узуфрукт эрх, бусдын газар дээр барилга барих эрх, кондоминиум эрх, сервитутын эрх, концесс, түрээсийн гэрээгээр ашиглах эрх зэрэг бусад эрхийн төрлүүдийг хэрэглэх журам зааврыг боловсруулан батлуулж мөрдөх

2. Газар ашиглах олон зориулалт, төрлийг системчлэн ангилах ангилал зүйн тогтолцоог боловсруулан батлуулж мөрдөх

3. Хуульд 15 жилээс доош хугацаагаар ашиглахаар гэрээ байгуулахаар заасан тохиолдолд газар дээр үл хөдлөх хөрөнгө барих, бүртгүүлэхийг хориглох журам, зааврыг боловсруулан батлуулж мөрдөх

4. Нийслэлийн газар, хүн хүч, хөрөнгө санхүү болон байгалийн нөөц, чадавхыг тооцсон газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийсэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг ногоон хөгжлийн агуулга, зарчимд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх хөгжил, чадавхыг бүрдүүлнэ.

5. Газар, байгалийн бусад нөөцийн ашигласны төлбөр, татварыг өмчлөгчийн үр шимийг хүртэх хувь хэмжээ, ногоон эдийн засгийг дэмжих экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ, даацыг зохицуулах газрын үнэлгээний оновчтой арга хэрэгсэл, хөшүүргийг нэвтрүүлж бүхий, байгаль хамгаалал, үйлдвэрлэл үйлчилгээ, цэвэр технологи, хөрөнгө оруулалтыг газрын менежментийн бодлогоор дэмжих.

6. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг дэмжиж, ногоон ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг дэмжих нутаг дэвсгэрийн маркетингийг хөгжүүлж, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

7. Бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.

8. БО-г хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, газар, бэлчээр нутгийн доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг удаан хугацаанд тогтвортой хангана.

Хүснэгт 8. Газрын засаглалыг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шийдэл

Үндэслэл	Төсөл, арга хэмжээний нэр	Засаглалын индексэд тавигдах шаардлага, үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Дэмжлэг үзүүлэх байгууллага,	Ач холбогдол
Газрын тухай хууль. 4 дүгээр зүйл. Төрөөс газрын талаар баримтлах зарчим 20.2.1. нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах; 24.1. Газар зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх... Төрийн албаны тухай хууль	1. Нийслэлээс дүүрэг, хорооны Засаг дарга, НГЗБА, ДГЗБА, албан тушаалтнуудын газрын харилцаа, зохион байгуулалтын талаарх үр дүнгийн гэрээг дүгнэх цахим технологид суурилсан засаглалын индексийг нэвтрүүлэх журам, заавар, арга зүй боловсруулж хэрэгжүүлэх. (Зөвлөх үйлчилгээгээр хэрэгжүүлэх)	1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур 2. төрийн алба, ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ, хариуцлагын шалгуур 3. нутаг дэвсгэр, хүн амын эрүүл мэнд, экологи, хүнсний аюулгүй байдлын шалгуур 4. хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний эрх, нийтийн эрх ашгийг хангах, шударга ёс, хүртээмжтэй, ил тод байдал, хэрэг, зөрчлийн шалгуур 5. газар ашиглалтын нийгмийн үр өгөөж, ногоон орчин, амьдралын чанар, орчны тохижилт, газар хөгжүүлэлтийн шалгуур 6. газрын эд хөрөнгийн болон газар ашиглалтын аж ахуй, эдийн засгийн үр өгөөжийн шалгуур 7. ГЗБ, кадастрын мэргэжлийн ажлын шалгуур,	2022 он	Нийслэлийн ЗДТГ, НГА	ГЗБГЗЗГ, Нийслэлийн ИТХ	1. Хууль дээдлэх зарчим хэрэгжиж тэгш, ил тод, шударга ёс нэвтэрнэ. 2. Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулахад төр, засгийн ажлын үр өгөөж дээшилнэ. 3. ГЗБ, газрын кадастрын ажлын чанар, үр дүн дээшилнэ. 4. Хууль тогтоомж зөрчих, хэрэг, зөрчил, маргаан буурах, газрын маргаанд зарцуулах цаг хугацаа багасна. 5. Дэг журам, зохион байгуулалттай, эмх цэгцтэй газар ашиглалт төлөвшинэ.
МУ-ын Үндсэн хууль. Гуравдугаар зүйл. 1. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.	Газар зохион байгуулалт, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах журам, заавар, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх	1. Газрын асуудлыг хорооны Иргэд Нийтийн Хурлаар хэлэлцэх бэлтгэл ажлыг хангах, дараалал, үе шатны баримт бичгийг боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, санал авах процесс 2. Иргэдээс санал авах, 2. Газрын асуудлыг хорооны Иргэд Нийтийн Хурлаар хэлэлцэх процесс	2022-2036	НИТХ, ДИТХ	ГЗБГЗЗГ,	1. Газар зохион байгуулалт, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл хэрэгжүүлэхэд иргэдийн зүгээс гарах гомдол тэмцэл багасах 2. Эдгээр төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэдийн дэмжлэг,

Газрын тухай хууль. 4.1.6.газар зохион байгуулалтын төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах.		3.Тухайн хорооноос сонгогдсон Иргэдийн төлөөлөгчийн оролцоо, санал хүсэлтийг авах арга хэлбэр 4.Хувь иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах арга хэлбэр, хэлэлцэх, , шийдвэрлэх процесс 5.Иргэд Нийтийн Хурлаас гаргах шийдвэр, тогтоол 6.ГЗБ,хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төслийн нийслэл, дүүргийн ИТХ-д оруулж хэлэлцүүлэх процесс				оролцоо сайжрах ач холбогдолтой.
Газрын тухай хуулийн 27-51дүгээр зүйл	Газрын эрх бүхий этгээдтэй байгуулах, сунгах, гэрээнд нийгмийн хариуцлага, байгаль орчныг хамгаалах үүрэг хүлээлгэх, жил бүр дүгнэх, гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хариуцлага тооцох мэдээллийн сан үүсгэх журам, зааврыг газрын ангилал, ашиглалтын зориулалт, төрлөөр ялгавартай тогтоон шинэчлэн баталж, гэрээг шинэчлэх, мөрдөх.	1.ГЗБ, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлсэн газрын эрх олгох, чөлөөлөх хугацааны шалгуур 2.Газрын эрх бүхий этгээдийн гэрээнд тусгах ирээдүйд бий болзол, тухайн дүүрэг, хороонд үзүүлэх нийгмийн үүрэг, хариуцлагын шалгуур 3.Газрын эрх бүхий этгээдийн гэрээнд газраа бохирдол, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламж, тохижуулалтын ажлыг өөрийн хөрөнгөөр хийх газрын хэмжээ, зардлын хэмжээний шалгуур 4.Хөршийн газар ашиглах эрхийг хангах, хүндэтгэхгүйгээс үүссэн маргааны үр дагавар, төрийн үйл ажиллагаа, хөршид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шалгуур 5.Газрын гэрээг байгуулах, дүгнэх, үнэлэх, хариуцлага тооцох нөхцөл, болзлын шалгуур 6.Газрын эрх бүхий этгээдийн газрын хил залгаа хариуцах орчны газрын зай хэмжээ, хамгаалалтын шалгуур 7.Газар чөлөөлөх нөхцөл, болзол, эс үйлдлээс учирсан хор уршгийг мөнгөн үнэлгээгээр үнэлэх, төлүүлэх, хугацаанаасаа өмнө чөлөөлсөн этгээдэд урамшуулал олгох шалгуур	2022-2036	НЗД, ДЗД НГА, ДГА НМХГ, НБОАЖГ	ГЗБГЗЗГ НИТХ, ДИТХ	1.Газрын эрх бүхий этгээдийн үүрэг, хариуцлага сайжирна. 2.Газрын маргаан багасна. 3.Газрын нөхөн олговорт олгох төсвийн зардал буурна.

		8.Газрын төлөв байдлын хянан баталгааны дүгнэлт зөвлөмжийг газрын гэрээнд тусгах, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлт 9.Гэрээний хэрэгжилтийг дүгнэх, үнэлэх, хариуцлага тооцох мэдээллийн сангийн үзүүлэлт, шалгуур				
Газрын тухай хууль.57.3.Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгнө. 57.4.Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна.	Газрыг хууль бусаар дун мэдэн эзэмшилдээ авахыг завдсан, авсан, барилга байгууламж барихыг завдах, барьсан , бусад хэлбэрээр ашигласан этгээдэд хүлээлгэх хариуцлагын үндэслэл, тооцооллыг гаргах журам, заавар, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх .	1.Хууль бус үйлдлийг илрүүлэх, мэдээлэх, бүртгэх сүлжээ, шуурхай байдлыг хангахад тавигдах шаардлага, шалгуур 2.Хууль бус үйлдлээс үүдэлтэй хөрш газар ашиглагчдад учруулсан эдийн болон эдийн бус, шууд болон шууд бус хохирол, үр дагавар тооцох шалгуур 3.Хууль бусаар эрх мэдэл, эзэмшилдээ авсан газарт эд хөрөнгийн агуулгаар кадастр хийж зэргэлдээ орших нэгж талбарын зах зээлийн үнээр үнэлж, газар,хөрс, ус, ургамал биологийн төрөл зүйлд учруулсан хохирол бүрээр тооцож төлбөр тогтоох шалгуур	2022-2036	НЗД, ДЗД НГА, ДГА НМХГ, НБОАЖГ	ГЗБГЗЗГ НИТХ, ДИТХ	1.Хууль бусаар газрыг мэдэлдээ авах хэрэг, зөрчил буурна. 2.Маргааныг шийдвэрлэх, хохирол тооцох нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.
Газрын тухай хууль.23.2.12.газар зохион байгуулалтын талаарх мэргэжлийн боловсон хүчний бодлогыг эрхлэх, газар зохион байгуулалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;	1.ГЗБ, кадастрын чиглэлээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх 2.Газрын цахим засаглалыг хэрэгжүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	1.Ажилтны мэргэжлийн ур чадвар, ёс зүйн шалгуур үзүүлэлтийг тогтоох, дүгнэх цахим систем бүрдүүлэх 2. Ажлын шаардлага, хөдөлмөрийн бүтээмжид нийцсэн техникийн үзүүлэлт, тоо хэмжээ	2022-2036 он	НЗД, ДЗД НГА, ДГА		Ухаалаг газрын харилцаа, ГЗБ-г хэрэгжүүлэх хүний болон техникийн чадавх бүрдэнэ.

1.7.2. Нийслэлийн ГЗБЕТ-ний газрын нийгэм-экологийн бодлого төлөвлөлт

Хүснэгт 9. Нийслэлийн ГЗБЕТ-ний суурьшлын бүсийн газрын нийгэм-экологийн бодлогын шийдэл

№	Шийдлийн хууль, эрх зүйн үндэслэл	Газрын бодлого төлөвлөлт	ГЗБЕТ-ний арга хэмжээний шийдэл	Хүрэх үр дүн, ач холбогдол
.	<p>Үндсэн хууль.16 дугаар зүйл. 2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; Газрын тухай хууль 9.1.10.газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах газрыг тогтоох болон нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх асуудлыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх;</p> <p>Газрын тухай хууль, 35.1.3.газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх; 35.3.2.газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх; Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 4 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах талаарх иргэний эрх, үүрэг 3/байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх. 17 дугаар зүйл.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх 4/нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн</p>	<p>1.Хэт төвлөрлийг сааруулах, газрын даац, экологийн тэнцвэрийг хангах хүрээнд УБ хотод өөр ангиллын газраас хот, тосгон, бусад суурины ангилалд шилжүүлж, УБ хотын суурьшлын бүс, гэр хорооллын газрыг тэлж өргөжүүлэхийг хориглох. 2. гэр бүлийн хэрэгцээний газрыг үе шаттайгаар инженерийн шугам сүлжээнд холбох, бие даасан цэвэрлэх байгууламж бүхий газар, зуслангийн бүс газарт хувааж газар ашиглалтын горим дэглэм тогтоох</p>	<p>УБ хотын 6 дүүрэгт суурьшлын бүсийг үргэлжлүүлэн тэлэх, гэр бүлийн хэрэгцээний газар олгохыг нийслэлийн ГЗБЕТ, УБ хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө батлагдах хүртэл хориглож, нийслэлийн алслагдсан дүүргүүдэд газар олгох суурьшлын бүсийг хэмжээг нэмэгдүүлнэ. УБ хотын хот, тосгон бусад суурины ангиллыг газрын хил заагийг одоогийн үүссэн газрын эрх, суурьшлаар тогтоож, эргэлтийн цэгүүдийг тэмдэгжүүлнэ. /Зуслангийн газар орно./ 2.УБ хотын 6 дүүрэгт</p>	<p>1. УБ хотын газар нутгийн онцлог, экологийн даац, чадавхад нийцсэн эрүүл аюулгүй орчин бүрдэж зардал, эрсдэл багатай, тогтвортой, ногоон хөгжилд хүрэх газрын орон зайн нөхцөл бүрдэнэ. 2.Ландшафт-экологийн нөхцөлд нийцсэн газар ашиглалт, газрын ангилал, зориулалтын эрхээр газрын экологийн аюулгүй, эрсдэлгүй байдлыг хангах, газрын нэгдмэл сангийн удирдлага, төлөвлөлт хэрэгжих боломж бүрдэнэ. 3.Нийслэлийн хөгжлийн төлөвлөлт, санхүүжилтийг эхний ээлжид экологийн асуудлыг шийдэх суурь шийдэл болох инженерийн байгууламж, шугам сүлжээгээр гэр хорооллыг хангахад зарцуулдаг болсон байна.</p>
		<p>2.Экологийн эрсдэлийг бууруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх хүрээнд гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж инженерийн шугам сүлжээгээр хангаж хувийн эдлэн газар бүхий хорооллын зохион байгуулалтад шилжүүлэх</p>	<p>1.Эмх замбараагүй гэр хорооллын нутаг дэвсгэрийн хуваарийг тэгш өнцөгт хороолол, хорооллыг дотор нь блокийн зохион байгуулалт шилжүүлж төлөвлөв</p>	<p>1.Газрын эрх бүхий этгээдийн үүрэг хариуцлага дээшилнэ. 2.Гэр хорооллын газрын эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл сайжирна. 3.Агаар, хөрс, усны бохирдол эрс багасна. 4. Орчны доройтлоос шалтгаантай өвчлөлийн тоо буурна.</p>
		<p>3. Экологийн эрсдэлийг бууруулах,</p>	<p>1.Гэр хорооллын газрыг инженерийн шугам сүлжээнд</p>	<p>1.ИТХ, Засаг даргын экологийн бодлого, хууль тогтоомжийн</p>

	<p>төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p>	<p>амьдралын чанарыг дээшлүүлэх гэр хорооллын газрыг дахин төлөвлөж нийтийн орон сууцны хорооллын газарт шилжүүлэх</p>	<p>хамрагдах тохиромжтой байдлаар нь хил зааг тогтоон, хаус, хороолол, дахин төлөвлөсөн нийтийн орон сууцны хороололд хуваан төлөвлөв. 2.Гэр хорооллыг шинэчлэн шинэчлэн зохион байгуулахад хороолол хоорондын зам, шугам сүлжээний газрын төлөвлөлтөд өртөх нэгж талбарын газар 3.Гэр хорооллын газрын дахин төлөвлөлт, шинэчлэн зохион байгуулалтын төслийн ТЭЗҮ-ийг өмнөх төслийн ГЗБ-ын ажлын зураг төслөөр хэрэгжүүлдэг тогтолцоонд шилжинэ.</p>	<p>талаар хэрэгжүүлэх ажил, газар ашиглагч нарт хүлээлгэх хариуцлага, гэрээний нөхцөл сайжирна. 2.Гэр хороололд амьдарч буй иргэдийн амьдралын чанар, нөхцөл эрс сайжирна. 3.Нийслэлийн гэр хорооллын газрыг эргүүлэн авах нөхцөл үүсэхгүй тогтвортой газар ашиглалтад суурилсан тогтвортой хөгжил бий болно. 4.Газар зохион байгуулалтын ажлын зураг төсөл хэрэгжсэнээр газрын маргаан үүсэх, олон жил үргэлжлэх, төсөл сунжрах, салбар хоорондын маргаан үүсэх зэрэг сөрөг үр дагаврууд арилна.</p>
		<p>4.Гэр суурьшлын бүсийн газарт учруулсан хохирлын болон экологийн нөхөн төлбөр ногдуулж дахин төлөвлөлт, газрыг шинэчлэн зохион байгуулалтын хөшүүрэг, арга хэрэгслийг нэвтрүүлэх</p>	<p>Гэр хорооллыг тохижуулан төлөвлөхдөө газрын экологи-эдийн засгийн үнэлгээ, төлбөр, нөхөн төлбөрийн агуулга чиглэлийг боловсруулав.</p>	<p>1.Гэр хорооллын газарт газар шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөлтөд оролцоогүй, газар чөлөөлөөгүй нэгж талбарын эрх бүхий этгээд газарт учруулсан хохирол, экологийн нөхөн төлбөр төлөх, инженерийн дэд бүтцээр хангуулах эрх үүсэхгүй байх тогтолцоо бүрдэнэ.</p>
	<p>35 дугаар зүйл.Газар эзэмшигчийн эрх, үүрэг 35.1.2. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах; 38 дугаар зүйл. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 38.2.2.эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тухай нотолгоо;</p>	<p>Газрын зах зээл, хэлцэлд газрын экологийн нөхцөл байдлыг тооцох бүрдүүлэх</p>	<p>Газрын үнэлгээнд хянан баталгааны үзүүлэлт, зөвлөмж, үүрэг зорилгын механизмыг нарийвчлан тооцох үндэслэлийг тодорхойлж төлөвлөв.</p>	<p>1.Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын чанар, гүйцэтгэгч байгууллагын үүрэг хариуцлага эрс сайжирна. 2.Газрын зах зээл, хэлцэлд экологийн шалгуур голлох хүчин зүйл болно. 3.Нийгэмд экологийн аюулгүй орчинд амьдрах дадал заншил, нэр хүнд төлөвшинэ.</p>

1.7.3. Нийслэлийн ГЗБЕТ-ний газар ашиглалтын экологи-эдийн засгийн бодлого төлөвлөлтийн шийдэл

Одоогийн бүрэлдэн бий бодсон газар ашиглалтын ангилал зориулалтын бүтэц нь орон зай, цаг хугацааны, эдийн засгийн, экологи, түүхэн үйл явдлыг илэрхийлж байдаг. Газрын экологи-эдийн засгийн үнэлгээг хийхдээ байгалийн нөөцийн чадавхыг тооцооноор үр дүнтэй, экологийн аюулгүй, шинжлэх ухааны үндэслэлтэй газар ашиглалтын загварыг гаргах боломжтой болно.

Хүснэгт 10. Нийслэлийн ГЗБЕТ-ний газар ашиглалтын экологи-эдийн засгийн бодлогын шийдэл

№	Шийдлийн хууль, эрх зүйн үндэслэл	Газрын бодлого төлөвлөлт	ГЗБЕТ-ний арга хэмжээний шийдэл	Хүрэх үр дүн, ач холбогдол
	<p>Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. 3 дугаар зүйл. Нийслэл, түүний чиг үүрэг</p> <p>4. Нийслэл нь эдийн засгийн дэд бүтцийг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын хэт төвлөрөл болон хотын хангамж, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах, оршин суугчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчны зохистой харьцааг хадгалах үүднээс дагуул хот /алслагдсан дүүрэг, хаяа хот, тосгон/-той байж болно.</p> <p>6. Нийслэл нь нутаг дэвсгэртээ байгаа төрийн дээд, төв болон бусад байгууллагын ажиллах хэвийн нөхцөлийг хангах үүрэг хүлээнэ.</p>	<p>1.Нийслэл УБ хотын нийгэм, эдийн засгийн төрөлжилтийг хуульд заасан нийслэлийн чиг үүрэгтэй нийцүүлэх, УБ хотын байгаль орчин, экологийн доройтлыг бууруулахад газар ашиглалтыг өөрчлөх, газрын эрхийг, аж ахуйн үйл ажиллагаатай уялдуулан газрын бодлогоор зохицуулах</p> <p>2.Агаарын бохирдол, замын түгжрэлийг бууруулах хүрээнд иргэдийн зорчих, үйлчлүүлэх хөдөлгөөний орон зайг газрын бодлого, төлөвлөлтөөр богиносгох, ойртуулах</p>	<p>Улсын нийслэлийн чиг үүрэгтэй нийцэхгүй болон байгаль орчныг доройтуулж, экологид эрсдэл үүсгэж буй болон цаашид эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж буй газрын эрх бүхий аж ахуйн нэгжийн газар ашиглалтын зориулалт, төрлийг өөрчлөх, өөр байршилд шилжүүлэх, алслагдсан дүүрэг, эдийн засгийн өөр бүсэд шилжүүлэхээр төлөвлөв.</p> <p>2.Нийгмийн болон инженерийн дэд бүтцийн сүлжээг гэр хороололд ойртуулж, хүргэж оновчтой байршуулах газрын схемийг боловсруулав.. /Хот, суурины ангиллын газрын төлөвлөлтөд дэлгэрэнгүй тусгав/</p>	<p>УБ хотын хэт төвлөрөл буурснаар дараах үр дүн, ач холбогдол гарна.</p> <p>1.Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах суурь нөхцөл бүрдэнэ.</p> <p>2.УБ хотын агаар, хөрс, усыг бохирдлын эх үүсвэрийн тоо багасаж экологийн доройтол тогтвортойгоор үлэмж багасна..</p> <p>3.Үйлдвэр аж ахуйн байгууллагууд өөр байршилд шилжсэнээр иргэдэд эрүүл аюулгүй орчинд шилжин суурьших нөхцөл бүрдэнэ.</p> <p>4.Иргэд шилжсэнээр машины тоо буурч замын түгжрэлд эерэг нөлөө үзүүлнэ.</p>

1.8. НИЙСЛЭЛИЙН ГЗБЕТ-ЫГ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛТАЙ УЯЛДУУЛСАН БОДЛОГО, ШИЙДЭЛ

1.8.1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийслэлийн ГЗБЕТ-г уялдуулах үндэслэл, агуулга, хандлага, бодлого төлөвлөлт шийдэл

Үндсэн агуулга: НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ БОЛ ТУСГААРЛАГДСАН АРАЛ БИШ, УЛСЫН НИЙСЛЭЛ, НЭЭЛТТЭЙ ТҮНШЛЭГЧ ХОТ ЮМ.

1.8.1.1. Нийслэлийн ГЗБЕТ-г бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн үндэслэл.

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль

10 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах

1. Нийслэлийн удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлагатай нийслэлийн эдийн засаг, нийгэм, соёлын талаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлага нийслэлийн хүн амыг хүнс болон шаардагдах бусад зүйлээр хангах, нийслэлд улсын баяр наадам, төрийн ёслолын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлж, үүрэг хүлээнэ.

3. Нийслэлийн хөгжил, хүн амын хангамж, нийгэм, эдийн засгийн үндэс болох үйлдвэр, аж ахуй, хангалтын зориулалттай бааз газрыг Засгийн газрын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэр дээр байгуулж, гэрээний үндсэн дээр ашиглаж болно.

4. Нийслэл, аймаг, бусад хотын хоорондын эдийн засаг, нийгэм, аж ахуйн харилцааг хуулиар тусгайлан зохицуулна.

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

73 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын харилцаа

73.1. Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор нэгж хоорондоо дараах хэлбэрээр харилцана:

73.1.1. бодлого, үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох;

73.1.2. нийтийн эрх зүйн гэрээ байгуулах;

73.1.3. харилцан туслалцаа үзүүлэх;

73.1.4. бүсчилсэн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;

73.1.5. харилцан туршлага солилцох;

73.1.6. хууль тогтоомжид заасан бусад хэлбэрээр харилцах;

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулах хэрэгцээ, шаардлага.

“Алсын хараа-2050”

Бүс нутгийн хамтын ажиллагаа

2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Орчин төвтэй шийдэл.

7. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно.

Нийслэл болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн кластер үүсгэх гол тодорхойлогч хүчин зүйл, үндэслэл нь нийслэлийн болон Төв аймгийн сумуудын газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, түүнд нийцүүлсэн газар ашиглалтын зориулалт, төрөл, аж ахуйн чиглэл, эдийн засгийн төрөлжилтийг тогтоон төлөвлөв. Энэ нь Нийслэл болон Төв аймгийн ГЗБЕТ, Зуун мод, Аэросити, Майдар, Налайх хот, Багахангай хот, Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хил залгаа сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, эдгээрийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харилцан уялдаатай, хамтын ажиллагааг дэмжих байдлаар төлөвлөх шаардлагыг үүсгэж байна. Энэ өмнө боловсруулсан дээрх төлөвлөгөөнүүдэд зарим нэмэлт өөрчлөлт хийх шаардлагыг үүсгэж байна.

1.8.1.2. Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн онол-арга зүйн үндэслэлийг тодорхойлсон байдал

Монгол улсын түүхийн бүхий л үед бүсчлэлийн асуудал тодорхой хэмжээгээр тавигдаж ирсэн.

Түүхийн үүднээс үзвэл монголчууд байгаль, газар зүйн өвөрмөц орчиндоо зохицон амьдарч, хөгжихийн тулд нутаг дэвсгэрээ 3-5 том аймагт ангилан зохион байгуулж ирсэн байна. Манай эрдэмтэн судлаачид нутаг дэвсгэрийн эдийн засаг нийгмийн орон зайн байгуулалтыг судлахдаа бүс, бүс нутаг муж, район зэрэг олон нэр томъёог хэрэглэж иржээ.

Б.Гунгаадаш эрдэмтэн бичихдээ “Нийгэм-эдийн засгийн газар зүйн ухааны судлах зүйл нь дэлхийн бөмбөрцгийн газар зүйн бүрхүүлийн аж ахуйн орон зайн бүтэц, нийгмийн амьдралын зохион байгуулалтын хэлбэрийг нийгэм, эдийн засгийн газар зүйн ухаан судалгаа явуулахдаа шинжилнэ” гэжээ. Цаашилбал эдийн засгийн муж хэмээх ойлголтыг “...үйлдвэрлэлийн ямар нэгэн чиглэлээр төрөлжиж, улмаар нийгмийн хөдөлмөрийн хуваарийн дагуу бусад хэсэгтэйгээ нягт холбогдсон улс ардын аж ахуйн нутаг дэвсгэрийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг” гэж тодорхойлсон байна. Уг тодорхойлолтоос үзэхэд эдийн засгийн муж нь нутаг дэвсгэрийн эдийн засгийн хэлхээ холбоог харуулсан ухагдахуун болох нь тодорхой байна.

Академич Т.Намжим эдийн засгийн бүс, үйлдвэрлэл – нутаг дэвсгэрийн цогцолбор бүрэлдэн хөгжих явдал нь ерөнхийдөө гурван бүлэг хүчин зүйлээс хамаарна гэж үзсэн. Үүнд: байгалийн нөөц, нутаг орны байршил, зам харилцааны нөхцөл үйлдвэрлэх хүчний хөгжил багтана. Эдийн засгийн зохистой бүсчлэлийн ерөнхий шалгуур бол байгаль орчны аль болох тохиромжтой нөхцөл, хангалуун нөөцөд түшиглэн бүтээгдэхүүнийг хамгийн бага хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл - Тээвэрлэлт-борлуулалтын нийлмэл зардлын түвшнийг хангах явдал юм гэжээ.

Манай орны хувьд гадаад зах зээлтэй холбогдох боломж, босоо тэнхлэг бүхий бүсчлэлийг төлөвшүүлэх асуудал чухал шаардлагатай болсон юм. Өнөөгийн бүсчлэлийн бүдүүвч нь газарзүйн байрлалын хувьд гадаад зах зээлтэй холбогдох боломж сайтай юм.

Гадаад худалдаа болон бүс хоорондын ачаа тээвэрлэх нутаг дэвсгэрийн хүрээ нь Цагааннуур, Хандгайтын боомтоос тооцоход Говь-Алтай, Завханы зүүн хэсгийн сумууд, Улаанбаатар, Дарханаас баруун чиглэлд Баянхонгор хүртэл, Сүхбаатар боомтоос баруун хойд чиглэлд Мөрөн, Хатгал хүртэл, Эрээнцавын боомтоос Өндөрхаан хүртэлх зайд ашигтай гарч байна.

2001 онд УИХ-аас “Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг батлан гаргаж Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатарын гэсэн эдийн засгийн 5 бүс байхаар тогтоожээ. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дэвшүүлсэн үндсэн зорилгуудыг (2.1-р заалт) нэгтгэвэл:

1. Хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задлах
2. Хот, хөдөөгийн ялгаа, аймаг бүс нутаг хоорондын тэгш бус байдлыг багасгах
3. Үндэсний нийгэм, эдийн засгийн дэвшлийг түргэтгэх явдал гэж судлаачид үзсэн байна.

Дүгнэлт. 1. Гэвч 2001 онд УИХ-аас “Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг бүрэн сайн хэрэгжүүлж чадаагүйгээс УБ хотод хэт төвлөрөл үүсэж, бусад бүсүүдийн хооронд хөгжлийн ялгаа гарч, тэгш бус байдал нэмэгдсэн байна. УБ-ын хотын хэт төвлөрөл нь экологийн гамшиг бүхий байдлыг дагуулж хүний эрүүл аюулгүй орчин амьдрах эрх зөрчигдөх гол үндэслэл болж байна.

2. Нийслэл УБ хот нь ганцаараа түрүүлж хэт төвлөрлийг үүсгэн хөгжих бус, бусад эдийн засгийн бүсүүдтэйгээ хамтарч хөгжих хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд нутаг дэвсгэр, технологийн кластерийг үүсгэх шаардлагатай байна.

1.8.1.3. Нийслэлийн ГЗБЕТ-г бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай үялдуулсан бодлого, шийдэл

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бодитоор газар нутаг дээр нь хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл бол үйлдвэрлэл – нутаг дэвсгэрийн цогцолборыг газар нутгийн орон зайн болон үйлдвэрлэл-технологийн кластер үүсгэн байгуулах явдал юм. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд хэрэгжих үндэслэлтэй юм.

Хүн төрөлхтний 21-р зууны хөгжлийн үзэл баримтлал, хандлага бол глобалчлал буюу даяарчлал болж байна. Глобалчлал буюу даяарчлалаас ангид нэг ч улс орон, бүс нутаг, орон нутаг, хот, суурин эдийн засгийн эрчимтэй хөгжлийн замд гарах боломжгүй болж байна.

Глобалчлал буюу даяарчлалын үндсэн объект бол газар нутаг, хүн амын хөгжил, чадавх, хөрөнгө санхүүгийн нөөц, түүх, соёлын өв, байгалийн нөөц баялаг, технологи, хиймэл оюун ухаан, дэд бүтэц болж байна.

Улс хоорондын глобалчлал буюу даяарчлалын хамрах хүрээ нь нутаг дэвсгэр, орон зайн хувьд улс орон, бүс нутаг байдаг бол улс доторх “глобалчлал”-ын хамрах хүрээ нь нутаг дэвсгэрийн хөгжлийн боломж, хэрэгцээнд суурилсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлого болж байна.

Иймээс нийслэлчүүдийн сайн сайхан, аж жаргалтай амьдрах хүсэл мөрөөдөл нь бусад бүс нутгийн хөгжлөөс, бусад бүс нутгийн ард иргэдийн сайн сайхан, аж жаргалтай амьдрах хүсэл мөрөөдөл нь нийслэл Улаанбаатар хотын хөгжлөөс хамаарах харилцаа, харилцан үйлчлэл, таталцлын зүй тогтол болж байна.

Нийслэл УБ хот хөрш зэргэлдээ аймаг, сум, хот болон бусад эдийн засгийн бүсүүдтэй хамтарч нутаг дэвсгэрийн болон үйлдвэрлэл, технологийн кластер үүсгэн хөгжих асуудлыг нийслэлийн ГЗБЕТ-нд тусгаж хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж байна.

Нутаг дэвсгэрийн кластер үүсгэн хамтарч ажиллахад саад болж буй гол хүчин зүйл бол аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр өөр дотроо л хөгжих бодлого баримтлах, асуудлаа шийдвэрлүүлэхээр дээш шатны байгууллагад хандаж шийдүүлэх хандлага хэт давамгайлж ирснээр асуудал шийдэх удирдлагын хэт төвлөрлийг үүсгэж, хөрш аймаг, сум дүүрэгтэй хамтарч ажиллах санаачилга, хандлага сул байгаад оршиж байгаа юм. Эсвэл тухайн нутаг дэвсгэр, газар нутгийг өөрийн мэдэлд авах хандлага юм. Эдгээр нь асуудлыг шийдэх орчин үеийн хандлага, арга барил биш, шийдлийг удаашруулах, шийдвэрлээгүй асуудлыг хуримтлуулах гол үндэс болж байна. Гол бэрхшээл нь бие биеэсээ тусгаарлагдсан, нутгархах сэтгэл зүй, ойлголт, хандлага юм.

Зураг 6. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал



1.8.2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх стратеги, нутаг дэвсгэрийн болон үйлдвэрлэл технологийн кластерийн ГЗБЕТ, схем

Нийслэлийн ГЗБЕТ-ний хамтын ажиллагаа, түншлэлийн стратеги.

Нийслэлийн ГЗБЕТ-г Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан нийслэлийн ГЗБЕТ-ний газрын бодлого, стратегийг “хэт явцуу, бие дааж тусгаарлагдсан, уялдаа зохицуулалтын дэмжлэг багатай нутаг дэвсгэрийн хөгжлийн хандлага бүхий газар зохион байгуулалт, газар ашиглалтаас-хамтын ажиллагаа, түншлэл бүхий ашиг сонирхлыг дэмжсэн газрын бодлого төлөвлөлт, газар ашиглалтад шилжих” гэж тодорхойлж төлөвлөв.

Төвийн болон бусад бүсийн хөгжлийн хүрээнд хил залгаа, аймаг, сум болон зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр харилцан хамаарал бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот, тосгонтой хөгжлийн бодлого төлөвлөлтөө уялдуулж хамтарч ажиллана. Энэ хэрэгцээ шаардлагын үүднээс тус тусын нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын харилцаа, газар зохион байгуулалт, газар ашиглалтын бодлого төлөвлөлтөд өөрчлөлт оруулж хамтарч ажиллана.

1.8.3. Нутаг дэвсгэр, газар ашиглалтад суурилсан нутаг дэвсгэрийн болон үйлдвэрлэл-технологийн кластер үүсгэх шийдлийн үндсэн чиглэл.

1. Нийслэл, орон нутгийн нийгэм, эдийн засаг, аж ахуйн хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд нутгийн өөрөөр удирдах ёсны байгууллага, төр захиргаа болон аж ахуйн байгууллага хоорондын хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалт, хяналт, үйл ажиллагааны цахим систем бүхий түншлэлийн харилцаа тогтоох, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

2. Хамтын ажиллагаа, түншлэлийг газрын менежментийн бодлогоор дэмжих хүрээнд хөрөнгө оруулалт хийж газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, аймаг, нийслэл, хотын таван жилийн үндсэн чиглэл, хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын ерөнхий болон тухай жилийн төлөвлөгөө хоорондын бодлого, зохицуулалтын цахим систем бүхий газрын харилцааны мэдээлэл солилцоог хөгжүүлэх

3. Газар ашиглалтын тохиромжтой байдалд суурилан нийслэл УБ хотыг хүнсээр хангах чанар, стандартын шаардлага хангах импортыг орлох хүнсний экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түүхий эдийн эрэлт нийлүүлэлт, тээвэр логистикийн сүлжээ

4. Газар, байгалийн нөөцийн байршил, дэд бүтэц, уламжлалт мэдлэг туршлагад суурилсан жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түүхий эдийн нийлүүлэлт, борлуулалтын кластерийн сүлжээ, гэрээ хэлцэл байгуулах

5. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалт газрын аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагаа, мэдээллийн цахим сүлжээ байгуулж ажиллах.

Дээр дурдсан хамтын ажиллагаа, түншлэлийг харилцан ойлголцох, зөвшилцөх, уулзалт хэлэлцүүлэг, семинар, зөвлөгөөн хийх замаар хэрэгжүүлэх шаардлагатай/

Хүснэгт 11. Нийслэлийн ГЗБЕТ-г бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэх бодлого, шийдэл.

№	Үндэслэл	Хамтын ажиллагаа, түншлэл, нутаг дэвсгэрийн кластерийн бодлого	ГЗБЕТ-ний бодлого, шийдэл
	<p>Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 73 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын харилцаа</p> <p>73.1.1. бодлого, үйл ажиллагаагаа уялдуулах, мэдээлэл солилцох; Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. 2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлага нийслэлийн хүн амыг хүнс болон шаардагдах бусад зүйлээр хангах, нийслэлд улсын баяр наадам, төрийн ёслолын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлж, үүрэг хүлээнэ.</p>	<p>1. Газар байгалийн нөөцийн эдийн засгийн чадавх, нөөцөд нийцүүлэн эдийн засаг, үйлдвэрлэлийн салбарыг төрөлжүүлэх,</p> <p>2. Аймаг, Нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээ уялдуулж боловсруулах</p> <p>3. ГЗБ-ын төлөвлөгөөг уялдуулж боловсруулах</p>	<p>1. Нийслэлийн ГЗБЕТ-нд нийцүүлэн Төв аймгийн ГЗБЕТ-нд нэмэлт өөрчлөлт оруулах,</p> <p>2. Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад хамтран ажиллах</p> <p>3. Таталцал нөлөөллийн бүсийн аймаг сумдын хамруулсан бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичиг хамтран боловсруулж Засгийн газраар батлуулах</p>
	<p>Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 73 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын харилцаа</p> <p>73.1.2. нийтийн эрх зүйн гэрээ байгуулах;</p> <p>Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. 10 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй харилцах</p> <p>1. Нийслэлийн удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн удирдлагатай нийслэлийн эдийн засаг, нийгэм, соёлын талаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана.</p>	<p>1. Газар, байгалийн нөөцийг хамтарч ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар санамж бичиг, гэрээ байгуулж хамтарч ажиллах.</p>	<p>1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг уялдуулж хамтарч боловсруулах</p> <p>2. Газрын эрх олгох харилцан ашигтай шийдвэр гаргах</p> <p>3. Нийслэлийн иргэдэд газар өмчлүүлэх нөөц газрын байршил, хэмжээг жил бүр хамтарч шийдвэрлэх</p> <p>4. Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын ойт хээрийн бүсэд сүү, ногооны чиглэлээр, хуурай хээрийн бүсэд мах, мал бодох чиглэлээр ХАА-н кластерийг хөгжүүлэх</p>
	<p>Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 73.1.3. харилцан туслалцаа үзүүлэх;</p> <p>73.1.4. бүсчилсэн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх;</p> <p>Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. 3. Нийслэлийн хөгжил, хүн амын</p>	<p>1. Нийслэлийн иргэдийг хөдөө орон нутагт шилжин суурьших, хөдөөгийн иргэд, байгууллагыг УБ хот, дүүрэгт бүтээгдэхүүн борлуулах, нийлүүлэх асуудлыг газрын менежментийн бодлогоор дэмжих</p> <p>2. Нийслэл УБ хотод экологийн органик хүнс үйлдвэрлэх, нийлүүлэх,</p>	<p>1. Шилжин суурьших болон газар ашиглах харилцан ашигтай байх ГЗБ-ын төлөвлөгөө боловсруулах, нийгмийн үүрэг хариуцлагын газрын гэрээ хэлцэл хийх</p> <p>2. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх газар нутгийг ГАТБҮ-г үндэслэх, газрын эрүүл ахуй, ариун цэврийн шалгуурыг газрын төлөв байдал, чанарын</p>

<p>хангамж, нийгэм, эдийн засгийн үндэс болох үйлдвэр, аж ахуй, хангалтын зориулалттай бааз газрыг Засгийн газрын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэр дээр байгуулж, гэрээний үндсэн дээр ашиглаж болно. “Алсын хараа-2050”.Орчин төвтэй шийдэл. 7.Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно.</p>	<p>борлуулах бүсчилсэн хөгжлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх газар нутгийн байршлыг сонгох 3. Нийслэлийн хөгжил, хүн амын хангамж, нийгэм, эдийн засгийн үндэс болох үйлдвэр, аж ахуй, хангалтын зориулалттай өөх засаг захиргааны мэдлийн газрыг ашиглах харилцан ашигтай гэрээ байгуулах ГЗБ-ыг хэрэгжүүлэх 4. Уул уурхайгүй, экологийн эрсдэлгүй, эрүүл газар нутгийн шалгуурт нийцсэн газар нутгаас гарал үүслийн баталгаатай органик хүнс бэлтгэх гэрээ хэлцэл байгуулж ажиллана.</p>	<p>хянан баталгааны үзүүлэлтээр тогтоох 3. Нийслэл УБ хотод экологийн органик хүнс үйлдвэрлэх, нийлүүлэх, борлуулах бүсчилсэн хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар нутгийг ХАА-н газрын ГЗБЕТ-нд дэлгэрэнгүй тусгав. 4. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байгаль орчны үнэлгээ, гол, нуурын усны эрүүл ахуйн чанар, газар ашиглалтын зориулалт, төрөл зэрэг экологийн нөхцөл байдлын, судалгаа, үнэлгээ, шалгуур тогтоож шийдвэрлэж байхаар төлөвлөв. 5. Нийслэл УБ хотод экологийн органик хүнс үйлдвэрлэх, нийлүүлэх, борлуулах арга хэмжээнд газар зүйн тэмдэгт, стандартын шалгуур үзүүлэлтийг тогтоох байхаар төлөвлөв</p>
<p>Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 73 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын харилцаа 73.1.5.харилцан туршлага солилцох;</p>	<p>Хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд туршлага солилцох, нөхцөл байдалтай танилцах аяллыг зохион байгуулах</p>	<p>НГА, ДГА, БОАЖГ, ХХААГ Газар, байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хамтран ажиллах боломжийг судлах, гэрээ байгуулах үндэслэлийг тодорхойлох аяллыг хийж байхаар төлөвлөв.</p>

1.8.4. Нийслэлтэй эрчимтэй таталцал нөлөөллийн бүсэд үйлдвэрлэл-технологийн кластер үүсгэх шийдэл

Нийслэлтэй эрчимтэй таталцал нөлөөллийн бүсийн үнэлгээг Нийслэлээс алслагдсан зай, дэд бүтцийн хангамж, үйлдвэрлэлийн нөөц зэргийг үнэлэн олон хүчин зүйлийн үнэлгээний аргаар ГЗМС-н орон зайн үнэлгээний хэрэгслийг ашиглан тодорхойлов.


Хүснэгт 12. Нийслэлийн таталцал нөлөөллийн бүс дэх аймаг сумууд

Таталцал нөлөөллийн 1-р бүс	Таталцал нөлөөллийн 2-р бүс	Таталцал нөлөөллийн 3-р бүс	Таталцал нөлөөллийн 4-р бүс
<p>Төв аймгийн Зуунмод Сэргэлэн Эрдэнэ Баяндэлгэр Архуст Баян Алтанбулаг Аргалант Баянчандмань Борнуур</p>	<p>Төв аймгийн Мөнгөнморьт Баянцагаан Баянхангай Лүн Баянцогт Цээл Өндөрширээт Сэлэнгэ аймгийн Зүүнхараа Хөтөл</p>	<p>Төв аймгийн Заамар Эрдэнэсант Баян-Өнжүүл Баянжаргалан Сэлэнгэ аймгийн Ерөө Орхонтуул Хэнтий аймгийн Дэлгэрхаан Өмнөдэлгэр</p>	<p>Бусад аймаг сумд</p>

Батсүмбэр Жаргалант Сүмбэр	Орхон Сант Баруунбүрэн Жавхлант	Мөрөн Орхон Шарын гол
Сэлэнгэ аймгийн Баянгол	Хэнтий аймгийн Жаргалтхаан	Дундговь аймгийн Дэрэн Дэлгэрцогт
Хэнтий аймгийн Цэнхэрмандал	Дархан-Уул аймаг Дархан	Орхон аймаг Дорноговь аймгийн Даланжаргалан
	Говьсүмбэр аймаг	

Зураг 7. Нийслэлийн таталцал нөлөөллийн бүсийн үнэлгээний зураглал

НИЙСЛЭЛИЙН ТАТАЛЦАЛ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗУРАГ



Хүснэгт 13. Таталцал нөлөөллийн 1-р бүс дэх аймаг, сумдын үзүүлэлтүүд

Таталцал нөлөөллийн 1-р бүс дэх аймаг сум	Төв аймгийн												Сэлэнгэ аймгийн Баянгол	Хэнтий аймгийн Цэнхэрмандал	
	Зуунмод	Сэргэлэн	Эрдэнэ	Баяндэлгэр	Архуст	Баян	Алтанбулаг	Аргалант	Баянчандмань	Борнуур	Батсүмбэр	Жаргалант			Сүмбэр
Хүн ам:	16677	2013	3907	1564	1327	2305	3152	1529	4175	4902	6861	6568	1748	5567	2072
Өрхийн тоо:	4711	703	1191	588	406	621	961	471	1132	1397	1961	1798	529	1608	
Шилжин ирсэн:	843	137	101	108	63	59	151	85	105	108	234	87	40	233	
Шилжин явсан:														63	
15-с дээш насны хүн ам	11424	1428	2751	1137	902	1682	2258	1109	2886	3468	4670	4384	1199	2374	1499
Ажил эрхэлдэг:	6296	981	1531	802	552	909	1518	668	1591	1906	2538	2231	725	2270	1001
Ажил хайж байгаа:	151	21	12	26	27	70	28	30	95	62	25	95	35	104	50
Ажилгүй иргэд:	4977	426	1208	309	323	703	712	411	1200	1500	2107	2058	439	1532	448
Газар тариалан															
Тариалан эрхлэгч иргэн:															
Тариалан эрхлэгч ААН:															
Тариалангийн газар га:															
Тариалсан талбай га															
Үр тариа тариалсан				280	1105			5612	280	787		12665	2053	6186	
Төмс	17	3.7	2.9	32	9	0.4	15	15.3	452.3	827.2	331.3	8391.4	303.5	102	10
Хүнсний ногоо	9.7	14.7	11	26	37.7	0.1	31	25.4	126.2	402.7	196.6	281.6	69.2	92.3	10
Хураасан ургац:															
Үр тариа тн:				404.0	2050			2921	96.5	934		11756.4	2562	5425	
Төмс тн:	62	15.2	38.5	380.0	39.6	8.7	197	207.5	7128	9096	4354.3	122458.1	4100	1000	122.1
Хүнсний ногоо тн:	49.8	325.2	331.7	125.7	179.8	1.8	331.5	269.8	1248.6	5968.3	2703.7	1880	1012.3	763.7	4.5
Мал аж ахуй															
Бэлчээрийн талбай:															
Малчин өрх:	337	423	702	430	134	315	740	348	292	625	766	386	146	467	501
Малтай өрх:	600	469	923	509	262	405	875	374	601	838	1330	823	256	864	559
Малын тоо:															
Адуу:	10378	18293	17648	15465	5961	15660	24438	8101	5536	11427	9856	13007	3395	10886	19629
Үхэр:	6381	10166	24586	14396	4679	7475	20248	7810	9586	15721	25951	13856	4294	18951	20982
Тэмээ:	4	39	7	58	10	70	217	1	27	29	20	1			13
Хонь:	41801	86305	115023	113327	30462	84311	172126	46534	19686	45076	23256	82443	20002	81815	121751
Ямаа:	30477	53753	76470	69436	21014	47337	117649	32968	17109	40367	19772	66919	18912	57176	81220
Гахай	27		72				3	107	104	113	7	693		125	
Шувуу	3022		81	26	18			73	331041	32	990	1121	95	1330	
Үйлдвэрлэл эрхлэгч ААН-н тоо														88	52

Уул уурхай Ү/А эрхэлж байгаа	3					1	2		1	1				3	
Уул уурхай Ү/А явуулаагүй	9	4	1				1	1	2	1		1			
ХАА Ү/А эрхэлж байгаа	12	2	5	4	4		3	9	14	17	22	60	14	27	6
ХАА Ү/А явуулаагүй	50	13	10	2	6	4	10	10	41	35	29	51	23		
Боловсруулах үйлдвэр Ү/А эрхэлж байгаа	34	3	13	2			4	1	4	5	2	2	2	4	2
Боловсруулах үйлдвэр Ү/А явуулаагүй	41	2	5			3	3		3	5	9	3			
Бөөний болон жижиглэн худалдаа Ү/А эрхэлж байгаа	61	2	3	1	2	3	5	5	9	2	7	7		25	13
Бөөний болон жижиглэн худалдаа Ү/А явуулаагүй	122	1	1	1	1	4	3	4	9	3	13	8			
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа Ү/А эрхэлж байгаа	10	1							2	1	1	4		1	
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа Ү/А явуулаагүй	8					1			2		2	4			
Дэд бүтэц															
Төмөр зам	төлөв					+	+					+			+
Хатуу хучилттай авто зам /сумын төвөөс алслалт км/	+	6км	+	+	30км	+	+	+	+	+	+	+	+	+	+
Агаарын тээвэр	+	+													

Хүснэгт 14. Таталцал нөлөөллийн 2-р бүс дэх аймаг, сумдын үзүүлэлтүүд

Таталцал нөлөөллийн 1-р бүс дэх аймаг сум	Төв аймгийн							Сэлэнгэ аймгийн						Хэнтий аймгийн Жаргалтхаан	Дархан-Уул аймгийн		Говьсүмбэр аймаг
	Мөнгөнморьт	Баянцагаан	Баянхангай	Лүн	Баянцогт	Цээл	Өндөрширээт	Мандал	Сайхан	Орхон	Сант	Баруунбүрэн	Жавхланта		Дархан	Хонгор	
Хүн ам:	2211	1865	1367	2501	1691	1547	2062	27011	9302	2290	2104	3094	1970	2311	85303	5861	17928
Өрхийн тоо:	694	609	381	735	538	718	675	6944	2705	686	645	834	567		24305	1535	4979
